

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн ажиллах эрх зүйн орчин



Очирхүрээгийн Тунгалаг

“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
төлөөлөгчийн ажиллах эрх зүйн
орчин”

Агуулга:**хуудасны дугаар**

Өмнөх үг.....	5
1.Нутгийн өөрөө удирдах ёсны тухай онол, үүсэл, хөгжил	
1.1.Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх онол.....	7
1.2.Нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн шинж, чиг үүрэг.....	10
1.3.Монгол Улсад Хурлын байгууллагын үүсэж хөгжсөн түүхээс.....	14
1.4.Нутгийн удирдлагын байгууллагын хараат бус үйл ажиллагааны зарчмын хэрэгжилт.....	16
1.5.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан.....	21
1.6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай шинэ хуулийн онцлог.....	28
2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн талаарх эрх зүйн зохицуулалт	
2.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох.....	44
2.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ба ашиг сонирхлын зөрчил	49
2.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн эрх, үүргийн хэрэгжилт.....	55
2.3.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Хуралдаа ажиллах.....	57
2.3.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч тойрогтоо ажиллах.....	65
2.3.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөс Засаг даргатай харилцан ажиллах.....	69
3.Нутгийн өөрөө удирдах байгууллагаас бусад байгууллагатай харилцан ажиллах хэлбэрүүд:	
3.1.Хуульд заасан чиг, үүргийн хүрээнд.....	74
3.2.Дээд байгууллагаас шилжүүлсэн үүргийн хүрээнд.....	77
3.3.Гэрээ байгуулж ажиллах хэлбэр	78
3.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал -Засаг даргын харилцаа.....	79
4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналт:	
4.1. Хяналт, үнэлгээ.....	87
4.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналтын чиг үүрэг.....	100
4.3.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүний хэрэгжилтэд хяналт тавихад анхаарах зарим асуудлууд.....	106
4.4.Иргэдийн Нийтийн Хурлын ажлыг чанаржуулж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх нь:.....	111
5.Нутгийн удирдлага- Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөл.....	116
5.1.Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн эрх, үүрэг.....	116
5.2.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн хариуцан хамгаалах байгалийн нөөц.....	124
6.Ном зүй.....	132

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт №1. Гадаадын зарим оронд нутгийн өөрөө удирдах байгууллагыг хуулиар баталгаажуулсан байдал.....	16
Хүснэгт №2. Орон нутгийн сонгууль болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намын оролцоо.....	19
Хүснэгт №3. Нийслэлийн иргэдээс ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж байгаа хэлбэрүүд.....	23
Хүснэгт №4. Засаг захиргааны нэгжийг өөрчлөх, татан буулгах талаар хуульд орсон өөрчлөлт.....	30
Хүснэгт №5. ИТХ-ын хуралдаантай холбоотой асуудлууд.....	30
Хүснэгт №6. ИТХ-ын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох зохицуулалт.....	35
Хүснэгт №7. Засаг даргад хүлээлгэх хариуцлага.....	36
Хүснэгт №8. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал.....	37
Хүснэгт №9. Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт.....	41
Хүснэгт №10. Сумын төсвийн орлого.....	42
Хүснэгт №11. Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх хэлбэрүүд.....	44
Хүснэгт №12. Зарим орны орон нутгийн Хурлын төлөөлөгч сонгогдох хүн ам, төлөөлөгчийн тоо.....	45
Хүснэгт №13. ИТХ-ын төлөөлөгчийг сонгосон Монгол Улсын сонгуулийн тогтолцоо.....	47
Хүснэгт №14. ИТХ-ын төлөөлөгчийн бүрэлдэхүүний талаарх судалгаа.....	50
Хүснэгт №15. ИТХ-ын хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд.....	58
Хүснэгт №16. ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт.....	72
Хүснэгт №17. Хурлын үйл ажиллагааны зарим үзүүлэлт.....	85
Хүснэгт №18. Хяналт шинжилгээ, үнэлгээний харилцан бие биенээ нөхөх хэлбэр.....	88
Хүснэгт №19. Аймаг, Нийслэлийн Засаг даргаас биелэлтийг тооцох, үнэлгээ хийх баримт бичгүүд, тайлагнах хугацаа.....	93
Хүснэгт №20. Сум, дүүргийн Засаг даргаас биелэлтийг тооцох, үнэлгээ хийх баримт бичгүүд, тайлагнах хугацаа.....	95
Хүснэгт №21. Үнэлгээ хийсэн жишээ.....	98
Хүснэгт №22. Шалгуур үзүүлэлтийг үнэлэх хяналтын хуудасны загвар.....	99
Хүснэгт №23. Шалгуур үзүүлэлтийг шалгах хэрэгсэл	100

Товчилсон үгийн жагсаалт

- 1.ИТХ-иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- 2.НИТХ-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- 3.АИТХ-аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- 4.БИНХ-Багийн иргэдийн Нийтийн Хурал
- 5.ОНХС-Орон нутгийн хөгжлийн сан
- 6.ТӨОААН- төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж

Өмнөх үг

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр байгуулагдаж, тухайн нутгийн иргэдийн хууль ёсны нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, тэднийг төлөөлөн хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг байгууллага билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлд Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд байна¹ гэж заасан бөгөөд Хурлууд тухайн нэгжийн хөгжил, иргэдийн амьдралын асуудлыг шийдвэрлэх үүрэг хүлээж ажилладаг.

Тойргийнхоо иргэдийн итгэлийг хүлээж Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгч бүр орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтийг хянах, иргэдийнхээ ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахад оролцох үүрэгтэй хүний хувьд холбогдох хууль, тогтоомжийг судлах, шаардлагатай мэдээлэлтэй танилцах, сайн туршлагаас суралцах хэрэгцээ үүсдэг.

2020 оны орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох ээлжит сонгуулиар 21 аймгийн 771, нийслэлийн 45, 330 сумын 7062, 9 дүүргийн 291 мандатын төлөө аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 9 нам, 1 эвслээс болон бие даан нэр дэвшигчид, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 3 намын болон бие даан нэр дэвшигчид нийт 17149 хүн нэр дэвшин өрсөлдөж, нийт 8169 хүн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогджээ. Өмнөх жилүүдийн сонгуулийн дүнгээс харахад төлөөлөгчдийн 60 гаруй хувь нь шинээр сонгогддог

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлд 8000 гаруй хүн сонгогдож, Хурлын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах болно.

Шинээр сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хувьд эрх зүйн шинэ орчин үйлчилж байгаагаараа онцлог юм.

Нэгдүгээрт: Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орж нутгийн удирдлагын эрх хэмжээг илүү тодорхой болгож, зарим шинэ зохицуулалтуудыг бий болгосон.

Хоёрдугаарт: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөхөөр боллоо.

Гуравдугаарт: Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 сарын 13 өдрийн 52 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн Журам шинэчлэн батлах тухай 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлагдан хэрэгжиж байна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

Дээрх хуулиудыг дагалдан нутгийн удирдлагын эрх, үүргийг зохицуулж байгаа олон хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орох, шинээр боловсруулах шаардлагатай байгаагаас гадна одоогийн Хурлууд эрх зүйн шинэ орчинд зохицон ажиллах, өөрийн Хурлаас өмнө нь баталсан зарим шийдвэрээ мөн л шинэчлэх шаардлага үүсэж байгаа болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгуулагдснаас хойш 29 жил үйл ажиллагаагаа явуулж, тодорхой хэмжээгээр төлөвшиж байгаа боловч шинээр сонгогдсон төлөөлөгчдийг Хурлын ажилд түргэн суралцуулах, шинэ мэдлэг олгох зорилгоор холбогдох байгууллагуудаас тэдэнд зориулсан сургалт хийх, гарын авлагаар хангах ажлыг зохион байгуулдаг. Эрх зүйн шинэ орчинд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг ажиллахад нь туслах зорилгоор энэхүү товхимлоо бэлтгэснээ Танд толилуулж байна.

Гарын авлагыг хэвлэж, Та бүхэнд хүргэх боломжийг хангасан “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн багийн хамт олонд талархлаа илэрхийлье.

ooOoo

1.Нутгийн өөрөө удирдах ёсны тухай онол

1.1.Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх онол

Нутгийн өөрөө удирдах ёсны үүсэл хөгжлийг XVIII зууны сүүлч, XIX зууны эхэн үед эрдэмтэн Г.Штмпфл, Х.Шоллер нар Францын хувьсгалтайгаар холбон тухайн орон нутгийн бие даасан байдлыг төв засгийн газартай харьцаж байсан харилцаагаар тайлбарлаж байснаар эхэлсэн гэж үздэг.²

Нутгийн өөрөө удирдах ёсны тухай ойлголт эрх зүйн шинжлэх ухаанд 1850-иад оны үед Германы захиргааны эрх зүйн хууль, тогтоомжид “орон нутгийн засаг захиргааны удирдлага” гэсэн томъёоллоор бий болж 1808 онд нутгийн захиргааны шинэчлэл хийсэн үетэй холбон тайлбарладаг.

Харин эрдэмтэн Л.Велихов Нутгийн өөрөө удирдах ёсны тухай ойлголт XVIII зууны үед Англид анх бий болж, түүнээс XIX зууны дундуур Германд, дараа нь Орост нэвтэрсэн гэж тайлбарлажээ. Нутгийн өөрөө удирдах ёс үүсэн хөгжиж эхэлсэн нь хөрөнгөтний хувьсгал хийгдэж, феодалын нийгмээс аж үйлдвэржсэн, төвлөрсөн хөгжлийн зам руу шилжиж, хотууд бий болж, төв засгийн хяналтаас хамааралгүй, орон нутаг бие даан хөгжих нөхцөл бий болсонтой холбоотой гэж үздэг.

Одоог хүртэл нутгийн өөрөө удирдах ёсны талаар нэгдсэн нэг ойлголт бий болоогүй бөгөөд тэдгээрийн адил болон ялгаатай талын чиглэлээр хийгдсэн нарийвчилсан судалгаа байхгүй байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны талаар дараах 3 төрлийн онол байна.³ Үүнд:

- чөлөөт хүй элгэний онол
- нийгэм, аж ахуйн удирдлагын онол
- төрийн онол

Чөлөөт хүй элгэний онолын онцлог нь анхдагч нь хүй элгэн, хоёрдогч нь төр улс гэж үздэгт оршино. Нутгийн өөрийн удирдлагын байгууллагыг иргэд өөрсдөө сонгож байгуулна, хүй элгэн өөрийн асуудлаа өөрөө хэлэлцэж шийдвэрлэнэ, төр засгийн байгууллагаас тэдний дотоод хэрэгт оролцох эрхгүй, харин тэдгээрээс эрх мэдлээ хэтрүүлж байгаа эсэхэд хяналт тавина.⁴

Нийгэм, аж ахуйн удирдлагын онолын онцлог нь хүй элгэний болон төв засгийн газрын эрхийн асуудал чухал бус, харин тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн аж ахуйн үйл ажиллагаа чухал гэж үздэг.

Төрийн онолын онцлог нь хүй элгэн төв засгийн бодлогыг хэрэгжүүлэгч доод шатны байгууллага бөгөөд энэ нь тухайн орон нутагт амьдарч байгаа иргэд өөрийн засаг захиргааны нэгжийг хөгжүүлэх орон нутгийн сонирхлыг хэрэгжүүлэгч байна.

²“Децентрализация государственной власти и местное самоуправление: проблемы реализации” Москва издательство РАГС 2007

³ Хусейнов.Р.Р.“Выдвижение и регистрация кандидатов на выборах в органы местного самоуправления: Зарубежный опыт для России” Вестник РАГС

⁴ Я.Долгоржав “Нутгийн өөрөө удирдах ёсны хөгжил, туршлага, хандлага” УБ 2000 он

Дэлхийн олон орон дээрх онолуудыг өөр өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлж ирсэн бөгөөд аль аль нь эерэг бөгөөд сөрөг талуудыг агуулдаг байна. Нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын нийтлэг дүр төрх нь төв засгийн газрын шийдвэрийг тухайн нэгждээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг, дээрээс өгөх үүрэг даалгаврыг хүлээсэн шинжтэй, эдийн засаг, санхүүгийн хувьд хараат байдлаар ажиллаж иржээ.

Одоогийн байдлаар улс төр, нийгмийн хувьд тогтвортой улс орнуудад нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн онцлог тогтолцоог бий болгосон байна. Жишээ нь:

-харьцангуй бие даасан тогтолцоо бөгөөд нутгийн удирдлагын байгууллага болон албан тушаалтнууд нь шууд сонгуулиар эрх мэдлээ авч хэрэгжүүлдэг тогтолцоо;

-орон нутгийн иргэдийн өмнөөс төлөөлөн сонгогдсон байгууллага, албан тушаалтнууд нь ажилладаг тогтолцоо;

-нутгийн удирдлагын байгууллага нь харилцан хамааралгүй боловч төв засгийн газраас тусгайлан байгуулсан байгууллага тэдгээрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавьдаг тогтолцоо.

Олон төрлийн эрх мэдэл бүхий нутгийн өөрөө удирдах байгууллагууд ажиллаж байгаа боловч гол цөм нь төр, засгийн бодлогыг орон нутгийн ашиг сонирхолтой зөв хослуулахад л оршдог байна.

Дээрх хэлбэрийн байгууллагуудад адил болон ялгаатай зүйл байдаг боловч орон нутгийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаагийн хувьд, төв Засгийн газар болон бусад байгууллагуудтай харилцах харилцаанд нийтлэг адил тал байдаг, харин Засгийн газрын зүгээс тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг нь адил бөгөөд энэ нь төв засгийн газар, орон нутгийн удирдлагын нэгдмэл харилцааг тодорхойлж байдгаараа онцлогтой юм.

Одоогийн байдлаар нутгийн өөрөө удирдах ёсны 3 загвар үйлчилж байна.⁵ Үүнд:

·**Хамтын ажиллагааны загвар:** Энэ нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нэгэн зорилгын үндсэн дээр орон нутгийн болон төв засгийн газрын хоорондын харилцаа адил түвшинд хэрэгжинэ. Энэ загвар АНУ, Швейцари, Голланд зэрэг улсуудад хэрэгжиж байгаа бөгөөд орон нутгийн иргэд өөрийн асуудлыг доороос тавьж шийдвэрлүүлдэгээрээ онцлогтой.

·**Агентын буюу төлөөллийн загвар:** Энэ загварын онцлог нь төв засгийн газарт эрх мэдэл төвлөрнө. Орон нутгийн байгууллага нь төв засгийн газрын шийдвэрийг зохион байгуулагч, орон нутаг дахь төлөөлөл болж ажиллана. Нутгийн удирдлагын байгууллагууд төв засгийн шийдвэрийг нутгийн иргэдийн ашиг сонирхлыг үндэслэн хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газар ч орон нутгийн эрх мэдлийн баталгааг ханган ажиллана.

·**Харилцан ажиллах загвар:** Нэг талаас орон нутгийн удирдлагын харьцангуй бие даасан байдал, нөгөө талаас нутгийн удирдлагын байгууллага нь төрийн байгууллага

⁵"Децентрализация государственной власти и местное самоуправление: проблемы реализации"
Москва издательство РАГС 2007

гэдэг утгаараа төв засгийн газраас хамааралтай байх, энэ нь гол төлөв төсөв, санхүүгийн хамаарал байна.

Олон оронд нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх, үүргийг хуулиар тодорхойлсон байна. Энэ нь нутгийн удирдлагын байгууллагын дарга нарын үйл ажиллагаанд төрийн зүгээс болон ард иргэдийн зүгээс тавих хяналт, шалгалт хийх асуудлыг хуульчилж өгсөн байдлаар илэрдэг. Орон нутгийн удирдлагад хариуцлага хүлээлгэдэг хэд хэдэн хэлбэр байна. Жишээ нь: нутгийн удирдлагын байгууллагыг татан буулгаж, үүргийг төв засгийн байгууллагад шилжүүлэх, орон нутгийн засаг захиргааны байгууллагад ажиллагсдыг ажлаас нь чөлөөлөх, орон тоог цөөлөх, санхүүжилтыг зогсоох зэрэг санкцийг хэрэглэхээр Герман, Франц, Япон, Португаль, Унгар, Энэтхэг улсын хуулиудад тусгагджээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг ерөнхийд нь анхдагч буюу хоёрдогч гэж ангилдаг.

Анхдагч гэдэг нь: орон нутгийн хэмжээнд өөрсдөө асуудлаа шийдвэрлэдэг эрх хэмжээ хамаарна. Үүнд: гудамжны цэвэрлэгээ, байшин, хашаа, гудамжны зөв зохион байгуулалт, барилгажилт, хаягжилт, парк, амралтын бүсийн тохижилт, ерөнхий боловсролын сургууль, дүүргийн хэмжээний эрүүл мэндийн асуудал, орон гэргүй, ядуу амьдралтай хүмүүсийн асуудлыг шийдвэрлэх гэх мэт.

Хоёрдогч гэдэг нь: энэ нь гол төлөв дээд шатны байгууллагын шийдвэрээр хийгдэж байгаа ажил хамаардаг. Үүнд: бүх нийтийн санал асуулга явуулах бэлтгэлийг хангах, сонгуулийн компанит ажил, сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, сонгуулийн санал авах ажлыг зохион байгуулах, цэрэг татлага, онцгой байдлын шугамаар хийгддэг вакцинжуулалт зэргийг нэрлэж болно.

1.2.Нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн шинж

Дэлхийн улс орнуудад нутгийн удирдлагын байгууллага нь эрх мэдлийн хуваарилалтаасаа хамаараад тогтсон хэдэн загвар байдаг. Үүнд:

Англо-Саксоны загвар: Нутгийн өөрөө удирдах ёсны /бидний өнөөгийн хүрсэн түвшингийн/ хамгийн төгс загварт тооцогддог. Нутаг дэвгэр – засаг захиргааны нэгжийн удирдах байгууллагуудыг төв Засгийн газраас байгуулах буюу томилдоггүй, гагцхүү нутгийн өөрийн удирдлагын байгууллагаас сонгож аль болох томилгоот албан тушаалаас татгалздаг байна. Энд иргэдээс сонгосон төлөөллийн байгууллага нь нутгийн удирдлагын хүрээнд голлох байр суурьтай байдаг, өөрөөр хэлбэл "орон нутгийн ашиг сонирхлын хүрээнд хамаарах бүхий л эрх мэдлийг" нутгийн өөрөө удирдах байгууллагад өгдөг. Сонгуульт албан тушаалтнуудад хэн нэгэн дээд албан тушаалтнаас хараат бус байж зөвхөн өөрийн сонгогчдоос хамааралтай байх боломжоор хангагдсан гэж үздэг байна. /АНУ, Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд гэх мэт/

Францын буюу эх газрын загвар; Төлөөлөгчдийн байгууллагын сонголт, төвийн байгууллагын томилолт хослуулна. Энд иргэдээс байгуулсан төлөөллийн байгууллага нь захиргаагаа байгуулдаг ба төрийн төлөөлөгч нь нутгийн захиргааны байгууллагын тэргүүн байна. Энэ хэв маягт баримталдаг гол зарчим нь Хурал, захиргааны байгууллагын хоорондын харилцаа нь эрх мэдлийг хуваарилах замаар тэнцвэртэй үйл ажиллагаа

явуулах явдал юм. Монгол Улс энэ хэв маягийн өвөрмөц хэлбэр нь болно. /Франц, Итали, Бельги, Испани, Латин Америк ойрхи дорнодын зарим орнууд/

Холимог загвар; Дээрх хоёр загварын алинд ч багтахгүй бүс нутаг, үзэл суртал, улс төрийн дэглэмийн тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарсан "Зөвлөлийн хэлбэртэй нэгдмэл тогтолцоо", "Цэргийн эрхтний томилолтын байгууллага" зэрэг загварууд байдаг. Энд төрийн удирдлагын болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь нэгэн нэгдсэн институтэд багтсан байдаг. /ХБНГУ, Япон/

Мөн зарим судлаачид нутгийн удирдлагын **"Төвлөрсөн удирдлагын"** загвар байдаг тухай тэмдэглэсэн байдаг. Энэ нь хуучин социалист системийн орнуудад хамааралтай юм.⁶

Нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн шинж:

1.Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд орон нутгийн байгууллагууд асуудлаа биеэ дааж шийдвэрлэх эрхийг хэлнэ.

2.Орон нутгийн байгууллагууд өөрийн эрх мэдлийн хүрээнд ажиллахыг хэлнэ.

3.Ардчилсан зарчмын үндсэн дээр явагдсан сонгуулиар байгуулагдсан, хамт олон, сонгогчиддоо эргэн тайлагнах үүрэг бүхий цаг үеийн асуудлыг шийдвэрлэхийг хэлнэ.

4.Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нийгмийн төрөл бүрийн ашиг сонирхлыг нэгтгэсэн, харилцан зөвшилцсон, өөрийн бие даасан зорилготой, түүнийгээ хэрэгжүүлэх өөрийн удирдлагын бүтцийг хэлнэ.

5.Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хэтэрхий биеэ даасан байдалтай болвол нийгмийн хөгжлийн гажуудал, эмх замбараагүй байдлыг бий болгодог сөрөг талтай.

Нутгийн өөрөө удирдах эрх нь хот, суурин газруудад анх үүссэн бол нүүдэлчдийн хувьд албан бус хэлбэрээр буюу тайван амгалан амьдрах, аж ахуйгаа эрхлэн хөтлөх зорилгоор хамтран ажиллах, бусдад туслах, хамтран эзэмших эд баялаг (худаг, гарам, гүүр гэх мэт) бий болгох зэргээр хамтын зохион байгуулалтад орж, өөрсдийн эрх ашигт нийцүүлэн өөрсдийн хүчээр үйл хэргээ бүтээж байсан нь нутгийн өөрөө удирдах ёсны суурь эхлэл байв. Ураг төрлийн холбоонд үндэслэсэн амьдрал нь овог аймгийн хүрээнд тогтсон зан заншил, жаягаар зохицуулагдаж байснаа нийгмийн амьдрал нарийсаж, "Хэлэлцээрт төр" бий болсон нь иргэдийг төрийн "харьяалалд" оруулж, заавал сахиж мөрдөх хэм хэмжээг бий болгосон байна.

Харин орчин үед нутгийн өөрөө удирдах ёсыг дэлхий нийтээрээ төв, орон нутгийн харилцааны нийтлэг хэм хэмжээ хэмээн хүлээн зөвшөөрч, олон оронд Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах ёсыг баталгаажуулан амьдралд хэрэгжүүлэх болжээ. Олон улсын түвшинд нутгийн өөрөө удирдах ёсыг хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн нэг баримт бичиг бол 1985 онд Европын зөвлөлөөс эрхлэн гаргасан "Нутгийн өөрөө удирдах ёсны тухай Европын Харти"⁷ юм. Европын Харти-д нэгдэн орохын тулд улс орон нь

⁶Децентрализация государственной власти и местное самоуправление: проблемы реализации" Москва издательство РАГС 2007

⁷ Орон нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Харти 1985 он

дотоодын хууль тогтоомжийг энэхүү Хартид нийцүүлэх үүрэг хүлээж, үндэсний парламентаар хэлэлцүүлэн баталдаг.

“Европын Харти”-д нутгийн удирдлагын эрх, үүргийг тогтоохдоо үндэслэх ерөнхий зарчмуудыг зааж өгсөн байна.Үүнд:

·Орон нутгийн захиргааны үндсэн эрх, үүргийг Үндсэн хууль эсвэл бусад хуулиар тогтоох;

·Төрийн чиг үүргийг хуваарилахдаа аль болох иргэдэд хамгийн ойр дөт захиргааны түвшинд тухайн чиг үүргийг ногдуулж байх (нийцүүлэх зарчим)

·Чиг үүрэг, хариуцлагын аливаа давхардал, тодорхой бус байдлаас зайлсхийх үүднээс орон нутгийн захиргаанд олгож байгаа эрх мэдэл нь аль болох бүрэн, тусгай байх;

·Төв засгийн газар, эсвэл бүсийн захиргаад орон нутгийн захиргаадад эрхээ шилжүүлсэн тохиолдолд тэд энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ боломжийнхоо хэрээр орон нутгийн нөхцөлд тохируулан өөрчлөлт хийх бололцоогоор хангагдсан байна гэжээ.

Өөрийн удирдлага, нутаг дэвсгэр бүхий коммунаас /хүй элгэн/ өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх бодит, эрх чадвар юм. /Нутгийн өөрийн удирдлагын Европын харти 1,3-р зүйл/

Орон нутаг бүр өөр өөрийн онцлогтой тэгэхээр өөр өөрийн онцлог хэв шинжид тохирсон ашиг сонирхол, эрх ашиг үйлчилдэг нь харагдаж болно. “Засаглал нь ард түмэнд хамгийн ойр, дөт баймааж ардчилсан гэгддэг”

Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимид орон нутгийн удирдлагын талаар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тайлбарласан байдаг. Тэрээр “Өөрөө удирдах ёс гэж тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил, хэргийг тэндэхийн иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэж эрхлэн хөтлөх, хариуцах ёсыг хэлнэ”⁸ гэжээ.

Аливаа төлөөллийн байгууллагын нэгэн адил нутгийн өөрөө удирдах байгууллага нь гурван чиг үүргийг хүлээдэг. Энэ нь төлөөлөх, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох, хянах чиг үүрэг бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны зарчмын үүднээс эдгээр чиг үүрэг нь өөр өөрийн онцлогийг агуулдаг байна.

Төлөөлөх чиг үүрэг: Тодорхой зорилго, чиглэлээр төлөөллөө сонгон илгээх, сонгогдсон төлөөлөгч сонгогчдоо төлөөлөн ажиллах нь төлөөллийн ардчиллын зарчим билээ. Гэхдээ төлөөллийн зорилго, чиглэлээс хамаарч уг төлөөллийн байгууллага нь сонгогчдынхоо нэг л шинжийг нь агуулж байх (өөрөөр хэлбэл төлөөлж байх)-ыг төлөөлөх чиг үүрэг гэх ажээ. Тэгвэл нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа иргэдийн төлөөллийг хангах чиг үүрэгтэй.

⁸ “Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал” товхимол II Улс төрийн боловсролын академи 2000 он

Төлөөлөх чиг үүрэг нь сонгуульд оролцох эрхээс эхлэх бөгөөд тухайн нутаг дэвсгэрт албан ёсны бүртгэлтэй, сонгуулийн насанд хүрсэн, Монгол Улсын иргэн саналаа өгөх эрхтэй байхаар (Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль⁹-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт) тогтоосон байна. Үүний зэрэгцээ сонгогдох төлөөлөгч нь тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч нь байхаар (Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт) тогтоожээ. Энэ нь тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч нь нутгийн иргэдийн язгуур эрх ашгийг илэрхийлэгч нь байна гэдгийг тодорхойлж буй хэрэг юм.

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох чиг үүрэг: Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ буюу тухайн нутгийнхаа иргэдийн амьдрал, хөгжлийн асуудлыг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд тэрхүү шийдвэр нь нутаг дэвсгэртээ засаглах, өөрөөр хэлбэл заавал биелүүлэх хүчин төгөлдөр байдаг. Энэхүү эрх нь нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогчдоос төлөөлүүлэн олгосон эрх бөгөөд өөрсдийгөө удирдах, өөрсдийг нь төлөөлөн шийдвэр гаргах эрхийг шилжүүлсэн гэсэн үг юм. Нутгийн иргэдийн язгуур эрх ашигт нийцүүлэн бие даан эрхээ хэрэгжүүлэх нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн чиг үүрэг.

Хуулийн хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан гаргах нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн үйл ажиллагаа билээ. Хурал нь өөрийн дотоод зохион байгуулалтын асуудлыг өөрөө тогтоох эрхтэй байдаг. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн хуралдааны дэгээ батлах, ажлын хороо байгуулах зэрэг дотоод зохион байгуулалтын асуудлыг бие даан шийдвэрлэдэг.

Хянах чиг үүрэг: Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засаг даргын үйл ажиллагааг чиглүүлж, явц, үр дүнд нь хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгөх үүргийг нутаг дэвсгэрийн хүн амын өмнөөс хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар:

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шийдвэрээ гаргаж, Засаг дарга түүнийг нь хэрэгжүүлнэ. Засаг дарга нь нутаг дэвсгэрийн хэмжээний амьдралын тодорхой асуудлыг санаачлан боловсруулж, Хуралд өргөн мэдүүлэн хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах ба хэрэгжилтэд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгнө.

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг даргын үйл ажиллагааны тайланг сонсож хэлэлцэх ба явц, үр дүнг нь үнэлж, үнэлэлт дүгнэлт өгнө.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд өмнөх сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжиж байсан, удаан хугацаанд мөрдөгдөхөөр батлагдсан бодлогын бичиг баримтууд, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үргэлжлүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж, засварлах, тухайн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогоо оновчтой тодорхойлох шаардлагатай юм.

⁹“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хууль Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2020 оны 8 дугаарт нийтлэгдсэн

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмыг мөрдөн ажиллах нь чухал байна. Хурлын хуралдаанаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэхдээ Засаг даргын Тамгын газраас түүнд хийсэн хяналт шинжилгээнд тулгуурлан хэлэлцэж үнэлгээ өгч байгаагаас гадна, зарим тохиолдолд улс төрийн намын шийдвэрээр Засаг даргын ажилд үнэлэлт өгч, ажлаас нь чөлөөлж байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэхэд хүрэх түвшинг тодорхой заагаагүй, тоон болон чанарын үзүүлэлтээр дүгнэх боломж хомс, үнэлэлт, дүгнэлт өгөх аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдөхгүй байгаа нь хүндрэл учруулдаг байна. Тиймээс Засаг даргын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тусгайлсан журам гаргаж мөрдөн ажиллах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Төсвийн төслийг боловсруулах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, Хурлын төлөөлөгчдийн өөрсдийн идэвх санаачлага өндөр байх шаардлагатай байна. Засаг даргаас боловсруулаад өргөн мэдүүлсэн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод, ялангуяа Төсөв, санхүүгийн хороо хуралдаанаас өмнө заавал хэлэлцэж, санал дүгнэлтээ боловсруулж хэвших нь чухал.

Төсвийн хэрэгжилтийн явцад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хороо хяналт тавих хэрэгтэй юм. Төсвийн хэрэгжилтийн талаар Засаг даргын мэдээллийг хэлэлцэх, төсвийн гүйцэтгэл, түүний дотор төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг сар, улирлаар нь судалж, шинжилгээ хийх, дүнг Хуралдаанаараа хэлэлцэж, шийдвэр гаргуулдаг байх шаардлагатай.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн идэвхтэй оролцоо дутагдаж байна. Баг, хорооны түвшинд орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалттай холбоотойгоор хийгддэг нээлттэй санал асуулгын ажилд Хурлын төлөөлөгчид оролцож, тухайн нэгжийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар тайлбарлан таниулах ажлыг хороо, багийн Засаг дарга, иргэдийн Нийтийн Хуралтай хамтран зохион байгуулах нь чухал байна.

Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хуулиудаас 30 гаруй хуульд нь тухайн шатны Засаг даргаас боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж батлуулах хөтөлбөр, төлөвлөгөөг нэр зааж хуульчилсан байдаг бөгөөд Хурал түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Хуулиар олгогдсон энэхүү бүрэн эрхээ Хурал, төлөөлөгчид тэр бүр хэрэгжүүлж ажиллахгүй байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ялангуяа сумын түвшинд хүний нөөцийн чадавх, хөрөнгө санхүүгийн боломжийн хувьд учир дутагдалтай байдаг. Хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байх нь эс үйлдэхүй болох бөгөөд тухайн үйл ажиллагаа эзэнгүй орхигдох сөрөг үр дагаврыг үүсгэж болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар орон нутгийн бие даасан байдлыг хангах, төсвийн болон өмчийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн тул хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр илүү санаачилга гарган ажиллах шаардлагатай юм. Ялангуяа сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Малын тоо, толгойн албан татварын тухай хууль шинээр батлагдлаа.

1.3. Монгол Улсад Хурлын байгууллага үүсэж хөгжсөн түүхээс

Ардын хувьсгал ялалт байгуулсныхаа дараа орон нутгийн засаг захиргааны байгууллагын хуучин тогтолцоог үндсээр нь халж, ардын төрийн орон нутгийн засаг захиргааны байгууллагын цоо шинэ системийг тогтоох явдлыг ойрын жилийнхээ гол зорилт болгон дэвшүүлжээ. Энэ зорилтоо биелүүлэхийн тулд эх орноо харийн түрэмгийлэгчдээс бүрэн чөлөөлөх, хар, шар феодалуудын улс төр, эдийн засгийн эрхийг эвдэн устгах, төрийн эрх барих орон нутгийн төлөөлөгчдийн болон тэдгээрийн гүйцэтгэн захирамжлах байгууллагыг байгуулах зэрэг харилцан уялдаа холбоо бүхий олон асуудлыг шийдвэрлэж эхэлсэн байна.

1923-аас 1925 онд “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”, “Их шавийн захиргааны дүрэм”, “Ховдын харъяат газрын захиргааны дүрэм”, “Дарьгангийн нутгийн захиргааны дүрэм”, “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж явах дүрэм”-ийг баталсан байна. Эдгээр дүрмийг үндэслэн Монгол оронд ардчилсан засаг захиргааны байгууллага байгуулах ажил 1923, 1924 онд амжилттай явагдаж, орон нутгийн засаг захиргааны хуваарьт үндэслэсэн арван гэр, баг, сум, хошуу, аймгаас ийнхүү хурал ба тэдгээрийн гүйцэтгэх байгууллагын нэгдмэл систем тогтжээ. Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь үйл ажиллагааныхаа ерөнхий зарчим, бүтэц, арга хэлбэрийн хувьд өөр хоорондоо ялгаатай байлаа.

БНМАУ-ын анхны /1924 оны/ Үндсэн хуульд засаг захиргааны байгууллагын дэд систем болох орон нутгийн Хурал, тэдгээрийн гүйцэтгэх байгууллагын ялгааг зааж “Орон нутгийн Хурал нь аливаа аж ахуй ба албаны хэсгүүдийг гүйцэтгэн явуулахаар өөрсдийн дундаас аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн аливаа хэрэг явдлыг гүйцэтгэх захиргааны газрыг сонгон байгуулвал зохино”...хэмээн тодорхойлжээ.¹⁰

Социализмын үеийн төрийн засаг, захиргааны байгууллагын хоорондын харьцааг тус улсын 1960 оны Үндсэн хуульд нарийвчлан тодорхойлсон байна. Үүнд: “Аймаг, сум, баг, Улаанбаатар хот хороо, хоринд төрийн эрх барих дээд байгууллагууд нь хөдөлмөрчдийн депутатуудын Хурал мөн. Аймаг, хот, сум, хорооны хурлуудыг тус тусын доод хурлуудаас сонгогдсон төлөөлөгчдөөр байгуулна. Улаанбаатар хотод 200 хүн ам тутмаас нэг төлөөлөгч, аймгуудад 400 хүн ам тутмаас нэг төлөөлөгчийг тус тус сонгоно. Баг ба хорьдын хурлууд нь баг, хорины бүх сонгуулийн эрх бүхий хүмүүсээс байгуулагдана. Аймгууд ба Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын тогтмол их хурлууд нь 3 жилд нэг удаа хуралдана. Сум, хороо, баг, хорины хөдөлмөрчдийн тайлан, илтгэлийн ба сонгуулийн тогтмол хурлууд нь жилд нэг удаа хуралдана.

Тогтмол бус Хурлуудыг аймаг, хот, сум, хороо, баг, хорьдын бүх сонгуулийн эрхтэй хүмүүсийн хагас хувиас доош бус буюу мөн хурлаар сонгогдсон засаг захиргааны байгууллагын гуравны хоёр хувиас доошгүй нь шаардах буюу мөн түүнчлэн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн даалгавраар зарлан хуралдуулна. Аймгууд ба Улаанбаатар хотын хурлуудын завсар цагт аймгууд ба Улаанбаатарт засаг захиргааны эрх барих дээд байгууллага нь аймгууд ба Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын их хурлуудаас 3 жилийн хугацаагаар 1000 хүн тутмаас нэг гишүүнээр сонгогдсон бага хурлууд болно.

¹⁰“Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” танилцуулга 2000 он

Аймгууд ба Улаанбаатар хотын бага хурлууд нь жилд 2 удаа хуралдана. Өдөр тутмын ажлыг явуулахын тулд аймгууд ба Улаанбаатар хотын бага хурлууд нь өөрийн гишүүдийн дотроос 7-13 хүртэл хүмүүсээр тэргүүлэгчдийг сонгох, Үүнд: дарга, орлогч дарга ба гишүүдээр тус тус бүрэлдүүлэн сонгоно. Аймгууд ба Улаанбаатар хотын бага хурлууд хийгээд тэдгээрийн тэргүүлэгчид аймаг, хотын захиргаад сум, хороодын захиргаад нь:

1.Өөрийн нутаг дэвсгэрийн соёл, боловсрол, улс төр, аж ахуйн байгууллагыг удирдах;

2.орон нутгийн төсөв батлах;

3.өөрийн харъяа засаг захиргааны байгууллагуудын ажил хэргийг удирдах;

4.улсын ёс журмыг хамгаалж, хуулийг сахиулах, ард иргэдийн эрхийг хамгаалах явдлыг хангах;

5.Засаг захиргааны эрх барих доод байгууллагуудын тогтоол, тушаал нь хэрэв БНМАУ-ын иргэдийн нийтээр дагаж мөрдүүлж байгаа хуулиудад харштай байвал хүчингүй болгоно...гэсэн байна.

Нийслэл хотын Хурал хувьсгалын үе шат бүрт 18 насанд хүрсэн иргэдээс сонгогддог төлөөллийн байгууллага байсаар ирсэн бөгөөд 1924 онд “Цаг зуурын Хурал нэртэйгээр 45 төлөөлөгчтэй байгуулагдаж байжээ. Дараа нь “Хотын Хурал”, 1948 оноос “Улаанбаатар хотын хөдөлмөрчин төлөөлөгчдийн Хурал, 1962 оноос Ардын депутатуудын Хурал, 1989 оноос “Улаанбаатар хотын Ардын Хурал”, 1992 оноос Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэртэйгээр ажиллаж байна. Хурлын төлөөлөгчдийн тоо 1924 онд 45, 1928 онд 251, 1952 онд 166, 1970-1989 онд 225, 1990 онд 150, 1992 онд 72, 1996 онд 40, 2008 оноос 45 болсон юм.¹¹

1989 онд Хурлын байгууллага гүйцэтгэх засаглалаасаа тусгаарлан, биеэ дааж үйл ажиллагаа явуулах болсон боловч, Хурлын Тэргүүлэгчдийн даргын үүргийг МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, дараа нь тухайн засаг захиргааны нэгжийн Гүйцэтгэх захиргааны дарга хавсран гүйцэтгэдэг байв. 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шинэчлэн байгуулагдаж, Хурлын Тэргүүлэгчдийн дарга орон тооны бусаар, 1996 оноос орон тоогоор ажиллах болсон түүхтэй.

1992 оны Үндсэн хуулиар ардчиллын бодит баталгааны нэг болох нутгийн өөрөө удирдах байгууллагын шинэ тогтолцоог бий болгосон юм. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуульд тусгагдснаар энэ байгууллага Үндсэн хуулийн байгууллага болж, баг, хороо засаг захиргааны анхан шатны нэгж гэж анх удаа хуульчлагдсан.¹²

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар “Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг, сонирхолд нийцүүлэн

¹¹“Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” танилцуулга 2000 он

¹² Монгол Улсын Үндсэн хууль 1992 он

хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн” гэж тодорхойлсон болно. Энэ бол Монгол Улсын хуульд “Нутгийн өөрөө удирдах ёс” гэж юу болохыг анх удаа тодорхойлж өгсөн болно.¹³

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална” гэж удирдлагын үндсэн зарчмыг тодорхойлсон байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр байгуулагддаг, тухайн нутгийн иргэдийн хууль ёсны нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, тэднийг төлөөлөх, тухайн нутаг дэвсгэрийн амьдралын асуудлыг тэндхийн иргэдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж, эрхлэн хөтлөх үүрэг бүхий, үйл ажиллагаа нь төлөөллийн ардчиллын зарчим дээр үндэслэсэн, хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг байгууллага билээ.

Харин 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “нутгийн өөрийн удирдлага” гэж иргэд шууд, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг; 4.1.5. “нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн шууд оролцоо бүхий иргэдийн Нийтийн Хурлыг гэж заасан байна.

1.4.НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН БИЕ ДААСАН, ХАРААТ БУС ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх хэмжээ, бие даасан байдлыг ихэнх улс оронд Үндсэн хуулиараа баталгаажуулсан байдгаас гадна нутгийн удирдлагын тухай хууль, түүний санхүүгийн бие даасан байдлыг хангах чиглэлийн хуулийг ч бас баталсан байдаг.

Гадаадын зарим оронд өөрөө удирдах байгууллагыг хуулиар баталгаажуулсан байдал¹⁴

Хүснэгт 1

№	Улсын нэр	Үндсэн хуулиар баталгаажуулсан	Бие даасан хуультай
1	Герман	Үндсэн хуулийн 28 дугаар зүйл	
2	Польш	Үндсэн хуулийн 163, 168 дугаар зүйл	

¹³ Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2006 он “Төрийн мэдээлэл” сэтгүүл 2007 оны 02 дугаарт нийтлэгдсэн

¹⁴ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал тэдгээрийн бие даасан, хараат бус байдлын талаар харьцуулсан судалгаа” Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны төвөөс 2015 онд хийсэн судалгааны тайлан

3	Болгар	Үндсэн хуулийн 135-146 дугаар зүйл	1991 онд Нутгийн өөрийн удирдлагын тухай хуулийг баталсан
4	Латви	-	1994 онд Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуулийг баталсан
5	Литва	Үндсэн хуулийн 119-124 дугаар зүйл	1994 онд НӨУБ-ын хуулийг, 1995 онд Нутаг дэвсгэр засаг захиргааны нэгж болон хилийн цэсийн тухай хуулийг баталсан.
6	Оросын Холбооны Улс	-	2003 онд бие даасан хууль баталсан
3	Австри	Үндсэн хуулийн 116 дугаар зүйл	
4	Франц	Үндсэн хуулийн 34, 72 дугаар зүйл	1982 онд хуулиа баталсан
5	Итали	Үндсэн хуулийн 5, 114 дүгээр зүйл	
6	Тайланд	1997 оны Үндсэн хуулийн 78 дугаар зүйл	
7	Япон	1947 оны Үндсэн хуулийн 8 дугаар бүлэг	Бие даасан хуультай
8	Филиппин	1987 оны Үндсэн хуулийн 10 дугаар зүйл	
9	Турк	Үндсэн хуулийн 127 дугаар зүйл	
10	БНСУ	1987 оны Үндсэн хуулийн 117, 118 дугаар зүйл	

Нутгийн удирдлагын талаар органик хуультай Испани, Гүрж, Хятад, Папаяа шинэ Гвиней, Албани, Либери, Австрали, Шинэ Зеланд, Япон, Малайз, Их Британи, Ирланд, Дани, Нидерланд зэрэг орнууд байна.

БНХАУ-ын Үндсэн хуулийн 110 дугаар зүйл, Вьетнам Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлээр орон нутгийн бие даасан байдлыг үгүйсгэсэн зохицуулалтыг баталгаажуулжээ.

Аливаа улсын төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан ажиллах чадамж нь тухайн орны хөгжлийн суурь болдог бөгөөд хараат бус байдлыг хангах гол нөхцөл нь эрх зүйн болон санхүүгийн баталгаанаас шалтгаалдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага” гэсэн Дөрөвдүгээр бүлгийн 57-63 дугаар зүйлд нутгийн удирдлагын байгууллагын эрх зүйн үндсийг баталгаажуулж өгсний дээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай бие даасан хуультай байгаа нь маш том амжилт гэж хэлж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2-т "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно", Жаран хоёрдугаар зүйлийн 3-т "Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно"¹⁵ гэж тус тус бүрэн эрхийг хуульчилсан болно.

Үндсэн хуулийн дээрх заалт ёсоор төрийн байгууллага, орон нутгийн байгууллагын харилцааг орон нутагт эрх мэдэл төлөөлүүлэн шилжүүлэх хэлбэрээр зохион байгуулж болно. Харин төлөөлүүлэн шилжүүлсэн эрх мэдлийг хэрэгжүүлэх арга замыг орон нутгийн байгууллага өөрсдийнхөө онцлогийг харгалзан тодорхойлох, эрх мэдэл шилжүүлсэнтэй холбогдож гарах зардлыг төрөөс хариуцдаг байх нь чухал.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хуулиар баталгаажснаар:

-тухайн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх

-улсын хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулах үүрэг хүлээж байгаа болно.

Оросын Холбооны Улсын хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхийг манай оронтой харьцуулахад нэлээд боловсронгуй, нарийвчилсан хэм хэмжээгээр зохицуулсан байдаг. Тухайлбал, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтцийг нутгийн иргэд өөрсдөө тогтоох боломжийг хуулиар олгосны дээр, нутгийн өөрөө удирдах байгууллага нь төрийн байгууллагын тогтолцоонд орохгүй хэмээн заажээ. Мөн нутгийн өөрөө удирдах байгууллагад төрийн зарим бүрэн эрхийг шилжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалтыг хийж өгсөн байна. Оросын Холбооны Улсад орон нутгийн удирдлага иргэдийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар үйл ажиллагаа нь үнэлэгддэг, гол төлөв иргэд сонгогчдын өмнө улс төр, ёс суртахууны хариуцлага хүлээдэг. Төв засгийн газраас орон нутгийн удирдлага эрх мэдлээ хэтрүүлэх, иргэдийн эрх ашгийг хохироосон тохиолдолд хариуцлага хүлээлгэдгийн дээр, тухайн албан тушаалтан дахин сонгогдож чадахгүй байгаа нь хамгийн том хариуцлагагүй үйлдэл гэж үздэг байна.¹⁶

Иймд орон нутгийн Хурлын байгууллагын үйл ажиллагаанд төрийн болон удирдах дээд байгууллагаас зөвхөн Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон хүрээнд хяналт тавих, харин төрөөс төлөөлүүлэн шилжүүлсэн эрх мэдлийн хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт тавих учиртай.

Англи, Бельги, Дани, Малайз, Франц, Канад зэрэг улсуудад орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшүүлэхээс гадна, тодорхой тооны сонгогчийн гарын үсэг цуглуулсан, тодорхой хэмжээний барьцаа мөнгө төлсөн 18-21 насны, тухайн орон нутагт 6

¹⁵ Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

¹⁶ Хусейнов.Р.Р."Выдвижение и регистрации кандидатов на выборах в органы местного самоуправления: Зарубежный опыт для России" Вестник ПАГС

сараас багагүй хугацаагаар оршин суусан, зарим тохиолдолд их сургууль төгссөн зэрэг шаардлагыг хангасан иргэнийг сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хуулиар зөвшөөрдөг байна. Энэ нь цөөн тооны хэдэн нам улсын болон орон нутгийн сонгуульд ялалт байгуулах нөхцлийг бүрдүүлдэг байна.



Орон нутгийн сонгууль болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намын оролцоо¹⁷

Хүснэгт 2

	Үзүүлэлт	Испани	Герман	Их Британи	Ирланд	Дани
1	Хуулийн нэр	“Орон нутгийн засаг захиргааны үндсэн хууль” 1979 онд энэ хуулиар орон нутгийн ардчилсан сонгуулийг явуулсан.	Дэлхийн II дайны дараагаас орон нутгийн сонгуулиа “Орон нутгийн засаг захиргааны хууль”-иар явуулдаг болсон.	2000 онд парламентаар батлагдсан “Орон нутгийн засаг захиргааны акт”-аар орон нутгийн сонгуулийг зохицуулдаг.	1898 онд “Орон нутгийн захиргааны Ирландын акт”-ыг батлан гаргасан.	1953 оны “Үндсэн хуулийн акт”-аар орон нутгийн сонгуулийг зохион байгуулдаг.
2	Орон нутгийн сонгууль дахь улс төрийн намуудын оролцооны эрх зүйн зохицуулалт	Орон нутгийн зөвлөлтэй. Зөвлөлийн гишүүдийг улс төрийн нам санал болгож, иргэдээс сонгодог. Гишүүн нас барсан тохиолдолд сонгууль явуулахгүй. сонгуульд орсон санал авсан нэрсийн	Улс төрийн намаас нэр дэвшсэн гишүүдтэй зөвлөл орон нутгийн удирдлагыг хэрэгжүүл дэг.	Улс төрийн намын харьяалалтай гишүүдээр дамжуулан тухайн орон нутгийн зөвлөлд намын бодлогоо хэрэгжүүлдэг.	Орон нутгийн зөвлөлтэй байна. Зөвлөл нь пропорция наль системээр бүрддэг. Зөвлөл нь гол улс төрийн намаас хамаарал тай.	Орон нутгийн зөвлөл нь улс төрийн намуудаас нэр дэвшүүлж, сонгогдсон төлөөллөөс бүрдэнэ.

¹⁷ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд дахь улс төрийн намын оролцоо, үүрэг, нөлөө, гишүүдийн орон нутгийн хуралд нэр дэвших эрх, улс төрийн намуудын гишүүнчлэлийн тухай” Улсын Их Хурлын Тамгын газар судалгааны төвөөс 2012 онд хийсэн харьцуулсан судалгааны тайлангаас

		жагсаалтаар дараагийн хүнийг шууд сонгодог. Олонх суудал авсан намын гишүүдээс зөвлөлийн даргыг томилдог.				
3	Орон нутгийн хурлын байгууллагын үйл ажиллагаа нд улс төрийн намуудын оролцоо их.	Олонх болсон намын санал болгож томилуулсан Зөвлөлийн дарга нь орон нутгийн захиргааны бүх томилгоог хийдэг. Энэхүү томилгоогоор дамжуулан нам нь улс төрийн бодлогоо хэрэгжүүлдэг.	Мужийн орон нутгийн зөвлөлийн гишүүдийн дундаас захирагчийг сонгодог.	Мужийн зөвлөлийг иргэдээс шууд сонгогдсон захирагч удирддаг.	Орон нутгийн зөвлөлийг гол улс төрийн намаас нэр дэвшүүлж, сонгогдсон захирагч удирдана.	

Дүгнэлт:

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны зарчмууд баталгаажсан байх, орон нутаг өөрийн асуудлаа шийдвэрлэх чадамжтай байх зэрэг нөхцөл бий болсон байна.
- Төрөөс тодорхой эрх мэдлийг нутгийн удирдлагад шилжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга замыг орон нутаг өөрсдөө тодорхойлох боломжтой байх, шаардагдах хөрөнгийн дэмжлэгийг үзүүлж байх нь цаашид үр дүнгээ өгөх алхам боллоо гэж үзэж байна.
- Нутгийн өөрөө удирдах байгууллагыг орон нутгийн хэмжээний асуудлаа бие даан шийдвэрлэх санхүү, өмчийн болон тухайн нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хамгаалах, хяналт тавих, ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжоор нэмэгдүүлэх, илүү тодорхой болгох хэрэгтэй юм.

....оОо.....

1.5. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН



1.5.Хуралдаан

Хуралдаан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэр юм. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар “Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулна.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хамтын шийдвэр гаргадаг этгээдийн хувьд хуралдах нь түүний шийдвэрээ гаргах үндсэн хэлбэр бөгөөд нийт төлөөлөгчийн олонх нь хуралдаанд оролцсоноор хүчин төгөлдөр болж (өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах хууль ёсны бүрэлдэхүүн бүрдэж) шийдвэрээ гаргадаг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хэн нэгэн этгээд, түүний дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч дангаараа буюу хэсэг бүлгээрээ төлөөлөн гаргах эрхгүй бөгөөд хуулийн дагуу иргэдээс сонгогдсон бүрэлдэхүүн хуралдаж байж, сая шийдвэргаргах эрх нь үүсдэг.

46.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

46.2.Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулна.

46.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг нийт төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүйн саналаар, эсхүл Хурлын Зөвлөл, Хурлын даргын санаачилгаар хуралдуулна.

46.4.Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачилгаар, эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн арваас доошгүй хувь нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлнэ.¹⁸

¹⁸ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль –“Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2021 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

Хуралдаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чуулганы хуралдаан, Ажлын хороо, Түр болон Дэд хорооны хуралдаан хамаарна.

Хуралдаанаар тухайн Хурлын эрх хэмжээнд хамаарах бүхий л асуудлыг, түүний дотор тухайн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг ч хэлэлцэн

шийдвэрлэж болно \2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл Тэргүүлэгчидтэй холбоотой асуудал үйлчилнэ\.

Хурлын эрх хэмжээнд хамаарах бүхий л асуудал гэдэгт хуулиар заасан Хурлын бүрэн эрхээс гадна хуулиар хориглоогүй болон бусад байгууллага, албан тушаалтны бүрэн эрхэд хамааруулсан асуудлаас бусад асуудлыг ойлгоно.

Анхдугаар хуралдааныг хуульд зааснаар Хурлын тухайн хуралдаанд оролцож байгаа, шинээр сонгогдсон нийт төлөөлөгчдийн хамгийн ахмад нь даргална. Зарим аймаг, сум, дүүрэгт Хурлын даргаа сонгосны дараа шинээр сонгогдсон дарга нь анхдугаар хуралдааныг даргалж байсан нь хууль зөрчсөн хэрэг юм.

“Хуралдааныг даргална” хэмээх үүрэг нь хамтын шийдвэр гаргадаг байгууллагын хувьд онцгой үүрэг бөгөөд юуны өмнө шийдвэр гаргах үйл явцыг хууль болон холбогдох бусад эрхийн акт (тухайлбал, Хуралдааны дэг)-ын хүрээнд удирдан явуулах, хэлэлцүүлэг, санал хураалтыг удирдах, хуралдааны дэг сахиулах ажил үүнд хамаарна. Энд “даргалах” хэмээх үүрэгт “өмнөөс нь шийдвэр гаргах” асуудал огт хамаарахгүй. Хуралдааны үед хууль дээдлэх, цөөнхийг сонсох, зарчимч, шударга байх ёстой.

Ээлжит сонгуулийн дүнг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн шатны **сонгуулийн хороо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулна.**

Анхдугаар хуралдаанаас бусад хуралдааныг тухайн Хурлын дарга хуралдаан эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна. Хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор төлөөлөгчдийн аль нэг нь удирдана.

Анхдугаар хуралдаанаар Хурлын даргыг сонгож, Засаг даргад нэр дэвшүүлдэг. Хэрвээ сонгууль болсноос хойш хуульд заасан хугацаанд анхдугаар хуралдаанаа зарлан хуралдуулж, Хурлын даргаа сонгож, Засаг даргад нэр дэвшүүлж чадаагүй бол тухайн Хурлыг тарсанд тооцож, дахин сонгууль явуулах ёстой. Ийм тохиолдол нь Хуралд олонх байхгүй, эсвэл олонх хуваагдаж, зөвшилцөлд хүрч чадаагүйгээс, цөөнх хуралд оролцохгүй байх зэргээс шалтгаалдаг. Хурлын төлөөлөгчид нь нам намаараа талцан, хуралдаандаа оролцохгүй байх, тус тусдаа хуралдаж, Хурлын дарга, Засаг даргаар өөр өөр хүний нэр дэвшүүлдэг, хуулийн хугацааг дуусгах гэж хүлээх, өмнөх Хурлын дарга нь тамгаа хүлээлгэн өгөхгүй байх зэрэг үйлдлүүд гарч байгаа нь орон нутгийн амьдралд сөрөг нөлөөтэй байдаг.

Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг жил, улирлын төлөвлөгөөндөө тодорхой зааж, тэр чиглэлээр судалгаа, тооцоог хийж, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг урьдчилан сайн хангах нь хамгаас чухал юм.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар болон гарсан шийдвэрийг тогтмол мэдээлэх, тэдний саналыг шийдвэрт тусгах, нутгийн иргэдийн амьдралд нөлөөлөхөөр үр дүнтэй байх, батлагдсан шийдвэр хэрэгждэг байх талаас нь анхаарах хэрэгтэй юм.

2019 онд иргэдийн дунд хийсэн судалгааны тайланд тусгагдснаар “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлүүлэхэд нийт иргэдийн 43 хувь нь хэлж мэдэхгүй, 25 хувь нь орон нутгийн төсөв батлах гэж, 15 хувь нь татварын хувь хэмжээ, хураамж тогтоох гэж хариулсан байна. Дараах үзүүлэлтүүдээс гадна архидан согтуурахтай холбоотой, дэд бүтэц зам гүүр тавих, гэрэлтүүлэг хийх, сургууль цэцэрлэг барих, хог цэвэрлэх ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн чиглэлээр зэрэг хариулт¹⁸уудыг өгсөн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуульд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцох хэлбэрийг илүү тодорхой хуульчилсан тул энэ эрхийг хангах зохицуулалтыг Хурал бүр өөрийн хуралдааны дэг, бусад баримт бичгүүддээ тусгаж хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

Судалгаанаас харахад иргэд Хурлын хуралдаанд оролцох, саналаа өгөх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажилд биечлэн оролцох сонирхолтой байдаг байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд биечлэн оролцох сонирхолтой эсэхийг асуухад орон нутгийн иргэдийн 56 хувь, нийслэлийн иргэдийн 50 хувь буюу хоёр хүн тутмын нэг нь биечлэн оролцох сонирхолтой гэж хариулсан байгааг анхааралдаа авах, тэр боломжийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

Нийслэлийн иргэдээс ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй хэлбэрүүд¹⁹

Хүснэгт №3

	Цахим хэлбэрээр санал өгөх	Хурал цуглаанд оролцох	Санал асуулга, судалгаанд оролцох	Нээлттэй утсаар саналаа хэлэх	Хорооны Засаг дарга хэсгийн ахлагчаар дамжуулан саналаа уламжлах
Улаанбаатар	32.9%	26.7%	19.0%	15.8%	14.8%
Дүүргээр:					
Багануур	46.2%	23.1%	15.4%	7.7%	15.4%
Багахангай	15.8%	42.1%	21.1%	15.8%	5.3%
Баянгол	44.7%	22.4%	32.9%	31.6%	35.5%
Баянзүрх	25.4%	23.7%	15.3%	15.3%	15.3%
Налайх	43.8%	15.6%	9.4%	15.6%	15.6%
Сонгинохайрхан	17.1%	43.4%	9.2%	7.9%	5.3%
Сүхбаатар	39.7%	20.5%	24.7%	11.0%	8.2%
Хан-Уул	42.1%	17.5%	14.0%	19.3%	10.5%
Чингэлтэй	28.1%	30.2%	19.8%	12.5%	14.6%

^{18, 19} “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан” 2019 он

Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд дээрх үзүүлэлт харьцангуй өөр байна. Орон нутгийн иргэдийн 40 гаруй хувьд нь хурал, цуглаанд оролцох нь илүү зохимжтой хэлбэр гэж хариулсан байна. Энэ онцлогийг харгалзан үзэж иргэдийн саналыг авч болох юм.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож, тэр чиглэлээрээ хороод байгуулан ажиллана. Хороодын тоо, нэг хорооны гишүүний тоо хэд байхыг Хурал өөрөө тогтоох бөгөөд нийт төлөөлөгчөө тэнцүү хуваан 4-5 хороотой болгон зохион байгуулж байгаа өнөөгийн нийтлэг практикаас зайлсхийж, нэг төлөөлөгч хэд хэдэн хорооны гишүүн байж болохоор зохион байгуулах боломж бий. Ингэснээр хороодын үйл ажиллагааны уялдаа сайжрах ба хороодын дунд хариуцан ажиллах асуудлын давхцал, хийдэгдэл гарахгүй байх магадлал нэмэгдэх юм. Ингэснээр хороо бүрд намын бүлэг бүрийн төлөөлөл орох боломжтой болно.

Зайлшгүй байх хороодод төсөв санхүүгийн, нутгийн захиргааны асуудал эрхэлсэн хороодыг нэрлэж болох ба харин нийгмийн бодлогын болон хөдөө аж ахуйн бодлогын асуудлаар тус тус хэд хэдэн хороо байгуулж болох юм. Тухайлбал, тухайн Хурлын бүрэн эрхийн хугацаанд тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо нийгмийн халамжийн асуудлаар, эсвэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гэх мэтчилэн нийгмийн бодлогын тодорхой асуудлаар дагнасан хороо байгуулж ажиллуулж ч болох юм.

Хороо нь Хурлын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцан ажиллах дотоод зохион байгуулалтын нэг хэлбэр юм. Хороо нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хурлаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрийн төсөлд санал өгөх, эрхлэх асуудлаараа иргэдийн санаа бодлыг судалж хэлэлцэх, дүгнэлт гаргах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зэргээр Хурлын шийдвэрийг үндэслэлтэй, хэрэгжих магадлалтай гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулна.

Хороо нь эрхэлж байгаа асуудлынхаа хүрээнд иргэдийн санаа бодлыг судлах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх асуудлын талаар саналаа гаргах, холбогдох бичиг баримтыг боловсруулах, түүний хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн үндэслэлийг судлах, байгууллага, албан тушаалтны (түүний дотор тухайн нэгжийн Засаг даргын) үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, батлагдсан шийдвэрийг сурталчлах, тайлбарлан таниулах, хэрэгжилтийг нь тооцох, нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн асуудлыг өөрийн эрхлэх асуудлын хэмжээнд хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргана. Хорооны шийдвэр нь бие даасан шийдвэр биш бөгөөд уг асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрээ гаргаж байж сая албан ёсны болох юм. Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

Хурал нь цаг үеийн асуудлыг судлах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Түр хороо нь тодорхой асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулах, Хурлын нэрийн өмнөөс иргэдийн санаа бодлыг судлах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хянан шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг хугацаатай ажил үүргийг шуурхай гүйцэтгэж болно. Түр хорооны бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журам, гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Түр хороо нь гүйцэтгэж буй үүргийнхээ хүрээнд гаргах шийдвэр нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төсөл, шийдвэрийн төсөлд гаргасан санал дүгнэлт, шийдвэрийн хэрэгжилт, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт, дүгнэлт байна. Энэ нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцсэний дараа баталгаажиж, албан ёсны шийдвэр болно. Өөрөөр хэлбэл, түр хороо нь бие даан шийдвэр гаргахгүй, харин иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн үндэслэлийг боловсруулах юм. Түр хороог аливаа ажлын хэсгээс ялган авч үзэх нь чухал. Түр хороо нь Хурлын албан ёсны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эрхлэн явуулах үйл ажиллагаа нь Хурлаас олгосон бүрэн эрхээр баталгаажин хэрэгжих учиртай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож, тогтоолоор батална” гэж заасан байгаа.

Хуралдааныг товлон зарлах, зохион байгуулж хуралдуулах, Хурлын Төлөөлөгч, ажлын хороод, Засаг дарга бусад этгээд хуралдаанд ямар эрх үүрэгтэйгээр оролцох, саналаа яаж гаргах, иргэдийн оролцоог хэрхэн хангах, шийдвэрийг ямар хугацаанд ёсчлох, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, биелэлтийг хангуулах зэрэг бүхий л үйл явцыг хуралдааны дэгээр зохицуулдаг. Тиймээс иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг нь хууль, тогтоомжид нийцсэн, асуудлыг үр дүнтэй, шуурхай шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн байхаар боловсрогдсон байх ёстой.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг хуульчилж өгсөн. Хуульд зааснаар төлөөлөгч нь асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох, хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал дүгнэлт гаргах, санал хураалгах эрхтэй.

Байнгын ажиллагаатай биш, жилдээ цөөн хуралддаг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд төлөөлөгчийн хуралдаанд үг хэлэх хугацааны асуудлыг дэгээр заавал зохицуулах шаардлагатай байдаг.

Сүүлийн жилүүдэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага нь улс төрийн намуудын өргөн өрсөлдөөний үр дүнд байгуулагддаг болж, зарим тохиолдолд намуудын суудлын тоо харьцангуй ойрхон байдаг болсон. Энэ тохиолдолд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарч байгаа шийдвэрт олонх, цөөнхийн төлөөллийн саналыг харгалзах, харилцан зөвшилцөх явдал нилээд их гардаг болсон гэж хэлж болно.

Хэдийгээр холбогдох хууль, тогтоомжид цөөнхийн талаар тусгагдаагүй ч иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд энэ асуудлыг тодорхой хэмжээгээр тусгасан байдаг. Жишээ нь: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд "...Шаардлагатай гэж үзвэл цөөнхийн саналыг сонсож, саналыг томъёоллоор 1 удаа санал хураалгаж болно...", Дархан-Уул аймаг, Чингэлтэй дүүргийн хуралдааны дэгд "...Цөөнхийн саналыг тусгайлан хэлэлцэж, тэмдэглэлд тусгана...", Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд "...цөөнх бологсод хүсвэл уг асуудлаар 5 минутаас илүүгүй хугацаанд үндэслэлээ товч тайлбарлаж дахин санал хураалгаж болно...", Дорноговь аймаг болон мөн аймгийн Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд "...Цөөнхийн саналыг хүлээн авах эсэхийг олонхоор шийдвэрлэнэ..." гэсэн бол Хэнтий аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд "...цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно..." гэж тус тус тусгасан байна.

Бүх шатны Засаг дарга тухайн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Тамгын газар, нутгийн захиргааны агентлагийг оролцуулан зохион байгуулна. Засаг дарга Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаар жил бүр тухайн Хуралд тайлагнана.

Хуралдаан хуралдах нь чухал ажил боловч, түүний шийдвэрийг албажуулах, холбогдох албан тушаалтанд хүргэх, олон нийтэд сурталчлах, биелэлтийг хангуулах тодорхой төлөвлөгөө гарган ажиллаж, үр дүнгийн талаар тогтсон хугацаанд авч хэлэлцдэг байх талаар нарийн журамлах хэрэгтэй юм. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан дээр гарсан санал, шүүмжлэл бүрийг ажил хэрэг болгох талаар Хурлын ажлын албаны ажилтнууд анхааран ажиллах учиртай. Энэ тал дээр зарим алдаа, дутагдал байгааг үгүйсгэх боломжгүй.

Хурал дахь намуудын авсан суудлын тоо ойролцоо байгаа тохиолдолд дахин буюу нөхөн сонгуулиар сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх асуудлыг удаан хугацаагаар хэлэлцэхгүй байх явдал өнгөрсөн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд гарч байсан. Иймээс дахин буюу нөхөн сонгуулиар сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх асуудлыг сонгуулийн санал авсан өдрөөс хойш нэг сарын дотор гэдэг юм уу 20 хоногийн дотор гэдэг юм уу тодорхой хугацаа зааж өгч хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж байхыг дэгдээ заавал тусгах хэрэгтэй.

Мөн Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлыг дэгдээ тусган, хэлэлцүүлэг, сонсгол, уулзалтаа зохион байгуулах нь зүйтэй. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль болон холбогдох журамд заасан хугацаанд хэлэлцэх, хяналт, үнэлгээ хийх асуудлыг хуралдааны дэгд тусгах шаардлагатай юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг чөлөөлөх, огцруулах тухай асуудал тодорхой тусгагдаагүй учраас энэ талаар Хуралдааны дэгүүдэд тусгагдсан зүйл алга байна. Хэрвээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Хурлын даргаа огцруулах санал тавибал хэдэн хоногийн дотор хуралдаж, хуралдаан хийх товоо тогтоох

зохицуулалт байхгүй байгаа нь асуудлыг хэзээ ч хэлэлцэж болохоор, хэдэн сар ч хүлээх боломжтой байдалд хүргэж байгааг анхаарах нь чухал гэж үзэж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан учраас бүх шатны Хурлууд хуралдааны дэгээ хуульд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага үүсэж байна.

...oOo...



1.6.МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙН ОНЦЛОГ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль нь 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны дараа хамгийн эхэнд хэлэлцэгдэн батлагдаж байсан хууль юм.

Нутгийн удирдлагын эрх, үүргийг зохицуулдаг энэхүү хуулийг 2006 онд шинэчлэн баталж, нийт 20 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан боловч, цаг үеийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна гэж үзэн 2021онд шинэчилсэн найруулгыг дахин баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болоод байна.

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орж, нутгийн удирдлагын зарим эрх хэмжээ өөрчлөгдсөн нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн найруулах гол үндэслэл нь болсон.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай шинэ хуулийн гол онцлог нь:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн1-д "Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн" гэж заасныг хэрэгжүүлж, төвлөрлийг сааруулах, орон нутаг өөрийн асуудлаа бие даан шийдвэрлэх эрх мэдлийг олгоход чиглэгдсэн. Төсвийн болон өмчийн удирдлагын эрх хэмжээ нэмэгдэж, **нийгэм, эдийн засгийн цогцолбор байхын төлөө ажиллах боломжтой боллоо. Засаг захиргааны нэгжийн бие даан хөгжих нөхцлийг бүрдүүлэх, чадавхийг дээшлүүлэх, төвлөрлийг сааруулах асуудлыг шийдвэрлэснээр хөдөөгийн хүн ам, иргэдэд үзүүлэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах, шуурхай болох, зах зээлийн багтаамж нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.**

2."Нутгийн удирдлагын чиг үүрэг"-ийг төрийн чиг үүргээс, нэгж бүрийн чиг үүргийг тус бүрээр нь, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга ямар эрх, үүрэгтэйгээр ажиллахыг ангилан тогтоосноороо ач холбогдолтой. Засаг захиргааны нэгж бүрийн чиг үүргийг тогтоохдоо:

- чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид болон зохих түвшинд оновчтой хуваарилах;
- чиг үүрэг хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх;
- чиг үүргийг давхардуулахгүй байх;
- нэгжийн удирдлагад бүрэн эрх олгохдоо энэ хуулиар тогтоосон нэгж тус бүрийн чиг үүрэгт нийцүүлэн ялгаатай хуваарилах;

- тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэх зарчмыг баримталсан байна.

3.Аймаг, Нийслэл, сум, дүүрэг, баг, хороо нь засаг захиргааны нэгжийн хувьд ямар байгууллага болохыг тус бүрт нь тодорхойлж өгсний дээр, хуульд хэрэглэгдсэн нэр томъёог оруулсан нь хуулийг хэрэглэхэд илүү ойлгомжтой болгосон байна.

Засаг захиргааны нэгж, түүний дотор сум, хороо иргэдэд хамгийн ойр ажилладаг, хуульд заасан үйлчилгээг үзүүлэх үндсэн нэгж гэдэг утгаар нь нутгийн захиргааны үйл ажиллагааг төвлөрүүлэх чиглэл барьсан байна. Сумын чиг үүрэгт /хуулийн 22 дугаар зүйлд зааснаар/ сумын хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлт, өмч, төсөв, татвар, төлбөр хураамж, тодорхой хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны зохицуулалт, менежмент, объектын ашиглалт, засвар үйлчилгээ, арчлалт, хамгаалалтын асуудлууд хамаарна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт, аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн болон хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл, сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт, худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт, орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт, нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг хариуцна.

Сумын хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ, орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт, зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, суурин газрын гэрэлтүүлэг, хөшөө дурсгалын байршил тэдгээрийн арчлалт, хамгаалалтын асуудлыг хариуцан ажиллана.

Мөн гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт, хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент, оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт болон бусад цаг үеийн асуудлыг хариуцна гэж чиг үүргийг тодорхой заасан байна.

Аймаг нь сумдын нийтлэг эрх ашгийн төлөөлөл болохын зэрэгцээ төв засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум хоорондын асуудлыг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих чиглэл давамгайлсан чиг үүрэгтэй нэгж байхаар тодорхойлогдсон. Аймгийн чиг үүрэгт: /хуулийн 21дүгээр зүйлд зааснаар/ аймгийн хэмжээний асуудлуудын нийтлэг зохицуулалт, төлөвлөлт, хяналт, аймгийн хэмжээний дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, өмчийн асуудал, түүнд тавих хяналт, аймгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт, татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээ тогтоох асуудал, орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага зэрэг асуудал хамаарна. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу концесс болон үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэхээр болсон.

4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо багт хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс хуваарилуулах

эрхийн баталгааг хангаж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх үүргийг төр хариуцна. Төр энэ үүргээ хэрэгжүүлэхдээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дараах **эрхийн баталгааг** хангана.

Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг тусгайлан хуулийн 27 дугаар зүйлд тодорхойлж өгсөн. Төрийн зарим чиг үүргийг хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар **төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлж** болно. Нэгжийн удирдлагад төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шийдвэрлэхээр заасан болно.

Тухайн засаг захиргааны нэгж нь улсын бүртгэл, нийгмийн хамгаалал, халамж, газар зохион байгуулалт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, онцгой байдлын болон гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зэрэг нийт 25 төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэж, иргэдэд үйлчилгээ үзүүлэхээр хуульчлагдсан болно.

5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарчмыг илүү тодорхой, өргөн хүрээтэй болгосон. Жишээ нь: төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах, улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах, нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх, нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохгүй байх, нутгийн өөрийн удирдлага нь тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийг илэрхийлж, иргэдийн саналыг харгалзан үздэг байх, ил тод байх, иргэдийг мэдээллээр хангах, асуудлыг шийдвэрлэхдээ хамтын зарчмыг баримтлах гэж өмнөх хуульд байгаагүй нэгжийн удирдлагын шинэ зарчмууд нэмэгдсэн.

Нутгийн удирдлага үйл ажиллагаандаа дээрх зарчмуудыг баримталж ажиллах нь чухал болж байна.

6.Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо нь нийтийн эрх зүйн этгээд байна гэж хуульчилж өгсөн. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан аймаг, сум, нийслэл, дүүрэг эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно. Эрх зүйн харилцаанд аймаг, сум, нийслэл, дүүргийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор Засаг дарга төлөөлнө. Ингэснээр нутгийн удирдлагаас хуульд заасан эрх ашгаа хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах, төсөв болон бусад хуулийг батлахад өөрийн саналаа Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлэх механизмыг бүрдүүлж байна.

7.Засаг захиргааны нэгжийг өөрчлөх, татан буулгах асуудалд орсон өөрчлөлт:

Хүснэгт №4

2006 оны хууль	2020 оны хууль
4.1.Аймаг, сум, дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас	13.1.Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. 13.2.Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна. 13.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ

гаргасан саналыг үндэслэн хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ	тухайн нэгжийн иргэдийн саналыг авсан байна. Санал авах ажлыг харьяалах иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулах бөгөөд санал авах журмыг Улсын Их Хурал тогтооно. Санал хураалтад сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх оролцсон бол уг санал авах ажлын дүнг хүчинтэйд тооцно. 14.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална. 14.2.Баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно. 14.3.Монгол Улсын засаг захиргааны нэгжийн оноосон болон нэгж дэх газар зүйн нэр, гудамж, зам, талбайг төрийн албан ёсны хэлээр нэрлэнэ.
---	---

8.Нутгийн удирдлагын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлаар ажиллах нөхцлийг хуульчилсан.

Хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ асуудлыг шийдвэрлэхэд оролцохыг хориглоно” гэж заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын **бие даасан, хараат бусаар** үйл ажиллагаагаа явуулах эрхийг баталгаажуулж өгсөн зохицуулалт болсон юм.

9.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаантай холбоотой асуудлууд

Хүснэгт №5

№	2006 оны хууль	2020 оны хууль
1	23.4.Анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Хурлын Тэргүүлэгчид, бусад хуралдааныг тухайн Хурлын Тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна.	46.5.Ээлжит сонгуулийн дүнг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн хороо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулна. 46.6.Анхдугаар хуралдаанаас бусад хуралдааныг тухайн Хурлын дарга хуралдаан эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна.
2	23.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд 3-аас доошгүй удаа тус тус хуралдуулна.	46.2.Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулна.

10. Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон иргэдийн Нийтийн Хурлаас гарсан шийдвэрийг бүх шатны Засаг дарга хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхээс өмнө тухайн Хурал өөрийнх нь чиг үүрэг, бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга өөрийн санаачилгаар, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын даалгаснаар холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны агентлагийг оролцуулан зохион байгуулна.

4.Засаг дарга Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаар жил бүр тухайн Хуралд тайлагнаж байхыг хуульд заасан болно.

11.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл

Хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ. 51.2-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй” гэж заасан.

Одоогийн ажиллаж байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2022 оны 01 дүгээр сарын 01-нийг хүртэл хуралдаж, тогтоол гаргаж болох бөгөөд хуульд заасан тодорхой эрхээ хэрэгжүүлнэ. Хурлын Тэргүүлэгчид нь цаг үеийн асуудлаар шийдвэр гаргаж үр дүнгээ жилд тайлагнан ажилладаг байсан одоогийн үүргийг шинээр байгуулагдах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл гүйцэтгэхгүй, харин Хурлын Ажлын хороод илүү үүрэгтэйгээр ажиллах болно.

12.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгааг илүү өргөн хүрээгээр тогтоож өгсөн. Үүнд:

А.Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална гэж заасан байгаа.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг одоогийн мөрдөгдөж байгаа хуульд тодорхой заагаагүй байсны улмаас нь Хурлууд төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг өөрийн төсвийн хязгаарт багтаан тогтоодог байсан. Төлөөлөгчдөд зориулсан сургалт хийх, шаардлагатай ном, сэтгүүл авах, тойрогтоо ажиллах болон бусад арга хэмжээний зардал хомс, хэрвээ мөнгө зарцуулсан бол аудитын шалгалтаар асуудал үүсэх тохиолдлууд гардаг байсан. Зарим Хурлууд журам гарган төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг өөрийн хэмжээнд нь зохицуулж байгаа нь харилцан адилгүй байдлыг бий болгож байна.

Шинэ хуульд зааснаар 2022 оноос эхлэн төлөөлөгчийн үйл ажиллагааны болон тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тухайн Хурлын төсөвт тусгайлан

тусгадаг болсноор төлөөлөгчид сургалтыг тогтсон хугацаанд зохион байгуулах, бусад арга хэмжээг зохион байгуулж байх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Б.Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Хурлын төлөөлөгч шаардлагатай мэдээллийг холбогдох албан тушаалтнаас авах, танилцах, хурлын хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхээр бэлтгэхдээ мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас дэмжлэг, туслалцаа авах зэргээр ажиллах боломжтой.

В."Улс төрийн нам, бусад байгууллага төлөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно" гэсэн нь Төлөөлөгчийг үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс хамгаалах болно.

Иргэдийн итгэлийг хүлээж сонгогдсон төлөөлөгчийн хувьд үзэл бодлоо илэрхийлэх, асуудалд өөрийн итгэл үнэмшилээр хандах, бие даан хараат бусаар ажиллах эрх зүйн баталгаагаар хангагдсан нь чухал юм.

13.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болохоор болсон. Хуулийн энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.

Сонгуулийн дараа төрийн албан хаагчаар ажиллаж байсан хүн төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувиас илүү тоотойгоор сонгогдсон тохиолдолд ямар үндэслэлээр төлөөлөгч болон төрийн албыг давхар хаших, эсхүл татгалзаж төрийн албан хаагчаар үлдэх, эсхүл төрийн албанд томилогдсон тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг нарийвчлан журамлахгүй бол хүндрэл учрах магадлалтай.Мөн гурван шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зөвхөн нэг Хурлын бүрэлдэхүүнийг өөр байдлаар бүрдүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан "тэгш" байх зарчмыг хангах эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй юм.

14.Хуулийн 45 дугаар зүйлийн 45.6-д "Улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл **сумын** иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй. Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө" гэж хуульчилсан байгаа.

15.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 2020 оны хуульд иргэдийн Төлөөлөгчдийн **Хурлын төлөөлөгчдийн эрх, үүргийг** тодорхойлж, Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд **хориглох зүйл**, төлөөлөгчийг сонгогчдын саналаар **эгүүлэн татах**, төлөөлөгчид **хүлээлгэх хариуцлага** гэсэн шинэ зохицуулалтуудыг бий болгосон. Үүнд:

Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах, өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байхыг хориглосон болно. Хоёр шатны төлөөлөгчөөр давхар сонгогдох заалт нь 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөгдөх юм.

Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна. Төлөөлөгчийг эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална. Төлөөлөгчийг эгүүлэн татах энэ заалт нь Хурлын төлөөлөгчдийг

сонгогчдынхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, илүү хариуцлагатай ажиллахыг хуульчилсан анх удаагийн зохицуулалт боллоо.

Хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй, Хурлын дэг зөрчсөн, эсхүл үйл ажиллагаагаа хуульд заасны дагуу тайлагнаагүй бол Хурлаас дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

а.сануулах;

б.хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;

в.санал хураалтаас бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;

г.асуудал оруулах эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь Хурлын хуралдааны дэг, Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, бусад хууль, тогтоомжийг сайн судлан мөрдөж ажиллах, хуралдаанд урьдчилан бэлтгэж, аливаа зөрчил гаргахгүйгээр ажиллах нь чухал. Төлөөлөгч ямар нэгэн хариуцлага хүлээх нь сонгогчдын дунд нэр хүнд буурах, итгэх итгэл багасах, дараа дараагийн улс төрийн карьерт сайнаар нөлөөлөхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

16.Нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх **иргэний эрхийг** илүү тодорхой болгон хуульчилсан.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд иргэдийн шууд оролцоо хангалтгүй байсны дээр 2006 оны хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасан “Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно” гэсэн эрхээ бараг хэрэгжүүлдэггүй байлаа.

Шинэ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу шууд болон төлөөллийн байгууллагаараа уламжлан нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй.

Иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй.

Тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр санал гаргана гэж заасан нь иргэний оролцоог хангах чухал зохицуулалт боллоо.

Иргэд сайн дураараа үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх асуудлыг “Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо” гэсэн 31дүгээр зүйлийн 31.3-т нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах, энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй гэж хуульчилсан. Хурлын байгууллагыг иргэдийнхээ санал хүсэлтийг заавал хэлэлцдэг байхаар үүрэгжүүлж өгсөн нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг жинхэнэ иргэдийн төлөөллийн байгууллага гэдэг утгаар нь иргэддээ үйлчилдэг байгууллага болгон, илүү нээлттэй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар гаргах шийдвэрийн талаар хуульд заасны дагуу **зөвлөлдөх санал асуулга** явуулж болно” гэж заасан нь Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийг хэрэгжүүлэх боломжийг илүү тодорхой болгосон зохицуулалт болжээ.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль²⁰ийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 2дох хэсэгт зааснаар бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийг хөгжүүлэх сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй холбоотой асуудлаар зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж болно. Шийдвэр гаргах эрх бүхий этгээд дээрх асуудлаас бусад асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулж болох юм.

17.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох зохицуулалт

Хүснэгт №6

	2006 оны хууль	2020 оны хууль
	15.1.1.Хурлын нийт төлөөлөгчийн гуравны хоёроос доошгүй нь тухайн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаас нь өмнө тараах тухай санал гаргасан; 15.1.2.тухайн нутаг дэвсгэрийн нийт сонгогчийн дийлэнх олонхи нь Хурлын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нь зүйтэй гэж санал гаргасан; 15.1.3.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх, татан буулгах тухай Улсын Их Хурлын шийдвэр гарсан. 15.2.Энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан тохиолдолд Хурал өөрөө тарах тухай тогтоол гаргаснаар тухайн Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно. 15.3.Хурал өөрөө тарах тухай тогтоолын төслийг илээр санал хурааж шийдвэрлэнэ. 15.4.Багийн Хурлаар энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан асуудлыг хэлэлцэхээр бол тухайн багийн нийт өрхийн гуравны хоёроос доошгүйн төлөөлөл оролцсон тохиолдолд Хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно. 23.13.Ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдаан хуралдуулж	36.1.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн олонх нь тухайн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж санал оруулсан бол Хурлын нийт төлөөлөгчийн гуравны хоёроос доошгүйн саналаар тухайн Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан бол; 36.1.2.анхдугаар хуралдааныг товлон зарласнаас хойш <u>50 хоногийн дотор</u> анхдугаар хуралдааныг хуралдуулж Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй, хуульд заасан хугацаанд <u>төсвөө батлаагүй</u>, түүнчлэн хуралдаан зарлаж <u>товлосон хугацаанаас хойш хуралдахгүй 60-аас дээш хоног өнгөрсөн бол</u> тухайн <u>Хурлыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал оруулснаар</u> Засгийн газар тараах шийдвэр гаргасан бол. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх 60.1.18.энэ хуульд заасан үндэслэлээр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулах;

²⁰ “Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017 оны 09 дүгээрт нийтлэгдсэн.

Хурлын дарга сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол тухайн Хурлыг тарсанд тооцож дахин сонгууль явуулна.	
---	--

18.Зарим нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох тоог өөрчлөгдсөн болно. Жишээ нь: сумын хүн амын тоо нь 5000-9000 хүртэл бол **27** төлөөлөгч сонгогддог байсан бол шинэ хуулиар 25, сумын хүн амын тоо нь 9000 ба түүнээс дээш бол 31 сонгогддог байсан бол 2024 оноос 29 төлөөлөгч сонгогдохоор өөрчлөлт орсон болно.

19.Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга **тушаал** гаргадаг байхаар хуульд заасан.

20. Засаг даргыг томилох

Дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд тухайн нэр дэвшигчийг томилохоос татгалзаж болно. Засаг даргыг томилохоос татгалзсан тохиолдолд Хурал хуульд заасан журмаар **өөр хүний** нэрийг дэвшүүлэхээр болсон. Өмнө нь заавал өөр хүний нэрийг дэвшүүлдэггүй байсан.

21. Засаг даргад хариуцлага хүлээлгэх үндэслэл:

2006 оны хуулиар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бүх шатны Засаг даргад зөвхөн чөлөөлөх, огцруулах хариуцлага тооцдог байсан бол одоо шат дараалласан хариуцлагын тогтолцоог бий болгосон.

Засаг даргад хүлээлгэх хариуцлага

Хүснэгт №7

	2006 оны хууль	2020 оны хууль
	32 дугаар зүйл. Засаг даргыг чөлөөлөх, огцруулах, Засаг дарга огцрох 32.2.Засаг дарга гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон, түүнчлэн хууль тогтоомж зөрчсөн буюу чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй бол тухайн шатны Хурал түүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө огцруулах саналыг дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайдад хүргүүлнэ. 32.3.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 32.2-т заасан саналыг ажлын 5 хоногт хянаж огцруулах эсэх асуудлыг	65.1.Засаг даргад дараах үндэслэлээр хариуцлага тооцно: 65.1.1.Хурлын шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн; 65.1.2.нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн; 65.1.3.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гэж дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд үзсэн. 65.2.Энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасан үндэслэл бий болсон гэж Хурлын төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй нь үзэж гарын үсэг зурсан бол Хурал 15 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж, Засаг даргыг огцруулах, эсхүл түүнд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдад нийт төлөөлөгчдийн олонхын саналаар тавьж шийдвэрлүүлнэ. 65.3.Ерөнхий сайд, дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргад

шийдвэрлэнэ. 32.4.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 32.2-т заасан үндэслэлээр Засаг даргыг огцруулах бол саналаа зохих шатны Хуралд хүргүүлэх бөгөөд Хурал 15 хоногийн дотор хэлэлцэж санал хураалт явуулж хариу өгнө.	энэ хуулийн 65.1-д заасныг үндэслэн тухайн шатны Хурлын санал, эсхүл өөрийн санаачилгаар дараах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна: 65.3.1.сануулах; 65.3.2.үндсэн цалинг 20 хүртэлх хувиар гурван сар хүртэлх хугацаагаар хасах. 65.4.Энэхүү хуулийн 65.3-т заасны дагуу ногдуулсан хариуцлагыг шат дараалан хэрэглэнэ.
---	---

Энэ хуульд Засаг даргад хүлээлгэх хариуцлагын дээд хэлбэрүүд үйлчлэхээс гадна “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-д Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” төлөвлөлтийн баримт бичигт туссан орон нутгийн үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг огцруулах үндэслэл болно гэж заасан болно.

22.Баг, хороо бол засаг захиргааны анхан шатны нэгж. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын ирц, Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл, Хуралдааны даргатай холбоотой шинэ зохицуулалтууд хуульд тусгагдсан байгааг өмнөх хуультай харьцуулан орууллаа.

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал

Хүснэгт №8

№	2006 оны хууль	2020 оны хууль	тайлбар
1	23.10.Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно. 23.11.Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах буюу огцрох тухай хүсэлтийг нь хэлэлцэх тохиолдолд аймгийн төвийнхөөс бусад сумын багийн Хуралд багийн нийт өрхийн 50-иас доошгүй хувийн төлөөлөл оролцсон бол хүчинтэйд тооцно. 23.12.Баг, хорооны Хурлын хуралдааныг хэсэгчлэн зохион байгуулж болно.	32.6.Тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хорооны хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны товыг хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна.	Баг, хорооны ИНХ-ын хуралдааны ирцийн хувийг хүн амын тооноос хамааруулан өөрчлөн тогтоосон нь хэрэгжихэд илүү зохимжтой болсон. Харин хуралдааныг хэсэгчлэн зохион байгуулж болдог байсан өмнөх хуулийн зохицуулалт үгүй болсон нь хөдөө орон нутагт таруу оршин суудаг иргэдийн хувьд зарим тохиолдолд хүндрэлтэй болох магадлалтай. Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах буюу огцрох тухай хүсэлтийг нь хэлэлцэхэд тусгайлан тогтоосон ирцийн хувь шинэ хуульд байхгүй болсон.

2	17.2.Баг, хорооны Хурлын энэ хуулийн 17.1.1-17.1.3, 17.1.8-д зааснаас бусад бүрэн эрхийг уг Хурлын хуралдааны чөлөө цагт тухайн Хурлын Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ.	32.9.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл нь иргэдийн төлөөллөөс гадна баг, хорооны Засаг дарга болон Хуралдааны дарга, хорооны хэсгийн ахлагч нараас бүрдэх бөгөөд гагцхүү иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дараагийн хуралдаанд бэлтгэх, хуралдааныг товлон зарлах үүрэгтэй. Зөвлөлийн хурлыг Хуралдааны дарга тэргүүлнэ. 32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг тухайн хуралдаанаас сонгосон дарга удирдаж явуулна.	Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлд хэнийг оруулахаа хуралдаанд оролцогсод өөрсдөө шийдвэрлэх нь ардчиллын зарчимд илүү нийцэх байсан. Иргэдийн Нийтийн Хурал нь баг, хорооны Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт, дүгнэх өгөх үүрэгтэй. Зөвлөлийн бүрэлдэхүүнд нь баг, хорооны Засаг дарга өөрөө болон түүний харьяанд ажилладаг хэсгийн ахлагч нар орно гэж заасан нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээр байна.
3	38.6.Баг, хорооны Хурлын даргад тухайн шатны Засаг даргын сарын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал сар тутам олгоно.	32.11.Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс олгож болно. 32.12.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргыг улируулан сонгож болно.	Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс олгож болно гэж заасныг сайн журамлаж өгөхгүй бол урамшуулал өгөхөд асуудал үүснэ.
	Баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралдааныг ээлжит бусаар хийх тухай зохицуулалт байхгүй.	46.4.Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачилгаар , эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн арваас доошгүй хувь нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлнэ.	"Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг ...Засаг даргын санаачилгаар хуралдуулна" гэж заасан нь нутгийн еерее удирдах байгууллага болох Ундсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1, мен хуулийн Жардугаар зүйлийн 1 дэх хэсгийн агуулгад нийцэхгүй байна. Харин Засаг дарга иргэдийн Нийтийн Хурлыг зарлан хуралдуулах тухай санал гаргадаг байдлаар хуульд заасан бол зохимжтой байсан.

23.Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь “**дээд боловсролтой**” байх шаардлагыг хангасан байна. Хуулийн энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөх юм.

24.Төрөөс нэгжид тавих хяналт

Хуулийн 80 дугаар зүйлийн 80.1дэх хэсэгт төрөөс нэгжид тавих хяналтын хэлбэрийг тогтоож өгсөн. Үүнд:

- хууль тогтоомжоор нутгийн өөрийн удирдлагын эрх хэмжээг тогтоох;
- нутгийн өөрөө удирдах байгууллагын хэм хэмжээ тогтоосон актыг бүртгэх;
- Хурлын шийдвэрт хориг тавих;
- нутгийн өөрөө удирдах байгууллагыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тараах;
- нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх;
- хуульд заасан бусад хяналт.

25.Нутгийн удирдлагын төлөөлөл

Нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэх, хууль тогтоомжийн төсөл болон орон нутгийн төсөв боловсруулах, нутгийн удирдлагад чиг үүрэг шилжүүлэх, Засгийн газраас нутгийн удирдлагатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах ажиллагаанд Засгийн газартай хэлэлцээр хийх, нутгийн удирдлагын байгууллагын өмнөөс шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах чиг үүрэг бүхий нийтийн эрх зүйн этгээдийн эрх эдлэх төлөөллийн байгууллагыг байгуулж ажиллуулахыг анх удаа хуульчилж өгсөн. Гадаадын улс оронд нутгийн удирдлагын төлөөллийн байгууллага ажилладаг бөгөөд түүний үйл ажиллагаанд төрөөс санхүүгийн болон бусад хэлбэрээр, мөн иргэдийн орлогоос бага хэмжээний татвар авч дэмжлэг үзүүлдэг туршлага байдаг.

Энэ хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан төлөөллийн байгууллагад сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус бүрээс нэг, аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурал тус бүрээс хоёр төлөөлөгчийг сонгогдон ажиллана. Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

26. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндэс

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх нь төрийн үүрэг байхаар хуульчлагдсан. Төр энэ үүргээ хэрэгжүүлэхдээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дараах эрхийн баталгааг хангана. Үүнд:

1.тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх;

2.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох;

3.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвөөс хуваарилуулах;

15.1.4.байгалийн баялгийн үр өгөөж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад боломжид түшиглэн хөгжих;

5.орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилах;

6.хуульд заасан үндэслэл, журмын дагуу концесс болон үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх.

Төрийн үүргийг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсөвт тусгана. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэхэд тухайн нэгж өөрийн нөөц бололцоог дайчлан ажиллах үүрэг хүлээнэ.

Нутгийн удирдлагын төсвийн болон өмчийн эрх мэдэл

Нэгжийн төсвийн орлогын эх үүсвэр бага, санхүүгийн эрх мэдэл хомс байсныг өөрчилж, “...нийгэм, эдийн засгийн цогцолбор...” байх зорилтыг хэрэгжүүлэхэд шинээр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга чухал үүрэг гүйцэтгэх болно.

Хуулийн 16 дугаар зүйлд зааснаар “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь бие даасан төсөвтэй байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн эх үүсвэр нь татварын болон татварын бус орлого, улсын төсвийн санхүүжилт, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгийг хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна.

Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Шинэ хуулийн “Орон нутгийн сан” гэсэн 17 дугаар зүйлд зааснаар “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий Төсвийн тухай хуульд зааснаас өөр бусад сантай байж болно. Уг санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна. Санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг тухайн шатны Хурал тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах болсон.

Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь ийм сантай болсноор хандив, тусламж авах, түүнийгээ журамд заасны дагуу захиран зарцуулах, ил тод тайлагнах, иргэдийнхээ санал, санаачилгыг дэмжиж ажиллах боломжтой болох юм.

Хуульд зааснаар аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ.

Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно. Ингэснээр орон нутагт нийтийн халуун ус, уурын зуух, цэвэрлэгээ, ариутгал хариуцсан байгууллага зэрэг олон асуудлыг хуулийн этгээд байгуулах замаар шийдвэрлэж, гэрээ байгуулах, түрээслэх хэлбэрээр ажиллуулж болох юм. Түүнчлэн тухайн сумандаа эрчимсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малын түүхий эд боловсруулах жижиг үйлдвэр, цех байгуулах, газар тариалан эрхлэх, төмс хүнсний ногоо тариалах зэрэг үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдээ дэмжих бодлого баримталж ажиллах нь үр дүнтэй байна.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбоотойгоор олон хуульд нэмэлт, өөрчлөлт орох шаардлага бий болж байгаа. Тэдгээрээс юуны өмнө Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж 2022 оноос хэрэгжиж эхлэхээр болсон. Энэ өөрчлөлтөөр

Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт :

Хүснэгт №9

2006 оны хуульд	2020 оны хуульд
23.4.Улсын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.4.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;	Өөрчилсөн заалт: 23.4.1 дэх заалтын “татвар” гэснийг “татварын 60 хувь” гэж
23.6.Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.6.1.нийслэл хотын албан татвар; 23.6.2.газрын төлбөрийн 60 хувь; 23.6.3.үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар; 23.6.6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар	<u>Нэмсэн</u> заалт: “23.6.10. аж ахуйн нэгжийн орлогын албан Татварын 40 хувь” гэсэн заалт нэмэх <u>Хасагдсан</u> заалт: 23.6.2 дахь заалтын “газрын төлбөрийн 60 хувь” 23.6.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар” 23.6.6 дахь заалтын “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар”,

Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь нь аймгийн төсвийн орлогод төвлөрөх болсон. Тухайн нэгжид бүртгэлтэй аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нутгийн иргэд илүү авч хэрэглэвээс борлуулалтын орлого өндөр болж, орон нутгийн орлого нэмэгдэж, эргээд орон нутгийнхаа иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулагдах боломж бүрдэнэ.

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн нэгж мөн” гэсэн нь иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх гол суурь нэгж болохыг тодорхойлжээ.

Сум, дүүргийн төсвийн орлогод:

Хүснэгт №10

2006 оны хуульд	2020 оны хуульд
23.8.Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар; 23.8.14.газрын төлбөрийн 40 хувь	Нэмсэн заалт: “23.8.15. малын тоо толгойн албан татвар” “23.8.16.үл хөдлөх хөрөнгийн албан татвар” “23.8.17.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар” Өөрчилсөн заалт: 23 дугаар зүйлийн 23.8.14 дэх заалтын “газрын төлбөрийн 40 хувь” гэснийг “газрын төлбөр” гэж

Сумаас аймагт төвлөрүүлж байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого зуун хувь сумын төсөвт үлдэх, Малын тоо, толгойн албан татварын тухай хуульд заасны дагуу уг татварын орлогыг сум, дүүргийн татварын орлого болон Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн оршин суугчдын саналын дагуу хөдөө аж ахуйн салбарт зарцуулахаар зохицуулсан.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд²¹ зааснаар малын тоо толгойн албан татварыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0-2000 төгрөгийн хязгаарт багтаан малын төрөл тус бүрээр тогтооно. Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.

Малын тоо толгойн албан татвар төлөгч ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлөх үүрэгтэй.Энэ татварыг урьдчилан төлж болохоор хуульчлагдсан бөгөөд уг хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.

²¹ “Малын тоо толгойн албан татварын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2020 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль батлагдсанаар орон нутгийн төсвийн бие даасан байдал нэмэгдэж, бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх зэрэг малчдын өмнө тулгамдаж буй олон асуудлуудыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болсон юм.

Сум, дүүргийн төсвийг боловсруулж, батлахдаа харьяалах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан саналыг авч тусгана. Баг, хорооны үйл ажиллагааны зардлыг харьяалах сум, дүүргийн төсөвт тусгайлан батлаж байна гэж зааснаар баг, хороо өөрийнхээ нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлаа шийдвэрлүүлэх, үйл ажиллагааныхаа зардлыг санхүүжүүлэх боломж нэмэгдэнэ гэж үзэж байна.

Одоо шинэ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, холбогдох журам, дүрмийг шинэчлэн батлах, удирдлагын төвлөрсөн хэлбэрээ өөрчилж, төрийн төв болон дунд шатны байгууллагууд анхан шатны нэгжүүдээ бэхжүүлэх чиглэлээр ажиллах нь чухал байна.

....oOo....

2.ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох

Хурлын төлөөлөгчийг сонгох зарчим ямар байх, нэр дэвшүүлэх эрхийг ямар байгууллага эдлэж байгаагаас шалтгаалан Хурлын байгууллагын бие даасан, хараат бус байдал, иргэдийн эрх ашгийг хамгаалан ажиллах чадамж шалтгаалж байна.

Орон нутгийн Хурлыг сонгох сонгуульд нэр дэвшүүлэх эрхийг тухайлбал Япон, Унгар, Бангладеш, Польш, Болгар, Чех, Казахстан, Бүгд Найрамдах Солонгос зэрэг улсуудад иргэнд буюу бие даан нэр дэвшихээр, улс төрийн намуудад тодорхой тооны сонгогчдыг нэр дэвшүүлэхээр хуульчилсан байна.

- БНУУ-д тухайн орон нутагт байнгын оршин суугчийн нэрийг дэвшүүлэх, түүнчлэн төрийн бус байгууллага нэр дэвшүүлэх эрхтэй.

- БНСУ-д бие даан нэр дэвшигч нь тодорхой тооны сонгогчдын гарын үсэг цуглуулсан байх, мөн тодорхой хэмжээний мөнгөний барьцааг өгсөн байхаар заасан байдаг.

- Японд тухайн улс төрийн намд нэр дэвшүүлэх хүний тооны хязгаарыг тогтоож өгдөг.

- БНКазахстанд тухайн тойргийн сонгуульд өргөдөл гаргаж нэр дэвших, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах асуудлыг Орон нутгийн сонгуулийн тухай хуульд зааж өгсөн байдаг.

- Монгол Улсад улс төрийн нам болон тодорхой тооны дэмжигчдийн гарын үсэг цуглуулсан иргэн бие дааж нэрээ дэвшүүлэх эрхтэй.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх хэлбэрүүд:

Хүснэгт №11

Улсын нэр	Намаас	Сонгогчдоос	Олон нийтийн байгууллагаас	Бие даан нэр дэвших
Австрали		+		
Австри	+			
АНУ	+	+		
Герман	+	+		
Испани	+			
Казахстан	+			+
Канад	+	+		
Словени	+			+
Солонгос	+			+
Унгар	+	+	+	+
Франц	+			
Чили	+			+
Швейцарь	+			
Япон	+			+
Белорусь	+		+	+

Эндээс үзвэл сонгуульд нэр дэвшүүлэх хэд хэдэн аргыг улс орнуудад хэрэглэж байна:

- а) улс төрийн намууд нэр дэвшүүлэх,
- б) тодорхой тооны гарын үсэг цуглуулсан сонгогч бие дааж нэрээ дэвшүүлэх,
- в) улс төрийн намууд ба тодорхой тооны сонгогчдоос нэр дэвшсэн иргэн хамтран нэр дэвшүүлэх
- г) олон нийтийн байгууллага, хамт олноос

Тухайлбал, Канадад нэр дэвшүүлэх баримт бичигт зөвхөн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй хоёр сонгогчийн гарын үсэг байхад хангалттай байдаг бол, Австралид нэр дэвшүүлэх өргөдөлд сонгогчдийн нэрсийн жагсаалтад бүртгэлтэй арван сонгогч гарын үсэг зурсан байх хэрэгтэй бөгөөд эдгээрийн нэг нь нэр дэвшүүлэгч, нэг нь нэр дэвшүүлэгчийн саналыг дэмжигч, үлдсэн найм нь нэр дэвшигчийг дэмжихийг зөвшөөрсөн мөн жагсаалтад бүртгэлтэй сонгогч байна.

АНУ-д улс төрийн намууд нэр дэвшүүлэхийн тулд тодорхой тооны бүртгэгдсэн сонгогчдын гарын үсэг цуглуулсан байх хэрэгтэй (Иллинойст 25 мянга, Нью-Йоркт 20 мянга, Охайо, Алабамад 5 мянга г.м.). Гэхдээ АНУ-д ихэнх орон нутгийн сонгууль улс төрийн намуудын оролцоогүй явагддаг байна.

ХБНГУ-д Бундестагт суудалгүй боловч аль нэг муж улсын Ландтагт сүүлийн сонгуулиар таваас доошгүй суудал авсан улс төрийн нам сонгуулийн кампанид оролцох хүсэлтээ сонгуулийн хороонд мэдэгдэж, үүнийг нь үндэслэн холбооны сонгуулийн хороо уг байгууллагыг улс төрийн намын шинжтэй гэж үзсэн тохиолдолд сонгуульд нэр дэвшүүлэх эрх нээгдэнэ. Үүнээс гадна парламентад суудалгүй нам өөрийн нэр дэвшигчийн жагсаалтыг гаргаж, муж улс бүрт 1000-аас доошгүй сонгогчдын гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг байна.

Зарим улсын орон нутгийн Хурлын төлөөлөгч сонгогдох хүн ам, төлөөлөгчийн тоо

Хүснэгт №12

Улсын нэр, хүн амын тоо	Франц коммун	Итали коммун	Швед коммун	Герман гмина	Япон хот, суурин, тосгон
2000 хүртлэх	19	12	31	10	14
	1500-2000	3000	12000 хүртэл	1000-2000	2000-5000
5-100.0 мянга	45-53	30	61	40	30
	50.0-60.0=45				
	60.0-80.0=49	30-100.0=30	35-300.0=61	50-150.0=40	50-100=30
	80.0-100.0=53				
300.000 хүртэл	69	46	101	48	46
	300.0 =69	250-500=46	760.0 хүртэл =101	150-400.0 =48	300-500.0=46

2020 онд баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйл²²д иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог дараах байдлаар тогтоосон болно. Үүнд:

- 37.2.1.сумын хүн амын тоо нь 2000 хүртэл бол 15;
- 37.2.2.сумын хүн амын тоо нь 2001-5000 хүртэл бол 21;
- 37.2.3.сумын хүн амын тоо нь 5001-9000 хүртэл бол 25;
- 37.2.4.сумын хүн амын тоо нь 9001 ба түүнээс дээш бол 29.

Тайлбар:-Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.

37.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тоо 45 байна.

37.4.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тоог доор дурдсанаар тогтооно:

- 37.4.1.дүүргийн хүн амын тоо нь 100 000 хүртэл бол 25;
- 37.4.2.дүүргийн хүн амын тоо нь 100 001-200 000 хүртэл бол 35;
- 37.4.3.дүүргийн хүн амын тоо нь 200 001-300 000 хүртэл бол 41;
- 37.4.4.дүүргийн хүн амын тоо нь 300 001 ба түүнээс дээш бол 43.

37.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тоог доор дурдсанаар тогтооно:

- 37.1.1.аймгийн хүн амын тоо нь 50 000 хүртэл бол 25;
- 37.1.2.аймгийн хүн амын тоо нь 50 001-70 000 хүртэл бол 29;
- 37.1.3.аймгийн хүн амын тоо нь 70 001-90 000 хүртэл бол 35;
- 37.1.4.аймгийн хүн амын тоо нь 90 001-ээс дээш бол 41төлөөлөгч сонгоно.

Монгол Улсын Үндсэн хууль²³-ийн Тавин есдүгээр зүйлийн 3-т “Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.” гэж заасан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн тухай хуулиар орон нутгийн Хурлыг сонгох сонгуулийг зохион байгуулж байлаа.

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэсэн шинэ байгууллага байгуулагдснаас хойш 29 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд орон нутгийн Хурлыг сонгох сонгууль 7 удаа явагдаж, сонгуулийн олон системийг хэрэглэсэн болно. Үүнд:

²² Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020 он

²³ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгосон Монгол Улсын сонгуулийн тогтолцоо (1992-2016 он)

Хүснэгт №13

№	Хугацаа	Сонгуулийн тогтолцоо
1	1992 он	төлөөллийн зарчмаар, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас, аймаг, Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас сонгож байсан ²⁴ .
2	1996 он	хосолсон зарчмаар; төлөөлөгчдийн зарим нь тойргоос, зарим нь намын нэрийн жагсаалтаар сонгогдсон ²⁵
3	2000 он	иргэдээс шууд сонгогдох, мажоритар тогтолцоогоор;
4	2004 он	иргэдээс шууд сонгогдох, мажоритар тогтолцоогоор;
5	2008 он	томсгосон мажоритар тогтолцоогоор; ²⁶
6	2012 он	холимог тогтолцоогоор, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор, Улсын Их Хурлын сонгуультай хамт зохион байгуулсан; ²⁷
7	2016 он	иргэдээс шууд сонгогдох, мажоритар тогтолцоогоор ²⁸
8	2020 он	олонхын /мажоритар/ тогтолцоогоор ²⁶

1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг баталсны дараа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг баталж, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох анхны сонгуулийг шууд бусаар буюу төлөөллийн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох зарчмаар сонгож байгуулсан.

1996 онд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн тухай хуулийг баталж, уг хуулиар сонгуулийн хоёр тогтолцоог хосолсон аргаар явуулж, 2000 оны 8 дугаар сард мөн сонгуулийн өмнөхөн энэ хуульд томоохон нэмэлт, өөрчлөлт дахин оруулж, сонгуулийн мажоритар тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулсан болно.

2016 онд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн тухай хуулийг хүчингүй болгож, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг сонгох сонгуулийн тухай хуулийг тусад нь баталж, Улсын Их Хурлын сонгууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийг хамтад нь явуулсан.

²⁴ Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 1996.08.27

²⁵ Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2007.01.18

²⁶ Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 2012.09.14

²⁷ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 2012.04.27

²⁸ Сонгуулийн тухай хууль 2015.12.15 “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2016 оны 04 дугаарт нийтлэгдсэн

²⁶ Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль “Төрийн мэдээлэл” сэтгүүл 2020 оны 08 дугаарт нийтлэгдсэн

2016 оны орон нутгийн Хурлыг сонгох сонгуулиар Монгол Улсын 21 аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр 790, 9 дүүрэг 330 суманд төлөөлөгчөөр 7299, нийт 8089 хүн сонгогдноос 1.3 хувь нь бие даан нэр дэвшигчдээс сонгогджээ. Мөн 1618 баг, 169 хороонд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчээр 8930 гаруй хүн сонгогдон, сонгуульт үүрэг гүйцэтгэсэн байна.

2016 оны орон нутгийн Хурлыг сонгох сонгуулиар Монгол Улсын 21 аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр 790, 9 дүүрэг 330 суманд төлөөлөгчөөр 7299, нийт 8089 хүн сонгогдноос 1.3 хувь нь бие даан нэр дэвшигчдээс сонгогджээ. Мөн 1618 баг, 169 хороонд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчээр 8930 гаруй хүн сонгогдон, сонгуульт үүрэг гүйцэтгэсэн байна.

2019 оны 6 дугаар сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 12/Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдснаар “Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурал нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.” гэж тусгагдсан байсан боловч дэмжигдээгүй болно.

2020 оны орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох ээлжит сонгуулиар 21 аймгийн 771, нийслэлийн 45, 330 сумын 7062, 9 дүүргийн 291 нийт 8169 төлөөлөгч сонгогджээ. Энэ удаагийн сонгуульд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 9 нам, 1 эвслээс болон бие даан нэр дэвшигчид, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 3 намаас болон бие даан нэр дэвшигчид нийт 17149 хүн өрсөлдсөн байна. Одоо баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид 8000 гаруй хүн сонгогдож, Хурлын баг бүрэлдэн ажиллах болно.

Манай Улсад орон нутгийн Хурлын үйл ажиллагаанд улс төрийн намын оролцоо их байгаа бөгөөд үүнээс улбаатайгаар аймаг, Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд намын бүлгийн Ажлын алба байгуулагдан орон тоогоор ажиллаж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудад намын бүлгүүд байгуулагдан ажиллаж, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор дүгнэлт гаргах, хуралдаанаас завсарлага авах, хуралдааныг орхин гарах, намын бүлгийн саналыг хуралдаанд танилцуулах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Цөөн тооны төлөөлөгчтэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд улс төрийн намаас сонгогдсон төлөөлөгчийн тоо ойролцоо харьцаатай байвал улс төрийн шалтгаанаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргаа огцруулах саналыг удаа дараа хэлэлцдэг, төсвөө баталж чадахгүй байх зэрэг хүндрэлүүдтэй тулгарч, энэ асуудлаа шийдвэрлэж чадахгүй цаг хугацааг өнгөрөөж, тухайн орон нутгийнхаа иргэдийн өмнө тулгамдсан асуудлаа орхигдуулан сонгуулийн бүрэн эрхийн хугацаагаа дуусгадаг тохиолдол ч байсныг давтаж болохгүйг анхаарах нь чухал.

Орон нутгийнхаа хөгжлийн бодлогыг тодорхойлж, иргэдийнхээ амьдралын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй иргэдийн төлөөллийн байгууллагыг улс төрийн намын нөлөөллөөс ангижруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг иргэдийн

Нийтийн Хурлаас болон нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, иргэдээс нэр дэвшүүлдэг тогтолцоонд шилжүүлэх нь хамгийн оновчтой хувилбар гэж үзэж байна.

Мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгуулийн нэг тойргоос сонгодог тогтолцоонд шилжвэл олон ах дүүтэй хүн сонгогдох, хэтэрхий цөөхөн сонгогчоос сонгогддог одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөх сайн талтай юм. Нэг сумын иргэд бие биенээ сайн мэддэг учраас 15-25 төлөөлөгчийг сонгоод хамгийн олон санал авсан хүн сонгогдох боломжтой. Тухайн сонгогч заавал квотод тохирох бүх нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх шаардлагагүй бөгөөд өөрийн сонгохыг хүссэн хүнийхээ төлөө саналаа өгнө, саналын нийлбэр дүнгээр нэр дэвшигчдийг эрэмблэн жагсааж төлөөлөгчөө сонгоно.

2.2. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД БА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нь ихэнх тохиолдолд улс төрийн намаас нэр дэвшиж сонгогдож байгаа учраас шийдвэр гаргахдаа гадны нөлөөнд автах нь илүү байна. Улс төрийн нөлөөнөөс ангид байх зорилгоор холбогдох хууль тогтоомжид олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа боловч одоог хүртэл бүрэн шийдвэрлэгдэж чадаагүй л байна. Бие төлөөлөгчийн хувиар асуудалд хандах, иргэдийнхээ эрх ашгийн төлөө намчирхахгүй ажиллах нь ялангуяа сумын түвшинд илүү чухал юм.

1992-2008 он хүртлэх хугацаанд Хурлын төлөөлөгчөөр төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч нэр дэвших эрх нь нээлттэй байсан бөгөөд 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр Төрийн албаны тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт орж "Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны төрийн жинхэнэ албан хаагч-Хурлын төлөөлөгчийн тоо нийт төлөөлөгчийн гуравны нэгээс хэтрэхээргүй байна..." гэсэн заалтыг хүчингүй болгосон.

Төрийн албан хаагч улс төрийн намын харъяалалд байх, төрийн захиргааны албан хаагч иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр давхар сонгогдон ажиллахыг хориглосноор 2008 оны орон нутгийн Хурлыг сонгох сонгуулиар нийт 7668 төлөөлөгчийн 70 шахам хувь нь анх удаа сонгогдож, бүрэлдэхүүнд нь хувиариа хөдөлмөр эрхлэгч, малчин, төрийн бус байгууллагын төлөөлөл ихэнх нь байв.

Дээрх хуулийн зохицуулалт хийгдээгүй байхад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэлдэхүүний дийлэнх олонхийг тухайн шатны Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, ажилтнууд, түүний харъяа хэлтэс, агентлагын дарга, баг, хорооны Засаг дарга нар бүрдүүлж байсан. Иргэдийн Төлөөлөгчийн Хурал ийм бүрэлдэхүүнтэйгээр ажиллах нь Засаг даргын үйл ажиллагаанд үнэн зөв, үндэслэлтэй үнэлэлт өгөх боломжгүй байсны дээр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хараат бусаар жинхэнэ утгаараа ажиллаж чадахгүй байсан гэж хэлж болно.

2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан "Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан нэр дэвших эрхийг нээж өгсөн. Мөн хуулийн 25.8-д "Нам, эвсэл аливаа нэг намын гишүүн бус иргэнийг

түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр нэрийг нь дэвшүүлж болно”²⁹ гэж заасан нь төрийн албан хаагчийн сонгуульд нэр дэвших эрхийг нээж өгсөн.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд³⁰ 2017 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт орж “10.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн захиргааны албан тушаал эрхэлж болно.” гэж заасан болно. Хуулийн энэ зохицуулалт нь Хурлын байгууллагад Засаг даргын харьяаны албан тушаалтнууд сонгогдох боломжийг дахин бий болгосон нь туйлын харамсалтай.

2020 оны 12 дугаар сарын 24-нд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн³¹ шинэчилсэн найруулгаар зөвхөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болохоор, энэ зохицуулалт нь 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөгдөхөөр болсон.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэлдэхүүний талаарх судалгаа \2019 оны байдлаар\

Хүснэгт №14

№	ИТХ-ын нэр	Төлөөлөгчийн тоо	ИТХ-ын дэд дарга	Засаг дарга, орлогч	ТӨО ААН	Төрийн үйлчилгээний албан хаагч	Төрийн захиргааны албан хаагч	Доод шатны ИТХ-ын дарга	Доод шатны Засаг дарга, орлогч	Бүгд хувь
1	Нийслэлийн ИТХ	45	-	4	12	-	-	1	4	21 46.6%
2	Төв аймгийн ИТХ	41	-	1	3	8	1	-	10	23 56%
3	Баянхонгор аймаг	41	-	2	2	6	-	-	7	17 41%
3	Баянгол дүүрэг	41	3	-	8		4	-	5	20 48.7%
4	Төв Баянчанд мань	21		2	-		2	2	2	8 38.0%
5	Хэнтий Мөрөн	15	-	1	-	3	-	-	3	7 46,6%
6	Дорнод Хэрлэн	31	-	-	1	2	1	-	4	8 25%

²⁹ “Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль” 2012 он

³⁰ Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2006 он “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2007 оны 02 дугаарт нийтлэгдсэн

³¹ Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2006 он “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн

7	Дорнод Хөлөнбуйр	15	-	1	1	2	-	1	-	5 33%
8	Өвөрхангай Арвайхээр	31	-	1	2	1	2	-	11	17 54.8%
9	Хэнтий Цэнхэрман- дал	15	-	2	-	1	1	-	1	5 033%
10	Хэнтий Дэлгэрхаан	21	-	2	-	3	-	1	2	8 38.0%
11	Дундговь Хулд	25	-	1	1	2	-	-	4	8 32%
	дүн	342	3	17	31	28	11	5	53	148 43.2%

Судалгаанаас харахад 2019 оны 6 дугаар сарын байдлаар сонгон авсан 11 Хурлын 43.2 хувьд нь Засаг дарга болон тэдгээрийн орлогчид, сум, баг, хорооны Засаг дарга нар зэрэг улс төрийн албан тушаалтнаас гадна төрийн үйлчилгээний албан хаагчид, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга, дэд дарга нар олон байна.



Орон нутгийн төлөөллийн байгууллагын төлөөлөгчөөр гүйцэтгэх засаглалд ажиллаж байгаа хүмүүс сонгогддог, эсвэл сонгогдсоныхоо дараа ийм албан тушаалд очдогоос иргэдийн төлөөллийн болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт давхцаж, нутгийн өөрөө удирдах байгууллагын хараат бусаар ажиллах, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг. Иймээс иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчийн эрхэлж үл болох албан тушаалын жагсаалтыг батлан мөрдүүлэх нь чухал байна.

Жишээ нь: Индонезид орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь 21 насанд хүрсэн хүн байна.Төлөөлөгч нь бүтэн цагаар сонгуульд ажлаа гүйцэтгэх ёстой, төрийн албан хаагч төлөөлөгчөөр сонгогдох, сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хориглосны дээр улсын

төсвөөс санхүүжилт авдаг байгууллагад ажилладаг бол сонгуульд нэр дэвших эрхгүй байхаар хуульчилсан байна.

Оросын Холбооны Улсын Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуульд зааснаар орон нутгийн зөвлөлд сонгогдсон депутат нь багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэхээс өөр төрийн алба хаших эрхгүй, гадаадын банканд данс эзэмших, гадаадын хөрөнгө оруулалттай халамжийн болон бусад байгууллагад төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүн байх, бусад улсад үндсэн хөрөнгөтэй байх, санхүүгийн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосон болно.³²

Монгол Улсад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр Засаг дарга болон төрийн албан хаагчид сонгогдох нь иргэдэд мэдээллийг түргэн шуурхай түгээх, Хурлын шийдвэрийн хэрэгжүүлэх, ажлын уялдаа холбоог хангахад ач холбогдолтой боловч, төсөвт байгууллагын захирлууд өөрийнхээ ажилд хяналт тавьж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, хариуцлага тооцох боломжийг хязгаарлаж байгаа юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарал бүхий этгээдэд Авлигын эсрэг хуулийн³³ 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч” гэж заасан болно. Иймээс иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ шинэчлэн үнэн зөв гаргаж, өгөх үүрэгтэй.

Хурлын төлөөлөгч нь бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглодог бөгөөд аливаа захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана. Хэрвээ ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдал үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос болон санал өгөхөөс татгалзах, тухайн ажлыг гүйцэтгэх боломжгүйгээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ. Эдгээр зохицуулалт нь тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг болон Ёс зүйн дүрэмд туссан байдгийг сайн судлаж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хурлын төлөөлөгч нь хуралдааны чөлөөт цагт Хурлын хорооны үйл ажиллагаанд оролцож, төлөөлөгчийн хувьд хийсэн ажлынхаа талаарх мэдээллийг Хурлын цахим хуудсаар болон бусад хэлбэрээр сонгогчдод мэдээлэх үүрэг хүлээнэ. Төлөөлөгч Та Хурлын хуралдаан, Ажлын хороо, Дэд болон Түр хороо, ажлын хэсгийн хурал, иргэдийн Нийтийн Хуралд оролцсон, хяналт шалгалт хийсэн, сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан, асуудал санаачилж Хурлаар хэлэлцүүлсэн, тодорхой шийдвэр гаргуулсан, саналаа хэлсэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд асуулга, асуулт тавьсан, албан бичиг явуулсан, сонгогчидтойгоо уулзсан зэрэг бүхий л үйл ажиллагааныхаа талаар цахим хуудсаар мэдээлж байх нь чухал. Одоогийн практикаас харахад тухайн нэгжийн цахим хуудсаар зөвхөн Хурлын байгууллагаас хийж байгаа ажил мэдээлэгдэж байгаагаас бус,

³² Федеральный закон об общих принципах организации местного самоуправления в Российской федераций 16 сентября 2003 года

²⁸ “Авлигын эсрэг хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн

төлөөлөгч бүр юу хийж байгаа нь харагддаггүй, харин төлөөлөгчийн товч намтрыг л харах боломж байдгийг өөрчлөх цаг нь болсон.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн³⁴ 41, 42 дугаар зүйлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болгох мөн төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах нөхцлүүдийг заасан байгаа.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно. Үүнд:

- 1.хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;
- 2.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан;
- 3.тухайн орон нутгаас шилжсэн;
- 4.төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон;
- 5.төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулсан эсхүл хувьдаа ашигласан бол;
- 6.Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;
- 7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үндэслэлээр төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр хүчингүй болсон.
- 8.нас барсан;

Дээрх тохиолдлууд үүсвэл Хурлын төлөөлөгчийг чөлөөлөх, эсхүл огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Шинэ хуульд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог шинээр бий болгосон нь онцлог зохицуулалт гэж хэлж болно. Хуульд зааснаар Хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй, Хурлын дэг зөрчсөн, эсхүл үйл ажиллагаагаа хуульд заасны дагуу тайлагнаагүй бол Хурлаас дараах хариуцлага хүлээлгэхээр болсон. Үүнд:

- 1.сануулах;
- 2.хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;
- 3.санал хураалтаас бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;
- 4.асуудал оруулах эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах зэрэг болно.

Хурлын төлөөлөгч Та ямар нэг хариуцлага хүлээхээргүйгээр ажиллах нь хамгаас чухал. Төлөөлөгч хариуцлага хүлээх нь сонгогчдоос Танд итгэх итгэл нимгэрэх, дараагийн

³⁴ “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн

сонгуульд төлөөлөгчөөр дахин сонгогдох магадлал буурах учраас энэ дээрх арга хэмжээнээс илүү том хариуцлага гэдгийг ухамсарлаж ажиллах нь чухал. Одоо иргэд, сонгогчид сонгуульт албан тушаалтнуудаас илүү их хариуцлагатай ажиллахыг шаарддаг болсныг анхаарахгүй байхын аргагүй.

Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна. Эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална гэж хуульчлагдсан болно.

Дүгнэлт

- Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар бие дааж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндэс нь бүрдсэн.

- Монгол Улсын эдийн засгийн чадавх, засаг захиргааны олон нэгжээс улбаалан санхүүгийн хувьд хараат бусаар, бие даан ажиллах боломж тэр бүр хэрэгжиж чадахгүй байна.

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэлдэхүүнд Засаг даргаас хамаарал бүхий олон төлөөлөгч байгаагаас Хурлаас гарах шийдвэрт улс төрийн намын нөлөө их байна.

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн тогтолцоог сонгуулийн жил бүр холбогдох хууль, тогтоомжоор өөрчилж байгаад анхаарч, эрх зүйн орчинг тогтвортой байлгах шаардлагатай юм.

- Тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татах журмыг батлахдаа асуудалд болгоомжтой хандаж, хуульд нийцсэн байхад анхаарах нь чухал.

ooOoo

2.3. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол Монгол Улсын Үндсэн хуулиар бүтэц, тогтолцоо, чиг үүргээ баталгаажуулсан, тухайн нутаг дэвсгэрийн сонгогч иргэдээс сонгогдсон сонгуульт байгууллага, аливаа асуудлыг хамтын оюун ухаанаар шийдвэрлэдэг хамтын удирдлагын байгууллага юм.

Мөн тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засгийн ямар ч асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд өөрсдөө санаачлан, өөрсдөө хэлэлцэн шийдвэрлэдэг, биелэлт, үр дүнгээ өөрсдөө хянаж шалгадаг, өөрсдийн асуудлыг өөрсдөө зохион байгуулдаг, өөрөө удирдах ёсонд тулгуурласан нутгийн удирдлагын нэг субъект, өөрөө өөрийгөө удирдан зохион байгуулах байгууллага. Өөрөө удирдах байгууллага нь иргэдийнхээ оролцоо, бүтээлч идэвх, санаачлагад тулгуурласан иргэдийн байгууллага учраас түүнд нэг л ашиг сонирхол байдаг ба энэ нь тухайн нутгийн иргэдийн ашиг сонирхол юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарчим” гэсэн 12 дугаар зүйлд дараах зарчмыг мөрдөж ажиллахыг хуульчилсан болно. Үүнд:

- 1.төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах;
- 2.улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах;
- 3.нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн чиг үүргийг зааглах;
- 4.нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх;
- 5.нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохгүй байх;
- 6.нутгийн өөрийн удирдлага нь тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийг илэрхийлж, иргэдийн саналыг харгалзан үздэг байх;
- 7.ил тод байх, иргэдийг мэдээллээр хангах;
- 8.асуудлыг шийдвэрлэхдээ хамтын зарчмыг баримтлах.

“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь улс төр, өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлэхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч мөн” ²⁷ гэж хуульчлагджээ.

Тэгвэл нутгийн өөрөө удирдах байгууллагын эд эс болсон, чөлөөт сонгуулиар иргэдийн олонхийн санал авч сонгогдсон “Төлөөлөгч” гэдэг хүн бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд ямар шардлага хангасан байх ёстой, Хурлын төлөөлөгчөөр ажиллахын тулд ямар бэлтгэл хангасан байх ёстой вэ?

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Та

1.Хурлын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгддэг хууль, тогтоомжийг судалж, энэ чиглэлээр тодорхой мэдлэгтэй болсон байх. Юуны түрүүнд Монгол Улсын Үндсэн

хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Сонгуулийн тухай хуулиуд, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Газрын тухай хууль, Нийгмийн халамж, нийгмийн хамгаалалтай холбоотой багц хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хуулиуд гэх мэт ажил, үүрэгт нь нэн шаардлагатай хуулиуд болон Улсын Их Хурлын тогтоолууд, эдгээр хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр батлагдсан олон журам, хөтөлбөрүүдийг уншина.

2.Харьяалагдах Ажлын хороодын хамаарал бүхий салбарын тодорхой мэдлэг, мэдээлэлтэй болох шаардлага үүснэ. Тухайн асуудлаар батлагдсан Засгийн газрын тогтоол, яамдын сайдын тушаал, хөтөлбөр, журам, стандартуудыг судлах хэрэгтэй.

3.Хурлын эрх, үүргийг тодорхойлсон дүрэм, журмууд Үүнд:

А.2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олон журам, дүрмийг шинээр боловсруулж мөрдөх болно. Үүнд: иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах журам, төлөөлөгчийн баримтлах ёс зүйн жишиг дүрэм, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам, нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын дүрэм гэх мэт

Б.Тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өмнө нь батлагдсан шийдвэрүүдийг сайн судалсан байх. Үдүнд хугацааны бодлогын баримт бичгүүд, Засаг даргын мөрийн үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, Хурлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа гол шийдвэрүүд, Хурлын үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрэм, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааны дэг, Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, Ажлын хорооны ажиллах журам гэх мэт эрх зүйн баримт бичгүүдийг судлан хэрэгжүүлж ажиллах болно.

4.Тухайн орон нутаг, сонгогдсон тойргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болох, онцлог болон давуу тал, тулгамдаж байгаа бэрхшээлийн талаар болон хүн амын зүйн судалгаатай болох нь чухал. \аймаг, нийслэл, сум, дүүргийн нийгэм эдийн засгийн гол үзүүлэлт, хүн амын бүтэц, орлого, амьжиргааны түвшин, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн талаарх статистик мэдээлэл гэх мэт\

5.Нутгийн удирдлагын чиглэлээр бичигдсэн гадаад, дотоодын ном, гарын авлага, судалгааны материалыг унших, бусад Хурлын байгууллага болон төлөөлөгчийн үйл ажиллагаатай танилцах, туршлагаас суралцах зэрэг хэлбэрээр ажиллана.

Сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд тухайн нэгжийн болон өөрийн сонгогдсон тойрогтоо хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, эрэмблэх, тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох, төсөөлөлтэй болсон байх, тэдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн шатны Хурлын болон Засаг даргаас бэлтгэж байгаа бодлогын баримт бичигт тусгуулах, төсвийн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор тооцоо,

судалгаа хийж, төсөлд нь тусгуулах зэргээр идэвх санаачилгатай, бас хариуцлагатай ажиллах хэрэгтэй.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь иргэдийнхээ санал хүсэлтийг судалж, хийж байгаа ажлаа тогтмол мэдээлдэг, хуулиа дээдэлдэг, ёс зүйтэй байх зэрэг наад захын шаардлага, шалгуурыг хангахын төлөө ажиллах нь чухал юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа” гэсэн 44 дүгээр зүйлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгагдах бөгөөд түүнийгээ үр дүнтэй зарцуулж, санхүүгийн тайланг тогтсон хугацаанд холбогдох албан тушаалтанд хүргүүлж байх хэрэгтэй.

Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Харин улс төрийн нам, бусад байгууллага төлөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно.”³⁵ гэж хуульчлагдсан болно.

2.3.1. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ ХУРАЛДАА ХЭРХЭН АЖИЛЛАХ ТАЛААР:

Төлөөлөгчийн гол үүрэг бол иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаан, Ажлын хороод, дэд хороод, ажлын хэсгийн хуралд идэвхтэй оролцох замаар сонгосон иргэдийн эрх ашиг, хүсэл бодлыг бүрэн илэрхийлэх, тэдний итгэл найдварыг биелүүлэхэд анхаарлаа хандуулах явдал юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль³⁶ийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн эрх, үүрэг” гэсэн 39 дүгээр зүйлийн 39.1.4-т зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нь: Хуралд тодорхой **асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах эрхтэй**. Хурлын хуралдаанд тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах нь төлөөлөгчийн онцгой эрх юм. Энэ эрхээ эдлэхийн төлөө төлөөлөгч бүр санаа тавьж ажиллах нь хамгаас чухал гэдгийг ухамсарлах хэрэгтэй юм.

Хурлын хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр санаачлахдаа асуудлаа зөв сонгох, үндэслэл, тооцоог нарийн гаргах, хувилбаруудыг боловсруулах, иргэдээс санал авах, мэргэжлийн хүмүүсийн саналыг авах зэргээр маш сайн бэлтгэх шаардлагатай. Хуралдаанаар нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн төсөл хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа бол Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангах ёстой.

^{35, 31} “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн

Судалгааны дүнгээс харахад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын 65.6 хувийг Засаг даргаас өргөн мэдүүлж хэлэлцсэн байх бөгөөд Хурлын байгууллагаас санаачилж хэлэлцүүлсэн асуудал 29.3 хувийг, Хурлын төлөөлөгч өөрөө асуудал санаачлан шийдвэр гаргуулсан тохиолдол харьцангуй бага буюу 0.07 хувийг эзлэж байна. Мөн доод шатны Хурал, Засаг дарга, иргэдийн зүгээс хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхээр санал тавьсан тохиолдол маш бага буюу 0.04 хувь байгаа нь хуулиа судлаагүй, мөн санал тавих эрхийн талаар холбогдох мэдээллийг өгдөггүйтэй холбоотой гэж үзэж байна.

Сонгогдсон Хурлын төлөөлөгч сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах учиртай. Гэтэл амьдрал дээр Хурлын төлөөлөгчөөс өөрөө санаачлаад Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал бэлтгэж оруулаад, тогтоол гаргуулсан нь маш цөөн тоотой байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцсэн асуудал

Хүснэгт №15

№	асуулт	Төв АИТХ 2018- 2019 оны VI	Баян хонгор АИТХ	ӨВХ Арвай хээр	Дор нод Хөлөн буйр	Дор нод Хэр лэн сум	Хэн тий Мө рөн	Хэн тий Цэн хэр ман дал	Хэн тий Дэл гэр хаан	Дунд говь Хулд	дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	10
1	ИТХ-ын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо: үүнээс	33	36	24	27	29	27	34	37	29	276
	ИТХ-аас санаачилж батлуулсан асуудлын тоо	1	10	5	3	15	11	7	16	13	81 29,3 %
	Хуралдаанд Засаг даргаас өргөн мэдүүлж батлуулсан асуудлын тоо	31	26	19	24	13	16	27	9	16	181 65.6 %
	ИТХ-ын төлөөлөгчөөс санаачилж батлуулсан асуудлын тоо	1	10	1	1	1	3	-	3	-	20 0,07 %
	Багийн ИНХ, багийн Засаг даргаас асуудал	-	-	4	-	-	3	-	4	-	11 0.04

	хэлэлцүүлэхээр санал тавьж, хэлэлцсэн тоо										%
2	ИТХ-ын төлөөлөгчөөс тавьсан асуулгын тоо	3	2	-	75	-	-		5	-	85
3	ИТХ-аас хийсэн хяналт шалгалтын тоо	6	9	10	3	3	6	4	6	7	54
4	ИТХ-аас хийсэн үнэлгээний тоо	54	11	1	3	2	-	-	-	-	71
5	ИТХ-ын төлөөлөгчөөс иргэдтэй хийсэн уулзалтын тоо	139	149	6	7	8	6	6	7	3	331

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх иргэний эрх” гэсэн 29 дүгээр зүйлд “иргэд сайн дураараа үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх, нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд энэ эрхийг хэрэгжүүлэхэд тухайн тойргоос сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч санаачлагатай ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Хуралд оруулах шийдвэрийн төслийг бэлтгэхэд нь туслах, саналаа өгөх, холбогдох байгууллага, албан тушаалтантай уулзуулах, мэргэжлийн хүмүүсийн туслалцааг авах зэргээр дэмжлэг үзүүлэх нь чухал юм.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бас нэг чухал эрхэд



асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох эрх юм. Хуралдаанаар хэлэлцэх шийдвэрийн төсөлтэй хуралдаан болохоос өмнө сайтар танилцах, түүнтэй холбоотой хууль, тогтоомж, холбогдох судалгааны материалыг судалж, саналаа өгөх үндэслэл болгох хэрэгтэй.

Аливаа асуудалд саналаа өгөхдөө асуудлын ач холбогдлыг эрэмбэлэн авч үзэх, дараах үр дагаврыг тооцоолох, гадны нөлөөнөөс ангид байх, хууль дээдлэх зарчмыг

баримтлах, иргэдийн эрх ашгийг дээдэлж, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх ёстойг анхаарах нь чухал.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлын талаар **асуулт асууж хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах эрх** эдлэнэ.

Хурлын төлөөлөгч бүр хуралдаан дээр асуулт асуух, санал, дүгнэлт гаргахын өмнө урьдчилж бичгээр бэлтгэсэн байх нь чухал байдаг. Өмнөх практикаас харахад төлөөлөгчид хурлын материалтай сайн танилцдаггүйн улмаас танин мэдэхүйн чанартай эсхүл хэлэлцэж байгаа асуудлаас өөр асуулт асуух, гол зүйлээ онож асуухгүй байгаа харагддаг. Өдөр болгон хуралдаан болох биш, тухайн нэгжийн чухал гэсэн асуудал хэлэлцэгддэг учраас төлөөлөгчид хуралдааны чанарт онцгой анхаарах хэрэгтэй юм.

Хуралдаан дээр төлөөлөгч үг хэлэх, санал гаргахдаа урьдчилан бичгээр бэлтгээгүйн улмаас тухайн үед толгойдоо орж ирснээ шууд хэлж, тэр нь тодорхой санал болж Хурлаас гарах шийдвэрийн төсөлд тусгагдаж чадахгүй байх нь олон байдаг.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, санал гаргах эрхтэй. Энэ зорилгоор өөрийн хэвлэмэл хуудсаараа холбогдох албан тушаалтны илтгэл, сонсголыг ямар асуудлаар, хэзээ, хаана, ямар хурлаар хэлэлцүүлэх тухайгаа мэдэгдэх шаардлагатай. Тухайн албан бичгийг Хурлын ажлын албанд бүртгүүлж, албажуулан, тэндээс хүргүүлэх, хариуг мөн түүгээр дамжуулан авах хэрэгтэй.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны хяналтын нэг чухал хэрэгсэл бол Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих эрх юм.

Засаг даргад **асуулга тавих**, үүрэг даалгавар өгөх зэрэг харилцаа нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын хоорондох харилцааг илүү нягт, амьд болгодог харилцаа боловч бодит байдал дээр Хурлын төлөөлөгчид бүрэн утгаар нь энэ хяналтын механизмыг хэрэгжүүлж чадахгүй байгаад анхаарах нь чухал.

Асуулга тавих эрх, асуулгын хэлбэр, асуулгын хариуг сонсох, хариуцлагын талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид сайн мэддэггүй, асуулгыг бичгээр үйлдэх, хариуг хэзээ, ямар хэлбэрээр сонсох ёстойг судалж хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуул³⁷ийн 39 дүгээр зүйлийн 39.2-т Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад

³⁷“Монгол Улсын Их Хурлын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн

байгууллагын даргад бичгээр хандсаныг “**асуулга**” гэнэ. Асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгнө, 39 дүгээр зүйлийн 39.7 дох хэсэгт “Үйл ажиллагаатай нь холбогдох тодорхой асуудлаар мэдээлэл авах зорилгоор гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад бичгээр хандсаныг “**асуулт**” гэнэ. Асуултыг хүлээн авсан албан тушаалтан хариуг 14 хоногийн дотор гишүүнд бичгээр өгнө гэж заасан байгаа.

Хуулийн энэ зохицуулалт нь иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд адилхан мөрдөгдөж болно. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн шаардлагатай асуудал, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан асуулга тавьж хариу авах нь Хурлын хяналтын эрх юм.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь асуулга болон асуулт тавьсан бол хариуг Хурлын хуралдаан, Ажлын хорооны хурал эсхүл баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр авахаа тодорхой заах хэрэгтэй.

Асуулга болон асуултын хариуг хэлэлцээд Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн төслийг урьдчилан бэлтгэх хэрэгтэй болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс Хурлын хуралдаан, Ажлын хорооны хурлаар асуудал боловсруулан оруулж, иргэдийн амьдралд нөлөөлсөн, тодорхой үр дүнд хүрсэн шийдвэрүүд цөөнгүй бий.

Жишээ нь: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёр төлөөлөгч Сүхбаатарын талбайн 2 талаар явдаг нэг чиглэлийн урсгалтай замыг хоёр урсгалтай болгон өөрчлөх асуудлыг санаачлан, Мэргэжлийн байгууллагатай хамтран судалж боловсруулан Ажлын хорооны хурлаар хэлэлцүүлэн, улмаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд асуудал боловсруулан шийдвэр гаргуулж байсан нь олон нийтийн сэтгэлд нийцсэн ажил болж байсан юм.

Хурлын төлөөлөгч Та Ажлын хороо, Дэд болон Түр хороо, ажлын хэсгийн хуралд идэвхтэй оролцож санал, бодлоо илэрхийлэх, ажлын хорооны дүгнэлтэд саналаа тусгуулах, хяналт шалгалтын ажилд оролцох, сургалт хэлэлцүүлэгт оролцох, илтгэл, мэдээлэл хийх зэргээр аливаа ажилд идэвхтэй оролцож байх хэрэгтэй.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Ажлын хороодын жилийн ажлын төлөвлөгөөнд өөрийн саналаа тусгуулан түүнийгээ ажил хэрэг болгохын төлөө санаачилгатай ажиллах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаатай танилцахад аль болохоор хамрагдах, нэгжийнхээ хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах үүрэгтэйгээ ухамсарлан ажиллах нь чухал.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь Хурлын хуралдаан, Ажлын хороо, Ажлын хэсэгт үр дүнтэй ажиллаж, хуулиар хүлээсэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд хэрхэн ажиллавал үр дүнтэй вэ? гэсэн асуудал үүснэ. Үүний тулд:

-Хэлэлцэх асуудалтай холбоотой материал цуглуулах, холбогдох байгууллагаас тухайн чиглэлээр гарсан шийдвэрийг судлах, өмнөх гарсан шийдвэрийн хэрэгжилтийн талаар бүрэн ойлголттой байх хэрэгтэй.

Энд дурьдах бас нэг зүйл бол шинээр байгуулагдсан нутгийн удирдлагын байгууллага нь өмнөх удирдлагаас батлан хэрэгжүүлж байсан бодлого, шийдвэрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, сайн ажлыг аль намын хөтөлбөрт тусгагдсанаас үл хамааран үйл ажиллагаандаа баримтлан мөрдөх асуудал дутагдалтай байдаг. Аливаа асуудлыг боловсруулах, судлах зорилгоо хэрэгжүүлэх, мөн иргэний оролцоотой шийдвэрийг Хурлаас гаргахын тулд үе үеийн туршлагатай иргэдийн төлөөлөгчид, орон нутгийн удирдлагаар ажиллаж байсан хүмүүсийн санал бодлыг сонсож байх нь хэрэгтэй байдаг. Говь-Алтай аймгийн Шарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Иргэдийн оролцоо-Үе үеийн төлөөлөгчдийн санал, туршлагыг Хурлын төлөвлөгөө, үйл ажиллагаанд тусгах нь” төслийг хэрэгжүүлж, Нутгийн өөрөө удирдах байгууллагын ахмадууд, үе үеийн төлөөлөгчдийн зөвлөлгөөнийг зохион байгуулсан байдаг. Энэ нь аливаа асуудлын залгамж чанарыг хангасан сайн туршлага болсон байна.

-Хэлэлцэх гэж байгаа асуудлаар улс орны болон аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийн төлөв байдал, ололт, дутагдал, тулгамдаж байгаа асуудлын талаар бүрэн ойлголттой байх, ямар асуудлыг хэрхэн шийдэх талаар өөрийн саналыг урьдчилан бэлтгэсэн байх нь чухал. Ихэнх төлөөлөгчид хуралдаан дээр бэлтгэлгүй ирж, тухайн үед саналаа шууд хэлдэг дутагдлыг гаргахгүй байхад анхаарах нь чухал.

-Жил бүрийн төсөвт тодорхой асуудал тусгуулах талаар Төлөөлөгч санал, санаачилга гарган ажиллах;

Хурлын байгууллага нь төсвийн асуудлыг Хуралдаанаар хэлэлцэн батлахдаа 2 үе шатны хэлэлцүүлэг явуулж байвал үр дүнтэй байдаг. Хурлын төлөөлөгчид жил бүрийн төсвийн төслийг боловсруулсны дараа Сангийн яаманд хүргүүлэхээс өмнө Засаг даргын мэдээллийг сонсож, саналаа тусгуулах нь илүү үр дүнтэйг анхаарах хэрэгтэй;

-Тухайн орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт, Засаг даргын нөөц сангийн зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагаанд оролцох, Худалдан авах ажиллагаа, тендерт ялсан компаний ажлын гүйцэтгэлд тавих олон нийтийн хяналтыг зохион байгуулах;

2013 оноос эхлэн Төсвийн тухай хуулиар анх удаа иргэдэд орон нутгийн хөгжлийн асуудлаа бие даан шийдвэрлэх, төлөвлөх, зарцуулалтанд нь хяналт тавих эрх олгосон. Үүний дагуу жил бүрийн 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн нутаг дэвсгэрт хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс саналыг нь авч эрэмлэх ажлыг зохион байгуулдаг. Энэ сангийн хөрөнгийн зарцуулалтад шат, шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний төлөөлөгчид хяналт тавих үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж буй бараа үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих, Иргэний хяналтын зөвлөл, баг ажиллуулж, ажиллах журмыг нь баталсан, иргэний хяналтын багийн гишүүдэд сургалт өгсөн, сум бүрийг үнэлгээний хороонд орж ажиллах эрхтэй 1-5 иргэнтэй болгосон зэрэг сайн туршлага зарим аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад

хяналт тавих асуудлаар олон Хурлууд төсөл хөтөлбөрт хамрагдан олон ажлыг зохион байгуулж байна. Төлөөлөгч нь шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллага, иргэний хяналтын зөвлөл, багтай хамтран энэ чиглэлээр ажиллах боломж байна. Энэ асуудлаар Төв аймгийн Зуунмод сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд “Олон нийтийн аудит” ажиллуулсан нь үр дүнтэй ажил болсон байна.

-Хуралдаанд оролцох бэлтгэлээ урьдчилан сайн хангаж, хуралдааны материал болон холбогдох хууль, тогтоомжийг судалж, хэлэх үгийн төслөө тусгайлан бэлтгэсэн байх;

-Иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олон, мэргэжлийн хүмүүс, сонгогчдын санал бодлыг судалж, Хуралдаанаас гарах санал, дүгнэлтэд оруулах, Хурлын шийдвэрт тусгуулах; Ямар байгууллага, албан тушаалтан санаачилгатай, хөөцөлдлөгөтэй ажиллана тэр салбарын ажил, асуудал Хурлаас гарах шийдвэрт сайн тусгагддаг шиг төлөөлөгч ТА хэрхэн санаачилгатай ажилласнаас тухайн орон нутаг, тойргийн сонгогчдын эрх ашгийг хөндсөн олон асуудал шийдвэрлэгддэг\

-Санал бодлоо үндэслэл сайтайгаар хэлэх, тайлбарлах, өөрөө бүх асуудлаар бүрэн мэдлэг, мэдээлэлгүй байж болох ч энэ талын эрдэмтэн судлаач, мэргэжлийн хүмүүсээс туслалцаа авах, асуудал оруулж байгаа албан тушаалтнаас тодорхой мэдээлэл авах;

-Нутаг дэвсгэрийн байгууллагад тэдгээрийн харъяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, мэдээлэл авах, шаардлага хүргүүлэх;

-Хурлын дотоод бүтэц, зохион байгуулалтын ажлыг сайжруулах асуудлаар санаачилга гаргах, асуудал боловсруулах. Хурлын Тэрүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Ажлын албатай хамтарч ажиллах, холбогдох мэдээллээр хангагдах;

-Хурлаас гарч байгаа шийдвэрийг иргэд, сонгогчдод сурталчлах, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор тэдний саналыг урьдчилан авах;

-Хурлаас гарсан шийдвэр, тавьсан санал хүсэлтийн мөрөөр холбогдох байгууллага, газар хэлтэс дээр шалгаж танилцах, асуулга тавьж хариу авах, биелэлт үр дүнгээр мэдээлэл сонсох;

-Хурлаас зохион байгуулж байгаа сургалт, семинар, уулзалт ярилцлага бусад арга хэмжээнд идэвхтэй оролцох; \Энэ арга хэмжээ нь төлөөлөгчдийг сургаж, дадлагажуулах, мэдээлэл, арга зүйгээр хангах, туслах зорилготой байдаг тул төлөөлөгчид идэвхтэй оролцох нь чухал юм.\

-Төлөөлөгч нь ажлын тайлангаа тухайн Хуралдаа хагас, бүтэн жилээр ирүүлдэг байх; \Хурлын байгууллагын үйл ажиллагааны тайланд төлөөлөгчдийн санаачилж хийсэн ажлыг оруулах, сурталчлах, тэдний ажлыг дүгнэж урамшуулалд хамруулах зэрэг ач холбогдолтой байдаг.\

-Нийтийн сонсгол, хэлэлцүүлэг хийх талаар санал тавьж ажиллах;

Нийтийн сонсголын тухай хуул³⁸ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “...нутгийн

³⁸ “Нийтийн сонсголын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны 29 дүгээрт нийтлэгдсэн

өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэр дэх захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор **ерөнхий хяналтын сонсголыг** явуулна.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь ерөнхий хяналтын сонсголыг

1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчийн дөрөвний нэгээс доошгүй төлөөлөгч сонсгол явуулах хүсэлт гаргасан;

2.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хэлэлцэн хүлээн авсан бол зохион байгуулна.

Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага дараах асуудлаар **төсвийн хяналтын сонсголыг** жил бүр зохион байгуулна. Үүнд:

-орон нутгийн хөгжлийн сангийн төсөв;

-тусгай сангийн төсөв;

-орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл;

-орон нутгийн зээл, буцалтгүй тусламж төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь сонсгол зохион байгуулах талаар санал гаргах, зохион байгуулагдаж байгаа нээлттэй хэлэлцүүлэг, сонсголд идэвхтэй оролцож, хяналтын энэхүү механизмыг ашиглах чиглэлээр санаачилгатай ажиллах нь чухал юм.

-Хуралдааны дэгд заасны дагуу Төлөөлөгч намын бүлэгтээ ажиллах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.

...oOo...

2.3.2. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ СОНГОГДСОН ТОЙРОГТОО ХЭРХЭН АЖИЛЛАХ ТАЛААР:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны бас нэг талбар нь түүний сонгогдсон тойрог юм. Зарим төлөөлөгч сонгогдсныхоо дараа зөвхөн Хуралдаа ажиллаад өөрийгөө сайн ажиллаж байна гэж үзээд, тойргийнхоо сонгогчдыг мартах тохиолдол байдаг. Энэ нь зөвхөн сонгуулийн пропорцианаль тогтолцооны үед байх хэлбэр. Та тухайн нэгжийн аль нэг тойргоос сонгуулийн мажоритар системээр сонгогдсон бол тойргийнхоо иргэдтэй уулзаж Хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах, сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан хариуг хуульд заасан хугацаанд авах үүрэгтэй.

Мөн өөрийнхээ үйл ажиллагаагаа жилд нэг удаа сонгогчдодоо тайлагнаж байхаар хуульчлагдсан тул хийсэн ажилтай, хэлэх үгтэй байхаар ажлаа төлөвлөж, идэвхтэй ажиллахаас өөр гарцгүй. Үүний тулд дараах байдлаар ажиллаж болох юм.

-тойргийнхоо иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг, тэдгээртэй уулздаг сарын тодорхой өдөр, цагтай байх, энэ талаар иргэдэд мэдээллээ хүргэсэн байх;

-Тойргийнхоо иргэдийн талаар дэлгэрэнгүй судалгаатай болж, түүнийгээ баяжуулж ажиллах;

-Төлөөлөгч нь сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тухайн тойргийнхоо сонгогчдод мэдээлж ажиллах;

-Бүх сум, дүүрэг, баг, хороонд хүрч ажиллах нь бэрхшээлтэй тул баг, хороо бүрт өөрийн төлөөлөгч, идэвхтэн сонгуультан, иргэдийн багтай болж тэднээрээ дамжуулж үйл ажиллагаа явуулах;

-Сар, улирал бүр тодорхой нэг ажил зохион байгуулж, иргэдтэй уулзаж хэвших; \ажлаа жилээр төлөвлөж, төсвийн тооцоог сайн гаргах\

-Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд тусалж, тэдэнтэй баг болж ажиллах;

-Иргэдийн бүлэг, Сууц өмчлөгчдийн холбоо, Нутгийн зөвлөл болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах; \Нутгийн удирдлагыг чадавхжуулах чиглэлээр ажилладаг Монголын Нутгийн удирдлагын холбоо, Нутгийн удирдлагын нийгэмлэг, “Тунгаамал төв”, Баг, сумдын холбоо зэрэг олон төрийн бус байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна\.

-Тухайн тойрогтоо тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай иргэдийн олонх нь дэмжиж хүссэн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах; \мэргэжлийн хүмүүсийг газар дээр нь урьж авч очих, хариу өгүүлэх, дүгнэлт гаргуулах. Газрын алба, хууль хяналтын байгууллага гэх мэт\

-Иргэд, сонгогчдынхоо санал бодлыг сонсон судалгаа хийж ажиллах; \Тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг хөдөлмөр, халамж,

үйлчилгээний хэлтэс, иргэдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, бусад байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулах\

-Тодорхой сонгогчдын гэр орноор орж ярилцах, нийгмийн давхарга, сонирхлын бүлгийн хүмүүстэй уулзаж ярилцан, тэдний хүч дэмжлэгийг авч, хамтарч ажиллах;

Энд нэг жишээ дуръя. Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс удирдамж гарган төлөөлөгчдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, иргэдэд Хурлын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тэд ажил, үйлчилгээтэй нь танилцаж “Төлөөлөгчийн нэг өдөр –Хишиг өдөр”-ийг зохион байгуулжээ. Энэ өдрөөр 24 төлөөлөгч ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, сургуулийн дотуур байр, газар тариалангийн “Алтан дуулга” компани, нийтийн аж ахуйн газруудад багш, галч, тогооч, асрагч, гурилын үйлдвэрт ажилчнаар ажилласан байна. Энэ үеэр төлөөлөгчдөд ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй байдлын журам заавар, ажлын байрны үүрэг даалгавар зэргийг танилцуулан холбогдох албан тушаалтан хариуцан заавар зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.

Төлөөлөгчид ажиллах явцдаа тухайн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, ололт дутагдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохын зэрэгцээ тэдний санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан ажиллажээ. Мөн хишиг өдрөөр төлөөлөгчид 7 бүлэг болон хуваагдаж, нэг бүлэг нь 10 айлыг сонгон зочилж, сумын Хурлаас хийж байгаа ажил, баталсан шийдвэрээ танилцуулан тэдний санал бодлыг сонсон, гарсан санал, хүсэлтүүдийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан нь иргэдийн сэтгэлд нийцсэн сайхан ажил болсон байна.

-Төлөөлөгч Та тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа аливаа төсөл, хөтөлбөрт иргэдийг тэгш хамруулахад анхаарах, үр дүнг хянах; Ингэснээр хамрагдах ёстой иргэн тухайн хөтөлбөрт хамрагдаж байгаа эсэх, зээл, тусламж, эд материалын түгээлтийн үр дүн нь ямар байсанд үнэлэлт өгөх боломжтой болно.

-Нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын ажилтай танилцах, тулгамдаж байгаа асуудлыг нь шийдвэрлэхэд туслах;

-Сум, дүүрэг, баг, хорооны Хурлын ажлыг идэвхжүүлэхэд анхаарч туслах;

-Төр, засгийн гаргасан шийдвэрийг сурталчлах, гарах гэж байгаа хуулийн төсөлд иргэдээс тавьж байгаа саналыг тусгуулах талаар санаачилгатай ажиллах, parliament.mn, forum.parliament.mn, law.parliament.mn цахим хуудсанд байнга хандан хуулийн төсөлтэй танилцан, иргэдээс санал авах, холбогдох Байнгын хороо, тухайн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн болон тухайн хуулийн төсөл дээр ажиллаж байгаа, ажлын хэсэгт ажиллаж байгаа гишүүдэд саналаа хүргүүлж ажиллах;

-Сонгогчдын эрх ашгийг хөндсөн нэн шаардлагатай хуулийн талаар болон шинээр батлагдсан хууль, тогтоол, бусад шийдвэрийн талаар иргэд, сонгогчдод мэдээлэл өгөх, сурталчлах;

-Иргэний танхимаас зохион байгуулж байгаа хэлэлцүүлэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг тухайн тойрог, сум, дүүрэг, баг, хороонд хэрхэн хуваарилах, эрэмбэлэх талаар анхаарч ажиллах, иргэдийн Нийтийн Хуралд оролцож байх;



-Төлөөлөгч нь иргэдийн санаачилгыг идэвхжүүлж ажиллах;

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Иргэний оролцоо - Гудамжны Хурал” арга хэмжээг зохион байгуулсан сайн туршлага байна. Хурлын нэг зорилго бол иргэдийн Нийтийн Хуралд иргэдийн ирэхийг хүлээх биш тэдэнтэй очиж уулзах, санал бодлыг нь сонсох, амьдрал ахуйтай нь танилцах явдал юм. Орон нутгийн Хурлын талаар бүрэн ойлголтгүй, хорооны иргэдийн Нийтийн Хуралд оролцдоггүй олон иргэд гудамжны хуралд оролцож санал бодлоо илэрхийлэх, иргэдийн оролцоотой шийдвэр гаргах боломж бүрдсэн байгаа юм. Дээрх төсөл, арга хэмжээг зохион байгуулснаар гудамжны ахлагчаа сонгосон, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж, байранд тодорхой урамшуулал бүхий эргүүлийг иргэдийн оролцоотойгоор ажиллуулах болсон, иргэдээс сонгогдсон Хурлын төлөөлөгчид нь энэ хуралд оролцон, тэдний тавьсан санал, хүсэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх боломж бүрдсэн, мөн иргэд зохион байгуулалтад орж, өөрсдөө явган хүний зам, шат барьсан, хашааны хаягжуулалтаа хийсэн, хог цэвэрлэгээний ажил сайжирсан зэрэг олон эерэг үр дүн гарсан байна. Төлөөлөгчид өөрсдөө хөрөнгө мөнгө гарган зарим ажлыг дэмжиж ажилласан нь зохих үр дүнгээ өгчээ.

-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль³⁹ийн 39 дүгээр зүйлийн 39.1.8-д зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах эрхтэй. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу судлан шийдвэрлэх эрхтэй. Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авсан төлөөлөгч “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль-ийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу 30 хоногийн дотор шийдвэрлэн хариу өгөх үүрэгтэй.”⁴⁰

Харин судалж шийдвэрлэхэд хугацаа шаардагдах асуудлыг 90 хоногийн дотор багтаан хариу өгөх ёстой талаар Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан

³⁹ Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020 он “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн

⁴⁰ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмын тухай хууль” Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн

байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль⁴¹ ийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас авах эрхтэй.

2019 онд хийгдсэн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтээс авсан судалгааны тайлан”-д иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч иргэдтэйгээ ямар хугацаанд уулзалт хийдэг, иргэд төлөөлөгчөө хэзээ харсан, нэрийг нь мэдэх талаарх асуултанд дараах хариултыг өгчээ.

Орон нутгийн иргэд аймгийнхаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг 24 хувь нь, Улаанбаатар хотын иргэд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг 6 хувь нь зөв нэрлэсэн бол нийслэлийн иргэдийн 47.9 хувь нь, орон нутгийн иргэдийн 18.6 хувь төлөөлөгчөө огт хараагүй гэж хариулсан нь 2015 онд хийгдэж байсан судалгааны дүнгээс 17.7 хувь болон 24.8 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм.

Дүүргийнхээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөө иргэдийн 45.9 хувь нь огт хараагүй, 19.4 хувь нь хэзээ харснаа санахгүй байна гэж хариулсан бол сумын иргэдийн 12.7 хувь нь огт хараагүй, 28.7 хувь нь хэзээ харснаа санахгүй байна гэжээ. Улаанбаатар хотын иргэд гол төлөв сонгуулийн үеэр харсан гэсэн бол хөдөө орон нутгийн иргэд сарын өмнө харсан гэж хариулсан хувь нь өндөр байсан байна.

Сонгогчид төлөөлөгчийн үйл ажиллагаанд дээрх байдлаар үнэлгээ өгсөн байдлыг давтахгүйн тулд шинээр сонгогдон ажиллаж байгаа Та бүхэн ажлаа нарийн төлөвлөн сонгуульт үүргээ сайн биелүүлэх хэрэгтэй юм.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудас байнгын ажиллагаатай байж, иргэдэд мэдээллээ хүргэх үүрэгтэй боловч, зарим нэгжид шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь нийтлэх байдал хангалтгүй байх, төлөөлөгч нэг бүр ямар ажил хийж байгаа нь тодорхойгүй хэвээр байсаар байна. Ялангуяа иргэдийг Хурлын үйл ажиллагаанд оролцох боломжоор хангахгүй байгаагийн дээр, Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаан нь зөвхөн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллагын албан тушаалтнуудын хүрээнд зохион байгуулагдаж байгаад дүгнэлт хийж, холбогдох баримт бичгүүдэд өөрчлөлт хийж, энэ байдлыг шинэчлэх нь чухал юм.

...оОо...

⁴¹ “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” ” Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2011 оны 26 дугаарт нийтлэгдсэн

2.3.3.ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨӨС ЗАСАГ ДАРГАТАЙ ХЭРХЭН ХАРИЛЦАН АЖИЛЛАХ ТАЛААР:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх ёстойг хуульчилсан нь ихээхэн ач холбогдолтой.

Засаг даргын Тамгын газар нь хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох үүрэг хүлээдэг.

Таныг мэдээллэл, арга зүйгээр хангах гол байгууллага нь Засаг даргын Тамгын газар юм. Тэнд мэргэшсэн хүмүүс ажилладаг тул тодорхой, шаардлагатай мэдээллийг авч байх;

-Хурлын хуралдаан, Ажлын хороод, Тэргүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэр, тэнд яригдаж хэлэлцэгдэх асуудлын талаар мэдээлэл сонсох, газар дээр нь танилцах, мэргэжлийн байгууллага, аудитын байгууллагатай хамтарч ажиллах;

-Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газартай хамтран жил бүрийн тодорхой заасан хугацаанд \02 дугаар сарын эхний 10 хоногт багтаан\ өмнөх жилийн ажлын үр дүн, хийх ажлын зорилт, эдийн засаг, нийгмийн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;

-Иргэдээс тавьж буй санал, хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох газар хэлтэст бичгээр өгч, хариу авах, иргэддээ эргэж мэдээлэх;

-Засаг даргын ажлын албадаар иргэдэд мэдээлэл хийлгэх, газар дээр нь тавьсан асуудалд хариу өгүүлэх, тайлбар хийлгэх;

-Тухайн тойргийн хэмжээний тулгамдсан асуудал бүрээс жил бүрийн зорилтод хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх; \Зам далан суваг, үерийн хамгаалалт, цахилгаан холбоо, цэцэрлэгжүүлэлт, газрын асуудал, нийгмийн асуудал гэх мэт\

-Төлөөлөгч бүр хэсэг бүлгээрээ, ажлын хороод, ажлын хэсэгт ажиллан тодорхой асуудлаар аймаг, орон нутгийн удирдлага, газар, хэлтсийн дарга нараас мэдээлэл, сонсох, асууж ярилцах замаар асуудлаа шийдвэрлэж байх;

-Сонгогчидтой уулзах үеэр иргэдээс хамгийн их сонирхдог, хүсдэг, эсвэл шүүмжилдэг асуудлаар холбогдох газар хэлтсийн дарга удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулан тайлбар өгүүлэх;

-Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хамтарсан шалгалт хийх, биелэлт үр дүнгийн талаар мэдээлэл сонсох, тодорхой шийдвэрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

-Иргэдийн зөвлөл, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, идэвхтэн, сонгуультан нартай хамтарч ажиллах, тэдний санал бодлыг сонсох, идэвхжүүлэх зэрэг хэлбэрийг дурьдаж болох юм.

2.3.4.Улсын Их Хурлын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид тойрогтоо хамтарч ажиллах нь:

-Нэг баг болж ажиллах. Тойрогтоо нэгдсэн болон хэсэгчилсэн уулзалт хийх, аймаг, нийслэл, сум, дүүргийн холбогдох хүмүүсийг байлцуулан ярилцах, асуулт, санал хүсэлтэд хариулт өгөх; \Улсын Их Хурлын гишүүдийг орон нутагт ажиллахад нь хамт явах, уулзалтанд нь оролцох\

-Тойрог, сум, дүүрэг, хороо, багтаа сонгуультны хамтарсан баг байгуулж ажиллуулах, тэднээр дамжуулан мэдээлэл авах, хариу өгөх хэлбэрээр ажиллах;

-Тухайн тойрогтоо тулгамдсан асуудлыг улс, аймаг, нийслэл, сум, дүүрэгтээ хуваан авч шийдвэрлүүлэх, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудлыг хамтран хөөцөлдөх, үр дүнгийн талаар тодорхой хугацаанд хамтран ярилцаж дүгнэх;

-Сонгогч иргэдээс тавьсан санал, хүсэлтийг барагдуулах, шийдвэрлэх талаар шат, шатандаа арга хэмжээ авч ажиллах;

-Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлагчийн хувьд тодорхой хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлэх талаар санал тавих, Засгийн газар, Яам, Тамгын газарт шаардлагатай асуудлаар хамтран хандах, гарах шийдвэрт нь иргэдийн эрх ашгийг хөндсөн тулгамдсан асуудлыг тусгуулах, хариу өгүүлэх;

-Тойрогтоо хамтарсан уулзалт, өдөрлөг, нээлттэй уулзалт, ярилцах цаг зэрэг сэдэвт ажлыг хамтран зохион байгуулах. Тайлангаа хамтарч танилцуулах өдөртөө болох;

-Хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр тулгамдаж байгаа асуудлаа ярих, хийж байгаа ажлаа сурталчлах, мэдээлэх ажлыг хамтран зохион байгуулах;

-Улсын Их Хурлын цахим хуудас, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсанд гарч байгаа асуудлуудтай цаг алдалгүй танилцаж, сурталчлах.



2.3.5.Бусад асуудлын талаар:

Төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Засаг даргын ажлын алба” гэсэн 67 дугаар зүйлийн 67.1.7-д “тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх” үүргийг тухайн шатны Засаг даргын Тамгын газарт хүлээлгэсэн байгаа.

Төлөөлөгчийг Хурал, сонгогдсон тойрогтоо ажиллахад нь холбогдох материал, мэдээллээр хангах, төлөөлөгчөөс тавьсан хүсэлт, гаргасан санал, сонгуулийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд Хурлын байгууллага, Засаг даргын Тамгын газар, түүний харъяа газар, хэлтэс, байгууллагаас туслах, төлөөлөгчийн өөрийнх нь асуудлыг шийдвэрлэхэд Хурлын байгууллагаас дэмжлэг үзүүлж байхад анхаарах хэрэгтэй.

Төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлыг Хурлын байгууллагаас хангаж ажиллана. \Үүнд: албан томилолтын зардал, хяналт шалгалт, танилцах ажлын тээврийн асуудал, бичиг хэргийн материал, хэрэгсэл, энгэрийн тэмдэг, үнэмлэх, хэвлэмэл хуудас олгох, ойн болон хүндэтгэлийн арга хэмжээнд оролцуулах гэх мэт\

Ёс зүйн асуудлын тухайд: Иргэдийн итгэлийг хүлээж, төрийн албыг хашна гэдэг бол ихээхэн нэр хүндтэй, хариуцлагатай зүйл учраас иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь ажил үүрэгтээ үнэнч байж, бүхий л авъяас билэг, оюуны чадавхаа дайчлан ажиллах шаардлагатай юм. Төлөөлөгч нь тухайн засаг захиргааны нэгжийн нийт ард иргэдийн эрх ашгийг төлөөлж, төрийн байгууллага, иргэдийн хоорондын гүүр болж ажиллах үүрэг хүлээсний хувьд ёс зүйн өндөр хариуцлагатай ажиллах ёстой.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд Ёс зүйн дэд хороо байгуулж, “Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн дэд хорооны дүрэм”-ийг батлан мөрдөж ажиллана.

Төлөөлөгчийн ёс зүйн гол шаардлага бол Хурлын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх, тухайн засаг захиргааны нэгжийн хөгжил, иргэдийн амьдралын асуудлыг шийдвэрлэхийн төлөө өөрийн хувийн болон намын ашиг сонирхлоос ангид ажиллах үзүүлэлт гэж үзэж байна. Төлөөлөгчийн ёс зүй нь эрүүл бөгөөд тогтвортой, ардчилсан нийгмийн ба төрт ёсны ёс суртахууны чин эрмэлзэлд бүрэн нийцсэн байх учиртай.

Төлөөлөгчийн ёс зүйн асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргах Ёс зүйн дэд хорооны дүрмийн зорилт нь төлөөлөгчийг ёс зүйн элдэв зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, түүнийг иргэдийн өмнө хүлээсэн сонгуульт үүргээ чин шударгаар, хариуцлагатай гүйцэтгэхэд туслах зорилготой юм.

Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс 2015, 2019 онуудад “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа”-г 2 удаа хийсэн. Судалгааны гол зорилго нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, төлөөлөгчдийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг, хандлага, оролцоог тодруулж, мэдээлэл авч байдлыг судлах, цаашид шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоход чиглэгдсэн юм.

2019 онд хийгдсэн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан”⁴²-д дурьдсанаар судалгаанд оролцогчдоос иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын талаар ямар ойлголттой байдаг талаар тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн 56.8 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 48.2 хувь нь ямар нэгэн ойлголтгүй гэж хариулсан байна. Өмнөх суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын талаарх ойлголттой иргэдийн хувь Улаанбаатар хотод 24.8 хувиар буурч, хөдөө орон нутагт 22.8 хувиар өссөн байна.

⁴²“Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан” “Эм Эм Си Жи” ХХК-аас хийсэн судалгаа 2019 он

Тухайн тойргоос сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөө хамгийн сүүлд хэзээ харсан талаар тодруулахад судалгаанд оролцогчдоос Улаанбаатар хотын иргэдийн 47.9 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 18.6 хувь **“огт хараагүй”** гэж хариулсан нь өмнөх 2015 онд хийгдсэн судалгааны дүнгээс 17.7 хувь болон 24.8 хувиар буурчээ. Харин хаана харснаа **“санахгүй байгаа”** гэж хариулсан иргэдийн эзлэх хувь өсөж Улаанбаатар хотод 19.6 хувь, хөдөө орон нутагт 34.9 хувь болсон байна.

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг хөдөө орон нутгийн иргэдийн 25 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 8 хувь нь зөв нэрлэсэн байна. Орон нутгийн иргэд Улаанбаатар хотын иргэдтэй харьцуулахад тухайн тойргийн төлөөлөгчөө зөв нэрлэх байдал 3 дахин өндөр байна.

Сум, дүүргийнхээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчтэй холбогдоход хүндрэлтэй байсан гэж Улаанбаатар хотын иргэдийн 61.5 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 22.3 хувь хариулсан байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 40.7 хувь, 20.3 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарсан байгаад төлөөлөгчид анхаарч, иргэдтэйгээ илүү холбоотой ажиллах шаардлагатай юм.

Судалгаанд хамрагдсан оролцогч талууд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэх ёстой гэж үзсэн байна. Дараах шалгуур үзүүлэлтээр үнэлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын харьяалах хорооны ажилд оролцож, хийсэн ажил
- Баг, хороон дээр орж ажиллаж, уулзсан өрхийн тоо
- Иргэдийн тавьсан санал, хүсэлтийг биелүүлсэн хувь
- Дэвшүүлсэн саналын тоо, Хурлын шийдвэрт нөлөөлсөн байдал
- Ажил хэрэг болгосон саналын тоо
- Хурлын ирц, идэвх, оролцооны байдал
- Шударга ажилласан, нөлөөнд автахгүй байдал
- Гаргасан санал, санаачилга, ажлаа иргэддээ тайлагнасан байдал
- Хэдий хэмжээний төсвөөр иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн
- Иргэд, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө гаргасан хүчинчармайлт зэрэг үзүүлэлт байж болно гэж үзсэн байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт ⁴³

Хүснэгт №16

Гол үр дүнгүүд	2019 он		2015 он		Өөрчлөлт	
	Улаанбаатар хот	орон нутаг	Улаанбаатар хот	Орон нутаг	Улаанбаатар хот	Орон нутаг

⁴³ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан” “Эм Эм Си Жи” ХХК-аас хийсэн судалгаа 2019 он

Сум, дүүргийн ИТХ-ын үйл ажиллагааг "маш сайн" болон "зарим талаараа сайн" гэж үнэлсэн	19.8%	33.1%	18.8%	34.2%	1.0%	-1.1%
Өөрийн тойргоос сонгогдсон аймаг, нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчийг зөв нэрлэсэн	6.0%	24.0%	4.8%	23.7%	1.2%	0.3%
Өөрийн тойргоос сонгогдсон Сум, дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг зөв нэрлэсэн	8.0%	25.0%	6.4%	26.3%	1.6%	-1.3%
Сум, дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй ямар нэгэн зорилго, асуудлаар уулзаж байсан	7.8%	22.1%	14.0%	5.0%	-6.2%	17.1%
Сум, дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй уулзахад хүндрэлтэй байсан	61.5%	22.3%	20.8%	2.0%	40.7%	20.3%
Иргэдийн илэрхийлсэн хүсэлт, асуудал, санал гомдол үр дүнтэй шийдэгдсэн байдал	25.6%	28.7%	20.8%	48.5%	4.8%	-19.8%
Сум, дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгчийг "маш сайн" болон "зарим талаараа сайн" гэж үнэлсэн	18.2%	30.0%	15.0%	32.7%	3.2%	-2.7%
Баг, хорооны ИНХ -д оролцож үзсэн	20.6%	49.2%	28.0%	56.7%	-7.4%	-7.5%
Өнгөрсөн жил баг, хорооны ИНХ -д оролцсон	20.2%	49.1%	28.0%	56.7%	-7.8%	-7.6%
Баг, хорооны хурлын урилга, мэдээлэл ирвэл оролцох хандлага	47.1%	63.2%	51.8%	70.0%	-4.7%	-6.8%

Иргэдээс төлөөлөгчийн үйл ажиллагаанд тааруу үнэлгээ өгч байгаа нь дараах шалтгаантай. Үүнд:

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид иргэддээ хүрсэн ажил санаачилж, хийдэггүй;

-Хурлаас хийж байгаа ажлынхаа талаар тэр бүр мэдээлэл өгдөггүй, тайлангаа тавьдаггүй;

-Үндсэн ажлынхаа хажуугаар сонгуульт ажлаа хийдэг учраас цаг бага байдаг;

-иргэдийн Нийтийн Хурал дээр болон иргэдээс тавьсан санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар буцаж мэдээллэдэггүй;

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч сонгуульт үүргээ биелүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгө байдаггүйтэй холбоотой гэж үзэж байна.

Орон нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартид сонгогдсон төлөөлөгчдөд бүрэн эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх бололцоо олгох, үүргээ гүйцэтгэх хугацаанд гаргасан зардлыг зэрэгцээ төлөөлөгчөөр сонгогдон ажилласан хугацаанд алдсан орлого, нийгмийн даатгалын төлбөрийг нөхөн олгох, төлөөлөгчийн гүйцэтгэсэн ажилтай дүйцсэн урамшуулал олгож байх тухай заажээ.(7.2) Төлөөлөгчийн цалин урамшууллын тухай асуудлыг улс орнууд янз бүрээр зохицуулсан байдаг. Жишээ нь Германд төлөөлөгчөөр сонгогдсон бол сонгууль үүрэг нь сайн дурын ажил гэж үзэн урамшуулалыг хориглодог бол Швед, Литвад төлөөлөгчийн үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулсан цагт тохирсон цалин олгодог. Хорватад цалин өгөхийг хориглодог боловч төлөөлөгчийн үүргээ гүйцэтгэхэд гарсан зардлыг нөхөн олговор байдлаар олгодог байна.⁴⁴

⁴⁴ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” УБ 2018 63 дугаар тал

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн мэргэжил, боловсролын түвшинд шалгуур тогтоох асуудлыг хуульд тусгах талаар олон санал гардаг. Аймгийн төвийн сумдын хувьд нийт төлөөлөгчдийн 90-ээс дээш хувь нь дээд боловсролтой байсан бол бусад сумдын Хурлын хувьд дунджаар 50 хувь нь дээд боловсролтой үлдсэн нь бүрэн дунд, дунд боловсролтой байна. Хурлын төлөөлөгчдийн үзэж байгаагаар Засаг дарга болон бусад байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, төсвийн төсөл, түүний гүйцэтгэлийг хэлэлцэхэд иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч өөрөө өргөн хүрээтэй мэдлэг боловсролтой байх нь чухал байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг сонгох, Хурлын үйл ажиллагааг сайн байлгахад нөлөөлж байгаа нэг бэрхшээл нь тухайн баг, орон нутагт хамгийн олон ах дүү, хамаатан садантай хүн, эсхүл тухайн нэгжид нөлөө бүхий компани, аж ахуйн нэгжийн удирдлага сонгогдох магадлал өндөр байдаг. Энэ нь чадвартай, боловсролтой хүн төлөөлөгчөөр сонгогдох боломжийг хязгаарлаж, Хурлын үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлдэг байна. Жишээ нь: Сумын Засаг даргад нэр дэвшүүлэх анхдугаар хуралдаанд оролцсоноос хойш нэг ч хуралдаанд оролцоогүй төлөөлөгч ч байдаг байна.

Хурлын төлөөлөгч нь давхар ажилтай, төсөв, санхүүгийн дэмжлэг сайнгүйгээс тойрогтоо ажиллахад хүндрэлтэй байдгаас гадна улс төрийн намын зүгээс дарамт, шахалт үзүүлдэг, зарим газарт Хурлын удирдлагын зүгээс цөөнхийн төлөөлөл болсон хамтран зүтгэгчээ сонгуульт үүргээ биелүүлэхэд нь төдийлөн идэвх санаачлага гарган дэмжлэг үзүүлэхгүй байх тохиолдол байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь тухайн засаг захиргааны нэгжийн хөгжлийн бодлогыг тодорхойлох мэдлэг чадвартай, иргэдийнхээ эрх ашгийн төлөө идэвхтэй ажиллах, өндөр ёс зүйтэй хүн байх шаардлагатай юм.

Дүгнэлт

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүний 90 гаруй хувь нь улс төрийн намаас нэр дэвшигдэн сонгогдсон төлөөлөгчид байгаа одоогийн тогтолцоог өөрчлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

- Хурлын төлөөлөгч болон Хурлын даргад нэр дэвшигчдэд тодорхой шалгуурыг бий болгох. Үүнд: боловсрол, нэр дэвших насны хязгаарыг өндөрсгөх, тухайн нэгжийн байнгын оршин суугч байхыг \сонгууль болохоос 180 хоногийн өмнө шилжин очиж тухайн Хурлын дийлэнх олонх болж байгааг\ хуульчлах хэрэгтэй.

.....oOo.....

3.НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГААС БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАРИЛЦАН АЖИЛЛАЖ БАЙГАА ХЭЛБЭРҮҮД

Хууль, тогтоомжийн хүрээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бусад байгууллагуудтай дараах хэлбэрээр харилцан ажиллаж байна. Үүнд:

Нэг. Хуульд заасны дагуу үндсэн үүргээ хэрэгжүүлж ажиллана.

Хоёр. Дээд байгууллагаас шилжүүлэн өгсөн эрхийг хэрэгжүүлнэ. Мөн доод шатны Хурал болон бусад байгууллагад зарим эрх мэдлээ шилжүүлнэ.

Гурав. Өөрийн харьяаллын бус байгууллагатай гэрээний үндсэн дээр ажиллана.

Дөрөв. Засаг даргатай харилцах харилцаа

Эдгээрийг тус бүрт нь дэлгэрүүлэн авч үзвэл:

3.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль⁴⁵д заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллага нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, яам, агентлаг, түүний харьяа байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах, үүнтэй холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын илтгэл, саналыг хэлэлцэх эрхтэй.

Нутаг дэвсгэртээ сахилга, дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, энэ зорилгоор дээд шатны болон тухайн засаг захиргааны нэгжийн хуулийн байгууллага, төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, бусад байгууллага, иргэдтэй харилцан ажиллана.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийг цогцолбороор хөгжүүлэх, хөрөнгө хүч төвлөрүүлэх томоохон асуудлыг Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга нар хамтран хэлэлцэн шийдвэрлэнэ. Өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар бусад байгууллагад тавина. Аймаг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь жил бүр хийсэн ажлын тайлангаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэж, ажилдаа үнэлгээ, заавар, зөвлөмж авдаг. Хурлаас баталсан дэд хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөж байгаа шийдвэрийн хэрэгжилтийг хэлэлцэж, холбогдох саналын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс, Хүний Эрхийн Үндэсний комисс зэрэг байгууллагуудтай байнгын харилцаатай ажиллана.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан орон нутгийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, бодлого, шийдвэрээ төрийн бодлоготой уялдуулна.

⁴⁵ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн талаар Засгийн газар, холбогдох яам, агентлагийг мэдээллээр хангаж, хууль, гэрээнд заасан хугацаанд үр дүнг тайлагнаж ажиллана.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал яам, агентлагуудтай олон асуудлаар харилцан ажилладаг. Жишээ нь: гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр Хууль, зүй, дотоод хэргийн яамтай, байгаль орчныг хамгаалах, газар нутгийг тусгай хамгаалалтанд болон орон нутгийн хамгаалалтанд авах асуудлаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлаар Эрүүл мэндийн яамтай, газар өмчлөх, газар ашиглалтын асуудлаар Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд голомтыг устгах, хохирлыг арилгах, байгалийн гамшигт үзэгдэл, гал, усны аюулын үед Онцгой байдлын ерөнхий газартай, Мал эмнэлгийн газар, ашигт малтмалын олборлолт, эзэмшлийн асуудлаар Уул уурхайн яам, Ашигт малтмал, газрын тосны газартай, хяналт шалгалтын асуудлаар Улсын болон орон нутгийн Мэргэжлийн хяналтын газартай гэх мэтчилэн харилцан, хамтарч ажилладаг.

Олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцан ажиллана. Төр, сүм, хийдийн харилцааны тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагуудад зөвшөөрөл олгох, үйл ажиллагааных нь эрхийг сунгах, цуцлах ажлыг хариуцаж, тэдгээртэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд нь улс төрийн намуудын орон нутгийн хороо, зөвлөл, салбартай харилцаж, санал солилцож болно.

-Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

-Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн газар эзэмших хугацааг сунгах, тэдгээртэй холбоотой орон нутагтай холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь гадаад орны муж, хот, дүүргүүдтэй харилцаа тогтоож, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, харилцан туршлага солилцох, ажилтнууддаа сургах, нутаг дэвсгэрийн байгууллага хоорондын бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд туслах зэргээр ажиллаж байна.

Олон Улсын байгууллага, гадаадын төсөл, сангуудтай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагууд хамтран ажиллаж байна. Жишээ нь: Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн банк, Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэг, Конрад Аденаурын сан, Шведийн олон улсын агентлаг, Азийн сан, Койка, Дэлхийн зөн зэрэг олон байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт семинар явуулах зэрэг хэлбэрээр ажиллаж байна.

3.2. Дээд байгууллагаас шилжүүлэн өгсөн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн "Нэгжийн удирдлага бусад байгууллагатай харилцах" гэсэн тавдугаар бүлэгт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хууль, бусад хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан орон нутгийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, бодлого, шийдвэрээ төрийн бодлоготой уялдуулна. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн талаар Засгийн газар, холбогдох яам, агентлагийг мэдээллээр хангаж, хууль, гэрээнд заасан хугацаанд тайлагнана гэж заасан болно. Энэ хүрээнд нутгийн удирдлагаас дараах хэлбэрээр ажиллана:

-Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын сонгуулийг явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах ажлыг хариуцна.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтэд нь хяналт тавих ажлыг нутаг дэвсгэртээ хариуцна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх "Иргэний танхим"-аар хэлэлцүүлэг зохион байгуулах, ард иргэдээс тодорхой асуудлаар санал авах ажлыг хариуцна.

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал, асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулна. Сонгууль болон ард нийтийн санал, асуулгыг зохион байгуулахтай холбоотой асуудлаар Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороотой харьцаж ажилладаг.

-Улсын Их Хурал, Засгийн газраас эрх олгосноор татварын хувь, хэмжээг тогтооно. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт⁴⁶ нэмэлт, өөрчлөлт орж, "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно." гэж заасны дагуу Хурлын эрх хэмжээ өргөжсөн болно.

-Төсвийн хөрөнгөөр хийгдэх зарим ажлыг холбогдох байгууллагад хөрөнгийг шилжүүлэх замаар эрхийг шилжүүлэн гүйцэтгүүлнэ.

-Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвөөс хуваарилуулах, байгалийн баялгийн үр өгөөж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад боломжид түшиглэн хөгжих, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилах эрхийг эдэлж ажиллана.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу концесс болон үнэт цаас гаргах асуудлыг шийдвэрлэх байхаар болсон.

⁴⁶ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт 2019.11.19

3.3. Гэрээ байгуулж ажиллах хэлбэр:

Тодорхой ажил, үүргийг гүйцэтгүүлэхээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг. Төрийн бус байгууллагуудтай зарим асуудлаар хамтарч ажиллан, тэдгээрээс тавьж байгаа асуудлыг дэмжиж шийдвэр гаргаж болно. Жишээ нь: ахмадын, эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, байгаль орчныг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгуулагдсан олон төрийн бус байгууллагуудтай хамтарч, зарим ажлыг гэрээгээр хариуцуулан гүйцэтгүүлж байгаа туршлагауд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар Захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно. Хэрэглэгчийн үнэлгээг хийх хөндлөнгийн байгууллагыг судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулна.

Энэ журамд заасны дагуу зарим дэд хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа” гэсэн 73 дугаар зүйлд нутгийн удирдлагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор бусад нэгжүүдтэй дараах хэлбэрээр харилцан ажиллаж болохоор заасан.Үүнд:

- 1.бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох;
- 2.нийтийн эрх зүйн гэрээ байгуулах;
- 3.харилцан туслалцаа үзүүлэх;
- 4.бүсчилсэн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;
- 5.харилцан туршлага солилцох;
- 6.хууль тогтоомжид заасан бусад хэлбэрээр харилцах.

Засаг дарга хууль тогтоомжийг биелүүлэх зорилгоор харьяа нутаг дэвсгэрийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно.

Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй. Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлөхөөр хуульчлагдсан тул энэ эрхээ хэрэгжүүлж, шийдвэрийн

биелэлтээ хангахад нутгийн удирдлага, төлөөлөгчид, харьяа байгууллага, албан тушаалтан бүр анхаарч ажиллах хэрэгтэй юм.

Засаг захиргааны тухайн нэгжид үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дээд шатны байгууллагад харьяалагддаг аж ахуйн нэгж, албан газар, байгууллагын гаргасан шийдвэр хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрт харшилбал Засаг дарга түүнийг өөрчлөх буюу хүчингүй болгуулах саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах бөгөөд энэхүү саналыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлнэ.

Харин Хурал, Засаг даргын хууль бус шийдвэрийн улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ. Хурал, Засаг дарга гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэл, хариуцлагыг бүрэн хүлээх ёстой.



3.4.ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ-ЗАСАГ ДАРГЫН ХАРИЛЦАА

Тухайн засаг захиргааны нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь нутгийн удирдлагын харилцан хамаарал бүхий субъектүүд билээ. Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.

Нутаг дэвсгэрийн хэмжээний, бодлогын шинж чанартай аливаа асуудлыг шийдвэрлэхдээ Хурал болон Засаг дарга нар харилцан зөвшилцөн, нийт иргэдийн ашиг сонирхолд нийцсэн байх талаас нь анхаарч ажиллах чухал юм.

Хурал Засаг даргатай дараах байдлаар харилцан ажиллаж байна. Үүнд:

1.Тухайн шатны Хурал нь Засаг даргыг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

Засаг даргыг томилуулахаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал нэр дэвшүүлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн бүлэг, түүнчлэн иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч хуульд заасан шаардлага хангасан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэхээр санал гаргана. Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно.

Хуралд оролцсон иргэдийн, түүнчлэн нийт төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ. Санал хураалтаар хэн ч олонхын санал аваагүй бол

хамгийн олон санал авсан хоёр хүний талаар дахин санал хураалт явуулж олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ. Нэр дэвшүүлсэн хүнийг баг, хорооны Засаг даргаар сум, дүүргийн Засаг дарга, сум, дүүргийн Засаг даргаар аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргаар Ерөнхий сайд томилно. Дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд тухайн нэр дэвшигчийг томилохоос татгалзаж болно. Томилохоос татгалзсан тохиолдолд Хурал өөр хүний нэрийг дэвшүүлнэ. Нэр дэвшүүлсэн хүнийг ажлын таван өдрийн дотор тухайн шатны Засаг даргаар томилно.

Засаг дарга нь биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаан нөхцлийн улмаас Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлж чадахгүйгээ илэрхийлж, хүсэлт гаргасан бол дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайд түүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд дараах үндэслэлээр доод шатны Засаг даргыг огцруулна:

- Засаг дарга гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон;
- хууль тогтоомж удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;
- Хурал түүнийг огцруулах санал гаргасан;
- Засаг дарга өөрөө огцрох хүсэлтээ гаргасан;
- хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гэж дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд үзсэн бол.

Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд зохих шатны Хурлын санал, эсхүл өөрийн санаачилгаар огцруулах шийдвэр гаргана. Энэ шийдвэрээ тухайн Хуралд нэн даруй мэдэгдэх бөгөөд Хурал 15 хоногийн дотор Засаг даргад шинээр нэр дэвшүүлнэ. Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд баримтлан гаргасан тухайн Хурлын саналын дагуу Засаг даргыг огцруулах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана. Хэрэв тухайн саналыг хүлээж аваагүй бол Хурал Засаг даргыг огцруулах саналыг нэг жилийн хугацаанд дахин тавихгүй.

Засаг даргыг хугацаанаас нь өмнө чөлөөлсөн, огцруулсан бол Засаг даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд түүний бүрэн эрхийг Засаг даргын орлогч хэрэгжүүлж хариуцлагыг бүрэн хүлээнэ.

2. Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ гэж хуульчлагдсан байгаа. Хурал нь Засаг даргад үүрэг даалгавар өгнө Засаг дарга түүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын саналыг харгалзан **үйлчлэх хугацаанаас зургаан сарын өмнө** батлах үүрэгтэй.

Засаг дарга нь тухайн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар жилийн болон урт хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг бэлтгэн иргэдийн төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлж, батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

4.Тухайн нэгжийн жил бүрийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байна.

5.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллана.

6.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар Хурлаар танилцуулж ажиллана.

7.Орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэргээр захиран зарцуулах санал боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

8.Орон нутгийнхаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг өсгөн үржүүлэх болон бусад асуудлаар бодлогын бичиг баримтын төслийг боловсруулж Хурлаар батлуулан, биелэлтийг ханган, үр дүнг тайлагнаж ажиллана.

9.Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, бэлчээр, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

10.Хурлын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргаж ажиллана.

11.Нутаг дэвсгэрийнхээ байгалийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн талаар гарсан Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

12.Газрын тухай хуулийн⁴⁷ 20 дугаар зүйлд заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлаж, газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэлт гаргана. Мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д заасны дагуу сум, дүүргийн иргэдийн

⁴⁷ Газрын тухай хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн

Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.

13.Ойн тухай хуулийн ⁴⁸ 32 дугаар зүйлийн 32.2-т зааснаар Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн заасан хязгаарт багтаан сум, дүүрэг бүрээр тогтооно. Харин сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөө болон иргэдийн хэрэгцээг үндэслэн ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- үйлдвэрлэлийн ашиглалт явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн огтлолтыг байгууллага бүрээр;
- ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг байгууллага бүрээр;
- ойн нөөц бүхий аймаг, сумын иргэдийн ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын огтлолтыг баг бүрээр.

Ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ -тай мод бэлтгэх гэрээ байгуулна.

14.Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

15.Эрүүл мэндийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Боловсролын тухай хууль, Ахмад настны тухай хууль, Газрын хэвлийн тухай зэрэг олон хуульд Засаг дарга холбогдох хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнгээ Хуралд тайлагнана.

16.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хууль тогтоомж, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Засаг дарга хэрхэн зохион байгуулж байгааг шалгах, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

17.Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг

⁴⁸ Ойн тухай хууль 2012 он Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн

шийдвэрлэхтэй холбогдуулан Хурлын төлөөлөгч Засаг даргад асуулга тавьсан бол хариуг нь өгөх, шаардлагатай бол зохих шийдвэрийг гаргана.

18.Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

19.Засаг дарга нь Хурал, түүний Тэргүүлэгчдээс хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, дүнг тайлагнах үүрэгтэй. Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Тамгын газар, нутгийн захиргааны агентлагийг оролцуулан зохион байгуулна. Засаг дарга Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаар жил бүр тухайн Хуралд тайлагнана.

20.Тухайн Хурал өөрийнх нь чиг үүрэг, бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга өөрийн санаачилгаар, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын даалгаснаар холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй. Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт шаардлагатай тохиолдолд хэсэгчлэн болон бүхэлд нь хориг тавих эрх эдлэж байгаа нь Хурал, Засаг даргын эрх мэдлийн тэнцвэрийг хадгалж байгаа зохицуулалт юм.

Хоригийг тухайн шийдвэр батлагдсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан бичгээр тавих бөгөөд хориг тавих болсон үндэслэлийг тодорхой заана. Хурал хоригийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнийг нийт төлөөлөгчийн олонх нь хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн шийдвэр, тэдгээрийн холбогдох хэсгийн заалтыг хүчин төгөлдөр хэвээр үлдээнэ.

Хурлын шийдвэрт бүхэлд нь хориг тавьсан бол үйлчлэлийг бүрэн хэмжээгээр, хэсэгчлэн хориг тавьсан бол холбогдох зүйл, заалтын үйлчлэлийг уг шийдвэрийг Хурлын дарга хүлээн авснаас хойш хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзсэнд тооцно.

Засаг даргыг огцруулах санал гаргасан тухайн Хурлын шийдвэрт Засаг дарга хориг тавих эрхгүй.

Тавьсан хоригийг Хурал төлөөлөгчдийн, эсхүл иргэдийн Нийтийн Хуралд оролцогчдын олонхын саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.

Хориг нь Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хууль зүйн утгаар зогсоох боломжийг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээ юм.

21.Аймаг, Нийслэлийн Засаг дарга нь аймаг, сумын болон нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулах эрхтэй болсон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах үндэслэлд:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 т зааснаар

-анхдугаар хуралдааныг товлон зарласнаас хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдааныг хуралдуулж Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй;

-хуульд заасан хугацаанд төсвөө батлаагүй;

-хуралдаан зарлаж товлосон хугацаанаас хойш хуралдахгүй 60-аас дээш хоног өнгөрсөн бол тухайн Хурлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тараах саналыг Засгийн газарт оруулна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Засаг даргад нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх, ажлынх нь тайланг сонсож, үнэлэлт өгөх, харин Засаг даргаас Хурлын шийдвэрт хориг тавих, Хурлыг тараах санал гаргах эрхтэй болсон нь Хурал, Засаг даргаас бие биенийхээ ажилд хяналт тавих, эрх мэдлийг тэнцвэржүүлж байгаа хуулийн зохицуулалт юм.

22.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн шаардсан мэдээ, судалгаа, холбогдох материалыг Засаг дарга, түүний Тамгын газар болон харьяа байгууллагууд бэлтгэж өгнө.

23.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль⁴⁹ болон Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2020 оны 206 дугаар тогтоол⁵⁰ ын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”- д заасны дагуу үнэлгээ хийх үүргийг Хурал, Засаг дарга аль аль нь хүлээж байгаа. Дээрх хуульд заасан “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” төлөвлөлтийн баримт бичигт туссан орон нутгийн үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг огцруулах үндэслэл болсныг аль аль нь анхаарч ажиллах хэрэгтэй юм.

24.Хурлын шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ тухайн Засаг дарга хангалтгүй биелүүлсэн гэж Хурал дүгнэсэн бол түүнд хариуцлага хүлээлгэнэ.

Хурлын төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй нь Засаг дарга хангалтгүй ажилласан гэж үзэн гарын үсэг зурсан бол Хурал 15 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж, Засаг даргыг огцруулах, эсхүл түүнд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдад нийт төлөөлөгчдийн олонхын саналаар тавьж шийдвэрлүүлнэ.

Ерөнхий сайд, дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргад тухайн шатны Хурлын санал, эсхүл өөрийн санаачилгаар дараах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

1.сануулах;

2.үндсэн цалинг 20 хүртэлх хувиар гурван сар хүртэлх хугацаагаар хасах хариуцлагыг шат дараалан хэрэглэнэ.

⁴⁹ “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” Төрийн мэдээлэл сэтгүүл 2020 оны №1

⁵⁰ Монгол Улсын Засгийн газрын 2020.12.09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хооронд үүссэн маргааныг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хооронд үүссэн маргааныг нутгийн удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус шийдвэрлэнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны явцад сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын хооронд үүссэн маргааныг харъяалах дээд шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол Ерөнхий сайд тус тус шийдвэрлэнэ.

“Засаг дарга хууль, тогтоомжоор олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид саад учруулж үл болно.” гэж Хурлын байгууллагыг хариуцлагажуулж өгсөн болно.

Хурлын дарга болон Засаг дарга нь тухайн нэгжээ төлөөлөн гадаад, дотоодын зочин, төлөөлөгчийг хүлээн авах, нутаг дэвсгэрийнхээ хэмжээний томоохон баяр ёслолын арга хэмжээ, хурал, зөвлөлгөөн, үзэсгэлэн зохион байгуулах ажлыг хамтран зохион байгуулна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдтэй байнгын харилцаатай ажиллана. Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авна, шийдвэрлэнэ, хариуг өгнө, өөрийн гаргасан шийдвэрээ сурталчлана, үйл ажиллагаагаа тайлагнана.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зарим үзүүлэлт⁵¹

Хүснэгт 17

Гол үр дүнгүүд	2019 он		2015 он		Өөрчлөлт	
	Улаанбаатар хот	Орон нутаг	Улаанбаатар хот	Орон нутаг	Улаанбаатар хот	Орон нутаг
Тойргоос сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид иргэдийг төлөөлж чадаж байна гэж үзэж буй	36.5%	35.7 %	33.6%	46.0%	2.9%	-10.3%
ИТХ -ын талаар ерөнхий ойлголттой иргэд	43.2%	51.8 %	68.0%	29.0%	-24.8%	22.8%
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Орон даяар гардаг ТВ/	47.5%	16.5 %	53.0%	18.6%	-5.5%	-2.1%
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Орон нутгийн ТВ/	20.0%	29.4 %	7.2%	22.0%	12.8%	7.4%
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Сошиал суваг -facebook, twitter гэх мэт/	30.5%	24.8 %	-	-	-	-
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Сонин, бусад хэвлэмэл материал/	17.2%	10.4 %	10.8%	11.3%	6.4%	-0.9%

⁵¹ “Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын талаарх иргэд олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан” 2019 khural.mn цахим хуудас

Аймаг, нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзэж буй	41.7%	52.7 %	40.8%	45.3%	0.9%	7.4%
Аймаг, нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлдэг гэж үзэж буй	45.3%	58.4 %	48.4%	45.5%	-3.1%	12.9%
Аймаг, нийслэлийн ИТХ -аас гаргасан шийдвэрүүдийг нэрлэж чадаж буй	50.5%	61.6 %	34.0%	23.0%	16.5%	38.6%
Аймаг, нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагааг "маш сайн" болон "зарим талаараа сайн" гэж үнэлсэн	16.6%	24.3 %	18.4%	27.3%	-1.8%	-3.0%
Сум, дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзэж буй	41.1%	66.2 %	45.6%	57.6%	-4.5%	8.6%
Сум, дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлдэг гэж үзэж буй	41.7%	62.7 %	36.0%	54.6%	5.7%	8.1%
Сум, дүүргийн ИТХ -аас гаргасан шийдвэрүүдийг нэрлэж чадаж буй	48.1%	71.6 %	19.0%	34.6%	29.1%	37.0%

Дүгнэлт

- Нутгийн өөрөө удирдах байгууллагаас бусад байгууллагуудтай харилцан ажиллах хэлбэрүүд холбогдох хууль тогтоомжоор баталгаажсан.
- Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд санхүү, өмч, хөрөнгө хомс, байгаль орчныг хамгаалах зарим эрх хязгаарлагдмал байгааг өөрчлөн, төвлөрлийг сааруулах хэрэгцээ өндөр байна.

...oOo...



shutterstock.com · 1386674981

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХЯНАЛТ

4.1.Хяналт, үнэлгээ

Бодлогын залгамж чанарыг хангасан, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, нөөц боломжтой уялдсан, нээлттэй ил тод боловсруулж, үр дүнтэйг тооцоход хүндрэлгүй баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтэд, хяналт шинжилгээ, үнэлгээг зөв хийж ажиллах нь өнөөгийн чухал асуудлын нэг юм.

Монгол Улс хөгжлийн бодлогыг төлөвлөх, түүний хэрэгжилтийг хангуулах зорилгоор сүүлийн жилүүдэд илүү анхаарч ажиллах болсон. Энэ зорилгоор Монгол Улсын Их Хурал 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, 2020 онд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг тус тус баталж, Засгийн газраас дээрх хуулиудыг хэрэгжүүлж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” бусад хөтөлбөр, журмуудыг батлан ажиллаж байна.

Батлагдсан хууль, хөтөлбөр, бусад шийдвэрийн биелэлтийг хангахад хяналт, үнэлгээ хийх нь ажлыг эрчимжүүлэх, гарсан үр дүнг тооцох, ололт, амжилт, алдаа дутагдлыг олж, засаж сайжруулахад ихээхэн үр дүнтэй хэрэгсэл юм.

Нутгийн удирдлагын байгууллагын нэг гол үүрэг нь хууль, тогтоомж, өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах, хэрэгжилтийн байдалд хяналт тавих ажил юм. Тухайн нутаг дэвсгэртээ өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хянахаас гадна Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан даалгавар, зөвлөмж, Засгийн газрын тогтоолууд, яамдын сайд нарын баталсан журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хянан шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

“Чиг хандлагын талаарх мэдээллийг зүгээр л хараад Засгийн газрын хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэх талаар мэдэх боломжгүй байдаг” Чанна Сора.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулахын тулд “Хяналт үнэлгээ хийх журам”-ыг батлан мөрдөх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудаа сургалтанд хамруулж, энэ ажилд мэргэшлүүлэх шаардлагатай юм. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг батлан мөрдөн ажиллаж байгаа.

Тухайн хөтөлбөр, үйл ажиллагааны тайланг үнэлгээний дүгнэлтгүйгээр танилцуулсан тохиолдолд шийдвэр гаргагчид болон бусад холбогдох хүмүүс тодорхой арга хэмжээний хүрээнд бий болсон амжилт эсхүл алдаа дутагдлын талаар буруу дүгнэлт гаргах

эрсдэлтэй байдаг байна. Тиймээс дээд байгууллагын болон өөрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулан ажиллах үүрэгтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хувьд хяналт шинжилгээ, үнэлгээний талаар мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай юм.

Хяналт шинжилгээ, үнэлгээ гэж юуг хэлэх вэ?

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь төрийн байгууллагуудын ажлыг үр дүнд хүргэх арга замыг сайжруулахад хэрэглэдэг удирдлагын хүчирхэг арга хэрэгсэл.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн³⁹ 4 дүгээр зүйлийн 4.1.13-т “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа энэ хуульд заасан зарчмыг баримталсан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын чиг үүргээ хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн цогц үнэлгээг; хэлнэ гэж тодорхойлсон байна.

“**Хяналт-шинжилгээ**” гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг хэлнэ.

“**Үнэлгээ**” гэж байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг хэлнэ.⁵²

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь 2 өөр чиг үүрэгтэй, өөр өөр асуулт тавьж, мэдээлэл болон шинжилгээний үр дүнг өөр байдлаар ашигладаг боловч харилцан бие биенээ дэмжин нөхөж байдаг.

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь хоорондоо ялгаатай бөгөөд үнэлгээ нь тодорхой цаг хугацаанд нэг удаа хийж гүйцэтгэдэг ажил бол хяналт шинжилгээ нь байнгын тасралтгүй үйл ажиллагаа юм.

Хяналт шинжилгээ, үнэлгээний харилцан нөхөх байдал

Хүснэгт №18

№	Хяналт шинжилгээ	Үнэлгээ
1	Хөтөлбөрийн зорилгыг тодорхой болгох	Хүлээгдсэн үр дүнд яаж хүрэв, эсхүл яагаад хүрч чадсангүй гэдэгт дүн шинжилгээ хийх
2	Үйл ажиллагаа болон нөөцийг зорилготой уялдуулах	Үр дүнд хүрсэн ажлын төлөвлөгдөөгүй нөлөөг үнэлэх
3	Зорилгуудыг шалгуур үзүүлэлтээр	хэрэгжилтийн явцыг хянах

⁵² “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол

	илэрхийлж, түвшинг тодорхойлох	
4	Мэдээлэл цуглуулж, хүрсэн үр дүнг зорилтот түвшинтэй харьцуулах	Төлөвлөж байгаа үр дүнд дүгнэлт хийх
5	Удирдлагад явцын талаар мэдээлж, хүндрэлийн талаар анхааруулах	Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар танилцуулж, сайжруулах талаар зөвлөмж гаргах

Хяналт, үнэлгээ нь оролцогч талуудын шаарддаг хариуцлагын тогтолцоонд анхаарал хандуулахын зэрэгцээ тавьсан зорилт, зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай мэдээллийг төрийн захиргааны удирдлагуудад өгч, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хэрэгтэй аливаа залруулгын үндэслэлийн талаар хангалттай баримт нотолгоогоор хангадаг.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т зааснаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны **зорилго** нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино” гэсэн болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Үүнд:

- 1.мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;
- 2.зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;
- 3.биелэлтийн үр нөлөөг үнэлэх;
- 4.гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;
- 5.төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;
- 6.биелэлтийн түвшинг үнэлэх;
- 7.бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах зэрэг болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүрдээ дээрх үе шатны ажлыг заавал бүрэн гүйцэтгэж, дүнг аль нэг хуралдаанаараа хэлэлцэн зөвлөмж, шийдвэр гаргана.



Үнэлгээ нь явцын, эцсийн, хөндлөнгийн, хэрэглэгчийн гэсэн хэлбэртэй байдаг.

1.“үр дүнд суурилсан **явцын** үнэлгээ” гэж хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.“үр дүнд суурилсан **эцсийн** үнэлгээ” гэж бодлогын баримт бичиг хэрэгжиж дууссаны дараа хэрэгжилтийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх, эсхүл зогсоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

3.“**хөндлөнгийн** үнэлгээ” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг;

4.“**хэрэглэгчийн** үнэлгээ” гэж захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг хэлнэ.

Үнэлгээ нь хэрэгжиж буй болон хэрэгжсэн төсөл, хөтөлбөр эсвэл бодлого, түүний загвар, хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлж дүгнэх ажиллагаа юм. Үнэлгээний зорилго нь төсөл, хөтөлбөр, бодлогын зорилгын уялдаа холбоо, хэрэгжилт, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, үр нөлөө болон цаашид тогтвортой байх эсэхийг тодорхойлдог.



Үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Шинжилгээ нь тухайн тогтсон цаг хугацаанд (болон цаг хугацааны явцад) холбогдох зорилтот түвшин болон үр дагавартай харьцангуйгаар зорилтот түвшин бодлого, хөтөлбөр эсвэл төслийн явцыг харуулах мэдээлэл өгдөг. Энэ нь зорьж буй зорилгыг дүрслэн тайлбарласан байна.

Үнэлгээ нь зорилтот түвшин болон үр дагаварт яагаад хүрч чадаагүй талаар мэдээлэл өгч, шалтгаан, үр дагаврын асуудалд анхаардаг.

Үнэлгээг хийхийн өмнө дараах зүйлд анхаарч, бэлтгэлийг урьдчилан сайн хангавал, үнэлгээний үр дүнд эерэгээр нөлөөлдөг.

Үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг дараах хүчин зүйлийг тооцоолсны дараа боловсруулж, үнэлгээний ажилд оролцох багаар хэлэлцүүлэн батлах, багийн ахлагч түүний хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулахад голлох үүргийг гүйцэтгэнэ.



Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь явцын дунд авч буй арга хэмжээнд гажуудал гарсныг илтгэх (жишээ нь, зорилтот бүлэг үзүүлж буй үйлчилгээг авахгүй байх, зардал хэтэрхий хурдан өсөх, шинэ санаачилга нэвтрүүлэхийг эрс эсэргүүцэх гэх мэт) дохио өгөх үед түүнийг төгс болгох үүднээс хийгдэнэ. Үнэлгээ хийх боломжтой сайн мэдээлэл нь хяналт-шинжилгээний бодит байдал болон чиг хандлагыг тодруулахад чухал ач холбогдолтой. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ нь хүлээж байсан үр дүнтэй харьцуулахад төсөл, хөтөлбөр эсвэл бодлогыг хэр сайн хэрэгжүүлснийг харуулсан мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх тогтмол үйл ажиллагаа юм.

Хэрэгжилтийн хяналт-шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд:

- Хэрэгжүүлэхээс өмнөх үеийн нөхцөл байдал, хүндрэлтэй асуудлыг тодорхойлох;
- Үйл ажиллагаа ба шууд бий болох гарцын харьцуулалт хийх үзүүлэлтүүд;
- Орц, үйл ажиллагаа, шууд бий болох гарцын талаар мэдээлэл цуглуулах;
- Орцын нийлүүлэлтийн талаар системтэй тайлагнах;
- Гарцын үйлдвэрлэлийн талаар системтэй тайлагнах;
- Хэрэгжилттэй шууд холбоотой байх; (эсвэл цуврал хэрэгжилт)
- Хөгжлийн үр дүнгийн илүү өргөн хүрээтэй асуудлын талаар бус харин захиргааны болон удирдлагын талаарх мэдээллээр хангах;

Үр дүнгийн хяналт-шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд: (бодлого, хөтөлбөр, төсөл, стратеги зэргийн хяналт-шинжилгээнд өргөн хүрээнд хэрэглэгдэнэ)

- Хэрэгжүүлэхээс өмнөх үеийн нөхцөл байдал, хүндрэлтэй асуудлыг илэрхийлэх суурь тоо мэдээ;
- Үр дагаврын шалгуур үзүүлэлтүүд;
- Гарцын талаарх мэдээлэл цуглуулах; Эдгээр нь үр дагаварт хүрэхэд хувь нэмэр хэрхэн оруулдаг болох;
- Өөрчлөлтийн талаарх оролцогч талуудын санаа бодолд илүү анхаарах;
- Үр дагаврыг бий болгох явцын ахиц өөрчлөлтийн талаарх чанарын болон тоон мэдээллийг системтэй тайлагнах;
- Стратегийн түншүүдтэй холбоотойгоор хийх;
- Хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд түншлэлийн стратегийн амжилт эсвэл алдааны талаарх мэдээллийг хуримтлуулах зэрэг болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын шийдвэр нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг нягтлан тогтоох, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, төлөвлөсөн үр дүнд хүрч хэрэгжээгүй бол түүнийг засаж, залруулах чиглэл, арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд бодлогын шинэ зорилтыг дэвшүүлж, холлбогдох албан тушаалтанд танилцуулах, шийдвэр гаргах үйл ажиллагааг бодлогын хувилбар, санал, дүгнэлт, зөвлөмжөөр дэмжихэд чиглэгдсэн байна.

Хяналтыг хэрэгжүүлэгч субъектууд:

- Яам, агентлаг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын ажлын хороо, ажлын хэсэг, төлөөлөгчид, Засаг дарга, түүний Тамгын газар
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, түүний орон нутгийн нэгжүүд
- Төрийн болон орон нутгийн аудитын газар
- Авлигатай тэмцэх газар
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд
- Төрийн бус байгууллагууд
- Иргэд

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдах бодлогын бичиг баримтын төслийг боловсруулах, батлагдсан бичиг баримтуудад тодорхой хугацаанд үнэлгээ хийж байх, энэ ажилд

иргэдийн оролцоог хангаж байхаар заасан билээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хяналт, үнэлгээ хийх зардлыг тухайн жилийн үйл ажиллагааны төсөвтөө тусгах, төлөөлөгчид, мэргэжилтнүүдийг үнэлгээ хийх чиглэлээр сургаж бэлтгэх, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, энэ ажилд мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах журам, аргачлалыг баталж мөрдөх зэрэг бэлтгэлийг хангах шаардлагатай.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах баримт бичгийн төслийг хууль болон журамд заасны дагуу бэлтгэн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах, биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж, заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ. \хүснэгтээр харуулав\

**Аймаг, нийслэлийн Засаг даргаас биелэлтийг тооцох,
үнэлгээ хийх баримт бичгүүд, тайлагнах хугацаа**

Хүснэгт №19

№	Баримт бичгийн нэр	Хийгдэх ажил	хугацаа
1	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Хяналт, шинжилгээ, үнэлгээ	Жил бүр 02.20
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	хяналт-шинжилгээ, үнэлгээ	Жил бүр 02.20
3	аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	02.20
4	Үндэсний хөтөлбөр, урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийн хугацаа дуусмагц эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж		02.10
5	хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт		01.15 07.01

6	Стратеги төлөвлөгөөний биелэлт		04.01
7	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		04.01
8	Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан		04.01
9	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт		02.01

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба болон Засаг даргын Тамгын газраас жил бүрийн 07дугаар сарын 01 болон дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор гарган хурлаар хэлэлцүүлэн, ажлын ололт дутагдал, цаашид анхаарах асуудлын талаарх саналын хамт холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт дараахь баримт бичиг хамаарна.Үүнд:

- 1.Монгол Улсын хууль;
- 2.Улсын Их Хурлын тогтоол;
- 3.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;
- 4.Ерөнхийлөгчийн зарлиг;
- 5.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;
- 6.Засгийн газрын тогтоол;
- 7.Ерөнхий сайдын захирамж;
- 8.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;
- 9.Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг болно.⁵³

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ “Аргачлал батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 5,6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”-ыг тус тус ашиглах хэрэгтэй болно.

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараахь аргачлалаар тооцно:

⁵³ “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол

а.“бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

б.“хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

в.“хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

г.“хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

д.“хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэж үнэлнэ.

Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөгдөхөөр иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийн тайланг мөн бэлтгэж, үргэлжлүүлэн мөрдөх, нэмэлт, өөрчлөлт оруулах, эсвэл хүчингүй болгох саналтайгаар холбогдох хуралдаанаар хэлэлцүүлнэ.

**Сум, дүүргийн Засаг даргаас биелэлтийг тооцох,
үнэлгээ хийх баримт бичгүүд, тайлагнах хугацаа**

Хүснэгт №20

№	Баримт бичгийн нэр	Хийгдэх ажил	хугацаа
1	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт	Жил бүр 02.01
2	сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Хяналт, шинжилгээ	Жил бүр 02.01

Аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гаргаж Хурлаар хэлэлцүүлэхдээ дараах тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл

ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6, 7 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мөн журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ. Хавсралтад:

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар:

- 1.тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- 2.төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
- 3.байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан;
- 4.шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ;
- 5.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
- 6.байгууллагын шударга байдлын үнэлгээ.

Захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь хийх, эрдэмтэн, судлаачдыг үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг мөн өөрийн байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулна.

Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан гурван яам, нутгийн захиргааны таван байгууллага тус бүрд 20.0 сая хүртэл төгрөг, гурван яамны Төрийн нарийн бичгийн дарга, таван аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргыг 1 сарын үндсэн цалинтай нь тэнцэх мөнгөн урамшуулал олгогдохоор хуульчлагдсан болно.

Харин Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" төлөвлөлтийн баримт бичигт туссан орон нутгийн үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг **огцруулах** үндэслэл болсныг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга, түүний Тамгын газар анхаарч ажиллах нь чухал юм.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны **үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан**, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан яамны Төрийн нарийн бичгийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргыг Төрийн албаны тухай хуулийн 45.1-д заасны дагуу **албан тушаал бууруулах** саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргахаар заасан болно.

Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аливаа үнэлгээний ажлыг зохион байгуулахын өмнө үнэлгээ хийх асуулт болон шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлох нь чухал. Тухайн үнэлгээ хийх байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажлын үр дүнг бодитоор үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож чадвал үнэлгээний үр дүнд эерэгээр нөлөөлнө.

Хяналт, шинжилгээ хийхийн тулд холбогдох мэдээллийг нэгтгэн цуглуулна. Үнэлгээ хийх асуултаа боловсруулна, шалгуур үзүүлэлт, хэмжүүрээ тогтооно.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20-д “шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлт гэж тодорхойлсон байна.



“Шалгуур үзүүлэлт” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ. Харин **“суурь үзүүлэлт”** гэж үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг хэлнэ.

Шалгуур үзүүлэлтийг боловсруулахын тулд үр дүнгийн талаар тодорхой ойлголттой болох хэрэгтэй. Шалгуур үзүүлэлтүүдэд орц, гарц, үр дүнгийн хэмжүүрүүд байж болно.



Шалгуур үзүүлэлт нь дараах зүйлсийг агуулсан байх ёстой. Үүнд:

- тоон мэдээ, баримт;
- чанарын мэдээ баримт;
- цаг хугацаатай холбоотой мэдээ баримт.

Тоон шалгуур үзүүлэлт нь тодорхой тоогоор \тоо, дундаж эсвэл голч\ эсвэл хувиар илэрхийлэгдэнэ.

Чанарын шалгуур үзүүлэлт нь зорилтот түвшин нь чанарын үнэлгээгээр хэмжигдэнэ. Чанарын шалгуур үзүүлэлт нь институцын үйл явц, хандлага, итгэл үнэмшил, идэвх, хувь хүний зан үйлийн талаар мэдээлэл өгнө.

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:



Дэлхийн банкны “Нийгмийн эгэх хариуцлага” төслийн хүрээнд 4 төрийн бус байгууллага 2017 онд Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт холбогдох хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн юм. Эдгээр байгууллагууд үнэлгээ хийх асуулт, үнэлгээний шалгуур үзүүлэлтээ хэрхэн томъёолсныг жишээ болгон танилцуулья.

1.“Стратеги академ”-иас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хоёрдох хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ үнэлгээний дараах 2 асуултыг бэлтгэсэн.

Үнэлгээ хийсэн жишээ

Хүснэгт №21

№	Үнэлгээний асуулт	Шалгуур үзүүлэлт
1	Сэтгэцийн эмгэгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж анхан, дунд, сүүлийн үе шатанд ямар байна вэ?	Эмнэлэгийн байгууллагын орчин бүрдүүлэлт-оношлогоо, эмчилгээ (өрөө, ор, эм хэрэгсэл, эмч мэргэжилтэн) -Нийгэм хамт олонд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж (гэр төвийн үйл ажиллагаа) Эрүүл мэндийн байгууллагаар сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээ авсан иргэдийн хувь -Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч мэргэжилтний эзлэх хувь -Эмнэлэгийн байгууллагаас сэтгэцийн эмгэгийн чиглэлээр авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл
2	Сэтгэцийн эмгэгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт ямар байна вэ?	Сэтгэцийн эмгэгийн талаарх ойлголт -Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн талаарх ойлголт -Иргэд, байгууллага, хамт олон, гэр бүл дэх сэтгэцийн эмгэгтэй хүнд хандах хандлага, харилцан тусалцах хэлбэр

2.“Тунгаамал төв” төрийн бус байгууллагаас Боловсролын үндэсний хөтөлбөр, сургуулийн орчны стандартын хэрэгжилтэд Нийслэлийн 3 дүүргийн 6 сургууль дээр үнэлгээ хийсэн.

Үнэлгээний асуултууд:

1.Эцэг эх, сурагчид, багш нар, сургуулийн удирдлага, төрийн байгууллагууд сурах орчны нөхцөл байдлыг хэрхэн үнэлж байна вэ?

2.Батлагдсан стандартуудын хэрэгжилтийн түвшин ямар байна вэ, нөлөөлж буй хүчин зүйлүүд?

3.Сурах орчин нь сургалтын чанарт нөлөөлж байна уу?

4.Сурах орчинг сайжруулахад зарцуулж буй төсөв ямар байна вэ?

Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

- Оролцогч талуудын (эцэг эх, сурагчид, багш нар, удирдлагын) сургуулийн орчны талаарх сэтгэл ханамжийн түвшин
- сургуулийн орчны аюулгүй байдлын түвшин
- Сурах орчин сайнаар үнэлэгдсэн сургуулийн сурагчдын сурлагын чанарын хувь
- Төсөв, хөрөнгө оруулалтын хэмжээ

Үнэлгээ хийгдээд дууссаны дараа дүнгээ гаргахад сурах орчин нь хоёр өөр нийслэлийн төвийн болон захын дүүргийн сурагчдын сурлагын чанарын байдалд онцын ялгаа байгаагүй нь сонирхолтой байсан бөгөөд бид үнэлгээний шалгуур үзүүлэлтээ оновчтой боловсруулж чадаагүй байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэсэн. Сурлагын чанарт анхаарахаасаа илүүтэй сурагчдын эрүүл мэндийн байдалд анхаарсан бол илүү үр дүнтэй үнэлгээний дүн гарах байсан болов уу гэж үзсэн болно.

Дээрх жишээнээс дүгнэлт хийж үнэлгээний асуулт, шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа багаараа маш сайн ярилцах, гарах үр дүнг тооцоолох, холбогдох материалуудыг сайн цуглуулж, судлах шаардлагатайг анхаарах хэрэгтэй.

Шалгуур үзүүлэлтийг үнэлэх хяналтын хуудасны загвар

Хүснэгт №22

- | |
|--|
| <ol style="list-style-type: none">1. Үр дагаврыг аль болох шууд илэрхийлж байна уу?2. Объектив хэмжигдэхүүнийг хангахуйц тодорхой байна уу?3. Хамгийн хэрэгцээтэй, зардал багатай мэдээлэл цуглуулах аргыг хэрэглэж чадсан уу?4. Үр дагаврын хувьд өөрчлөгдөх мэдрэмжтэй, харин өөрчлөлтөөс харьцангуй хамаарал багатай байна уу?5. Үр дагаврыг тайлагнах үед шаардлагын дагуу бүлэглэн задалсан байна уу? гэх мэт |
|--|

Шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо дээрх үзүүлэлтийг ашиглаж болохоос гадна өөрсдөө зохих үзүүлэлтийг гаргаж болох юм.

Хэмжүүрийн харгалзах түвшинг орц, гарц, үр нөлөө гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ.

Хэмжүүрт тавигдах шаардлага

- Ач холбогдолтой байх- хамааралтай буюу чухал утга санааг хэмжих боломжтой байх;
- Найдвартай байх- ижил нөхцөлд давтан хийсэн хэмжилт адил үр дүнг үзүүлэх;
- Өөрчлөгдөхгүй тогтмол байх;
- Хэмжүүрийг удаан хугацаагаар хэрэглэх боломжтой байх;
- Практикт хэрэглэх боломжтой байх- хэмжүүрийг хэрэглэхэд хялбар байх;
- Өөрчлөлтийг түргэн харагдуулдаг байх;
- Хэмжүүр нь өөрчлөлтийг аль болох богино хугацаанд харах боломжтой байх;
- Хэмнэлттэй байх - боломжит зардлаар тодорхойлж болохоор байх зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг шалгах хэрэгсэл

№	Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Практикт турших
3	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
5	Зардал	Зардлын тооцоо хийх
6	Харилцан уялдаа	Төслийн уялдаа холбоог шалгах

Шалгуур үзүүлэлтийг дээрх шалгах хэрэгслэлээр шалган хамгийн зөв хувилбараар боловсруулж чадвал үнэлгээний үр дүн бодитой, үнэн зөвд нийцсэн байдлаар гарах болно.

....oOo...

⁵⁴ "Хууль тогтоомжийн тухай хууль –аргачлал, гарын авлага" Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы хамтын ажиллагаа төсөл 2016 он



4.2. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн засаг захиргааны нэгжийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, хэрэгжилтийн байдалд хяналт тавихаар хууль, тогтоомжоор ихээхэн үүрэг хүлээсэн байгууллага билээ.

Шинээр байгуулагдаж байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд маань өмнөх сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжиж байсан, удаан хугацаанд мөрдөгдөхөөр батлагдсан бодлогын бичиг баримтууд, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж, засварлах, одоогийн бүрэн эрхийн хугацааны бодлогоо тодорхойлох шаардлагатай юм.

Нутгийн өөрөө удирдах байгууллагаас тухай орон нутгийнхаа хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн үндэслэл нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”;

2.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

3.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

4.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”

5.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын хавсралтаар 6 аргачлал батлагдсан болно.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын нэг гол үүрэг нь хууль, тогтоол, өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах, хэрэгжилтийн байдалд тавих хяналт юм.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн³⁹ Төрийн хяналт, шалгалтын тогтолцоо, хүрээ гэсэн 3 дугаар зүйлийн 3.1дэх хэсэгт “Төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын

хяналт шалгалт, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ” гэж заасан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ үүргээ хэрэгжүүлж тодорхой төлөвлөгөөтэйгээр, хууль эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

-Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэртээ өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтээс гадна Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан, нутгийн өөрөө удирдах байгууллага биелэлтийг нь хянана, эсхүл хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэнэ гэж заасан холбогдох хуулиудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан даалгавар, зөвлөмж, Засгийн газрын тогтоолуудын хэрэгжилтийг хангах талаар хийж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар Засаг дарга, өөрийн нутаг дэвсгэр дэх тухайн засаг захиргааны байгууллагад харьяалагдах байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын мэдээллийг сонсох, илтгэл, сонсголыг хэлэлцэх, дээд шатны Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийнхээ холбогдох бүх байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах эрхтэй.

-Холбогдох хууль, тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, яам, агентлагаас баталсан тогтоол, журмын хэрэгжилт, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангахтай холбогдуулан Хурлын төлөөлөгчдөөс тавьсан асуулт, асуулгын хариуг хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл зохих шийдвэр гаргаж ажиллана.

-Тухайн шатны Засаг даргаас дээрх байгууллагуудаас баталсан хууль, бусад шийдвэрийн биелэлтийг хэлэлцэх, хянах, үнэлэлт дүгнэлт өгөх, үр дүнг холбогдох байгууллагад тайлагнах ажлыг зохион байгуулна.

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналтын гол хэсэг нь өөрийн нэгжийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, түүний үр дүнгийн байдалд тавих хяналт юм. Төсвийн төслийг боловсруулахдаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх, төсвөөс санхүүжих бүх байгууллагын төсвийг аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөвт тусгасан байх зармуудыг баримталсан эсэхийг хянах хэрэгтэй. Жишээ нь: баг, хорооны үйл ажиллагааны зардлыг харьяалах сум, дүүргийн төсөвт тусгайлан тусгасан байх ёстой.

Төсвийн төлөвлөлтийг тооцоолол, үндэслэл сайтай бэлтгэж, талуудын саналыг тусган, оролцоог ханган боловсруулах нь төслийг батлах, хуваарилах, зарцуулахад хүндрэл бага байх болно. Энэ зорилгоор дараах ажлыг хийх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

А.Жил бүрийн төсвийн төлөвлөгөөний төсөлд шаардлагатай санхүүжилтийг тусгуулах талаар холбогдох Ажлын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж \жил бүрийн 5-6 дугаар сард\ саналаа урьдчилж хүргүүлэх;

Б.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан хөтөлбөр бусад бодлогын баримт бичигт тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгуулах саналыг бэлтгэж хүргүүлэх;

В.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зардал, түүний дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг чадавхжуулах сургалт, семинар, хэлэлцүүлэг хийх, ном, сэтгүүл, гарын авлага захиалах, төлөөлөгчийн Хуралдаа болон тойрогтоо ажиллахад шаардагдах санхүүжилтийг тусгуулах;

Г.Төсвийн төслийг жил бүрийн 8-9 дүгээр сард холбогдох Ажлын хороо, Тэргүүлэгчид, Зөвлөлийн хуралдаанаараа хэлэлцэж, нэмэлт, өөрчлөлт оруулах, төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх санал, дүгнэлийг бэлтгэн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж байх;

Д.Төсвийн тухай хуульд заасан хугацаанд төсвийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, Аудитын дүгнэлтийг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

Е.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, төсөв батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгах, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар Засаг дарга жил бүр нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлж байгаа эсэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төлөөлөгчид хяналт тавьж ажиллах нь чухал юм.

Ё.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн буцаан төлөлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, өр авлагын шийдлийн байдлыг хагас жил тутам хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган ажиллах;

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зарим аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2017-2019 онд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд төлөөлөгчид, иргэдийн оролцоотойгоор хяналт тавих төслийг хэрэгжүүлж зохих үр дүнд хүрсэн туршлагауд байна. Жишээ нь:

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Завхан аймгийн Их-Уул, Баянхонгор аймгийн Заг, Ховд аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах зорилготой “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо хяналт” төслийг хэрэгжүүлжээ.

Төслийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг нь мэдээлж байх “Иргэний хяналтын зөвлөл”, “Мэдээллийн хөтөч баг”-ээрэг иргэдийн хяналтын бүтэц байгуулагдан ажиллуулж, хяналт үнэлгээ хийх журмыг батлан, мөрдүүлж ажилласан байна. Дээрх төслийг хэрэгжүүлснээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажилд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгдэж тухайн ажил, үйлчилгээ чанартай техникийн тодорхойлолтын дагуу хийгддэг болсны дээр, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд иргэд ажил хэрэгч санал өгч, ажлын жагсаалтад эрэмбэлэн тусгуулах, хэрэгжилтэд үнэлгээ хийх хяналт тавихад оролцдог болсон байна. Иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн талаар тодорхой мэдээлэлтэй

*болж, Хяналтын багийн хийсэн хяналт үнэлгээ нь ажлын чанар, гүйцэтгэлийн хугацаанд зохих нөлөө үзүүлсэн байна.*⁵⁵

Ж.Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүний зарцуулалтын байдалд оршин суугч иргэдийн эрх ашгийн өмнөөс хяналт тавьж ажиллана.

З.Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлого, дансны үлдэгдлийг тухайн нэгжийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэхэд зарцуулж болох эрх нь нээгдсэн байгаа тул төсвийн орлогын бүрдүүлэлт дээр тавих хяналтаа сайжруулах хэрэгтэй юм.

Е.Төсвийн жилийн явцад шинээр бий болсон орлого, зээл, хандив, тэдгээрээр санхүүлсэн үйл ажиллагааны зарлагын талаар мэдээлэл сонсох, хяналт тавих;

Шинэ хуулиар төсвийн бус хөрөнгөөр сан байгуулж чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болохоор хуульчлагдсан нь орон нутаг шаардлагатай асуудлаа иргэдийнхээ оролцоотойгоор шийдвэрлэх боломжийг бүрдүүллээ. Гадаадын болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өгсөн хандив, тусламж, эд материал, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал, хяналтын ил тод байдлыг хангах асуудал иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас анхаарч журамлах хэрэгтэй юм.

Ё.Аймаг, нийслэл концесс, үнэт цаас гаргаж болохоор хуульчлагдсан байгаа. Хуулийн энэ шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ Хурлын зүгээс санхүүгийн нөөц, эргэн төлөх боломж, хугацаа, зайлшгүй гаргах шаардлага, үндэслэл, тооцоо, судалгаа, дараа нь гарах санхүүгийн эрсдлийг маш сайн судлах шаардлагатай.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэрийн хэмжээнд боловсрол, эрүүл мэндийн салбар, орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой асуудлууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үзүүлж байгаа үйлчилгээнд хяналт тавьж ажиллана.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд тавих аливаа хяналт нь юуны түрүүнд гүйцэтгэх засаглалын байгууллага болох Засаг дарга руу чиглэгдэх учиртай. Хурлын шийдвэрийн гүйцэтгэлийн талаар Засаг дарга, түүний Тамгын газар, харъяа болон дэргэдэх газар, хэлтэс, агентлагийн дарга нарын илтгэл, сонсгол, мэдээллийг авч хэлэлцэх, үр дүнгийн тайланг сонсож, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хороо, хэсгээс болон мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан баг гарган ажиллуулах зэргээр шийдвэрийн гүйцэтгэлийг хянаж болно.

Тухайн нутаг дэвсгэрийг хөгжүүлэх чиглэлээр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар хийгдэж байгаа ажлууд, иргэдийн санал, шүүмжлэлийн мөрөөр авч байгаа арга хэмжээний талаар

⁵⁵ “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сайн туршлагууд 2017-2019” khural.mn цахим хуудас

тодорхой хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаараа буюу бусад хуралдаанаараа авч хэлэлцэх, газар дээр нь үзэж танилцах ажлыг зохион байгуулна.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулиудаас 70 орчим хууль нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг, үйл ажиллагааг зохицуулж байгаа. Иймээс дээрх хуулиудын холбогдох заалтуудыг судалж, хяналт шалгалтын ажлаа урьдчилан нарийн төлөвлөн, чанар сайтай зохион байгуулах нь чухал юм.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд жилийн эхэнд хяналтын ажлын төлөвлөгөөгөө гарган Засаг даргын Тамгын газар, Аудитын газар, Мэргэжлийн хяналтын байгууллагатай ажлаа уялдуулах, тухайн байгууллага, аж ахуйн нэгж дээр давхардсан шалгалтыг хийхгүй байх, зарим шалгалтыг хамтран зохион байгуулах хэлбэрээр ажиллавал илүү үр дүнтэй.

Хяналт шалгалт нь цаг үеэ олсон, тухайн байгууллагын ажлыг идэвхжүүлсэн, үр өгөөжөө өгсөн байх талаас нь бодолцох хэрэгтэй. Төрийн хяналт шалгалтын тухай хууль⁴⁰д зааснаар:

3¹.1.1.“**хяналт шалгалт**” гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг;

3¹.1.2.“**хяналт шалгалтын арга, хэлбэр**” гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож байгаа шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг; ...гэж тодорхойлсон байна.

Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд хяналт шалгалтын байгууллага нь хяналт, шалгалтаа хийхдээ төрийн бус байгууллага, иргэдийн дэмжлэгийг авч болохыг зааж өгсөн.

Хяналтын ажлыг зохион байгуулахын тулд юуг анхаарах вэ?

1.Хяналтын ажлын төлөвлөгөөг өмнөх оны эцэст гаргасан байх, төлөвлөгөөг гаргахдаа холбогдох байгууллагаас давхардсан шалгалт хийх эсэх, хамтарсан шалгалт зохион байгуулж болох эсэхийг харгалзан үзэх;

2.Ямар чиглэлээр хаана, хэзээ шалгалт хийх, ямар албан тушаалтны илтгэл, сонсголыг ямар хуралдаанаар хэзээ хэлэлцэх талаар тухайн байгууллагад жилийн эхэнд урьдчилан албан бичгээр мэдэгдэх;

3.Хяналтын ажлыг зохион байгуулах бүрэлдэхүүнийг томилсон шийдвэр гаргах; /ажлын хэсэг байгуулах, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж болно./

4.Хяналтын ажлын удирдамжийг батлан гаргах;

5.Хяналтын ажлыг зохион байгуулах хүмүүсийг холбогдох мэдээлэл, судалгаа, шаардагдах хууль, тогтоомж, гарын авлагаар хангахаас гадна тэдгээрийг ажлаас түр хугацаагаар хөндийрүүлж, хяналтын ажилд оролцуулах болсон талаар холбогдох байгууллагын удирдлагад мэдэгдэх, унаа, ажиллах байр, танхим хуваарилах, томилолтын зардал бусад хэрэгслэлээр хангах талаас нь анхаарах;

6.Хяналтын ажлын дүнг аль нэг хуралдаанаар хэлэлцэх, шаардлагатай бол мэдээллээр хэрэгслэлээр мэдээлэх.

Хяналтын ажлыг үр дүнтэй болгох талаар юу анхаарах вэ?

1.Хяналтын ажлыг хэн зохион байгуулж байгаагаас үл хамааран ажлаа тогтсон нэг арга хэлбэрээр явуулж, асуудалд бодитойгоор хандах, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх нөхцлийг бүрдүүлэх;

2.Хууль, нийтээр дагаж мөрдөх эрхийн актын хэрэгжилтийг хангуулах, тухайн ажлыг эрчимжүүлэхэд чиглүүлэх;

3.Шалгуулж байгаа байгууллагын ажилд үнэлэлт өгч, цаашид ажлаа сайжруулах арга замыг тодорхой болгоход нь туслах;

4.Хууль, холбогдох шийдвэрийн биелэлтийг хангахад эерэг нөлөө үзүүлэх;

5.Хяналтын ажлын ил тод, нээлттэй байдлыг хангаж, шалгагч, шалгуулагч хоёр тал мэдээллийн нэг түвшинд байх нөхцөл бололцоог бүрдүүлэх;

6.Ажлын ололт, амжилтыг сурталчлах, сайн арга барил, туршлагыг бусад байгууллагад нэвтрүүлэхэд анхаарах;

7.Зарим хяналтыг төрийн бус байгууллагатай хамтран хийх, эсхүл тэднээр хөндлөнгийн хяналт хийлгэж, дүнг хэлэлцэж, дүгнэлт гаргаж болно.

...oOo...

4.3.ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛУУД

“Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-аар хөгжлийн бодлогын баримт бичгийн төрлийг тогтоож өгсөн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаатай урт, дунд, богино хугацааны гэсэн төрөлтэй байна:

Орон нутагт:

- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- Орон нутгийн төсөв гэсэн баримт бичгийг хэлэлцэн батлана.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийнхаа хөгжлийн бодлогыг тодорхойлох баримт бичгийг хуралдаанаараа баталж, түүнийхээ хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байгууллага. Энэ утгаараа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нь бодлогын бичиг баримтыг боловсруулах, хэлэлцэж батлах, үнэлгээ хийх, хэрэгжилтийн тайланг сонсох, хяналт, шинжилгээ хийх чиглэлээр тодорхой мэдлэгтэй байх нь чухал.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь удаан хугацаанд мөрдөгдөх бодлогын бичиг баримтыг хэлэлцэж батлахдаа дараах зарчмыг баримтална: Үүнд:

- 1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 2.дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
- 3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 4.тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
- 5.тэнцвэртэй байх;
- 6.нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;
- 7.ил тод, нээлттэй байх;
- 8.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 9.зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
- 10.шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;
- 11.төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;
- 12.төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;
- 13.бүх талын оролцоог хангасан байх;
- 14.төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;
- 15.оролцогчдын хариуцлагын зарчим.

Дээрх зарчмуудыг бодлогын баримт бичиг бүрт заавал тусган хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд хэрэгжилтийн тайланг холбогдох журамд заасан хугацаанд гарган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэж, холбогдох байгууллагад хүргүүлж ажиллана.

Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авч, **Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор** багтаан боловсруулна.

Сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг **Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.**

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ.

Тухайн шатны Засаг дарга үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, жил бүрийн 02 дугаар сарын 20-ны дотор үр дүнгийн тайлангаа хэлэлцүүлнэ. Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

Засаг дарга өөрийн үйл ажиллагааны хөтөлбөрт туссан асуудлуудыг хэрэгжүүлэх, бусад хуульд заасан зорилтот хөтөлбөрүүдийн төслийг бэлтгэн Хурлаар батлуулан, хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна. Харин иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бодлогын бичиг баримтын хэрэгжилтийн тайланг хэлэлцэх, хяналт, үнэлэлт өгөх, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг гүйцэтгэнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргаас бодлогын бичиг баримтын төслийг боловсруулахдаа дараах дарааллаар ажиллана. Үүнд:

Баримт бичгийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгана: Үүнд:

- 1.нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;
- 2.нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох;
- 3.бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах;
- 4.бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх;
- 5.бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах;

6.бодлогын баримт бичгийн төслийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулна.

Бичиг баримтын төслийг боловсруулахдаа холбогдох хууль, баримт бичгүүдийн уялдааг хангах, хувилбар бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөлөл, тооцоо, хэлэлцүүлгийн саналын багц, товъёог, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, шалгуур үзүүлэлт, бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний загвар зэргийг бэлтгэнэ.

Эдгээр шаардлагыг бүрэн хангасан эсэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Хурлын Ажлын алба болон Засаг дарга, түүний Тамгын газрын ажилтнууд анхаарч мөрдөх хэрэгтэй юм.

Өмнө нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр гэж ямар бичиг баримт болох, түүний хэрэгжилтэд хэрхэн үнэлгээ хийх талаар ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй байсан гэж хэлж болно. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д **“Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”** гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг” гэж тодорхойлсон байна. Хөтөлбөр нь тавьсан зорилгодоо хүрэхийн тулд бэлтгэн боловсруулсан ерөнхий баримт бичиг болон газрын зураглалуудын бүрдэл юм.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.2-т зааснаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

а.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг сонгон боловсруулсан байх;

б.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

в.тухайн орон нутгийн хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн улсын, бүсийн болон орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдсан байх;

г.зорилт, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;

д.бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, харилцан уялдаатай хөгжих боломжийг хангасан байх зэрэг болно.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь тухайн засаг захиргааны нэгжийн ирээдүйн хөгжлийг тодорхойлох цөм баримт бичиг бөгөөд иргэд, олон нийтийн ашиг сонирхлыг тусгасан бодлогын баримт бичиг байх ёстой. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байвал зохино.Үүнд:

- Дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэх арга зам нь тодорхой байх;
- Хөтөлбөрт жил бүр хийгддэг ажлыг нарийвчлан тусгахгүй байх;
- Хэрэгжилтийг хангах орлогын эх үүсвэрийг заах, боломжийг судалсан байх;
- Татварын орлогыг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарах;
- Улсын болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалттай уялдуулах;
- Хөрөнгө, мөнгө шаардахгүйгээр хийх ажлын жагсаалт гаргасан байх;
- Гадаад, дотоодын сайн туршлага, шинэ технологийг нэвтрүүлэх санааг хайх;
- Жил болгонд тодорхой зорилго дэвшүүлсэн бол илүү тодорхой байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглосон байна. Дэд хөтөлбөрийн жагсаалтыг шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэж ангилан, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.

Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо Төсвийн тухай хуулийн “Орон нутгийн төсвийн харилцаа” гэсэн 9 дүгээр бүлэгт заасныг мөрдөнө. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төсөв, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан, дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт

Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулна. Хурлаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавихдаа дараах байдлаар ажиллавал илүү үр дүнтэй байх болов уу? Үүнд:

-Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тодорхой хугацаанд тооцож, хуралдаанаараа хэлэлцдэг байхаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгдээ тусгасан байх;

-Хурлын Ажлын хороо бүр өөрийн харьяалах асуудлын хүрээгээр жилд 1-2 удаа хөтөлбөрийн хэрэгжилтээр дүгнэлт гаргаж, хуралдаанаараа хэлэлцдэг байх;

-Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулах.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэхдээ дараах асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.Үүнд:

- 1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэдийн саналыг урьдчилан авах;
- 2.Ажлын хороо бүр хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар өөрийн хариуцах чиглэлээр дүгнэлт гаргах;
- 3.Төлөөлөгч бие даан өөрийнхээ саналыг бэлтгэж гаргах;
- 4.Гаргасан санал бүрээр санал хураалт явуулах;
- 5.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг давхар хэлэлцдэг байх.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэж байгаа одоогийн практикаас харахад хуралдаан болохоос 1-3 хоногийн өмнө Засаг даргын Тамгын газраас “хөтөлбөрийн хэрэгжилт” гэсэн маш олон хуудастай материалыг төлөөлөгчдөд тараадаг. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид бичиг баримттай бүрэн уншиж танилцалгүй намын бүлгийн өгсөн үнэлгээг үндэслэн Засаг даргын үйл ажиллагаанд “Хангалттай”, эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээг өгдөг. Тэр зузаан материалыг уншиж үзэхээр тухайн засаг захиргааны нэгжийн бүх байгууллагуудаас тухайн жилд хийсэн ажлыг нэгтгэн Засаг даргын хийсэн ажил гээд жагсаасан байдаг.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн байгууллагаас хийсэн ажилд үнэлгээ өгөх биш, харин тэдгээр ажлыг хийхэд Засаг дарга ямар үүрэг, оролцоотой байсан, удирдлага зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсан, хөрөнгө, санхүүгийн асуудлыг нь шийдвэрлэхэд хэрхэн тусалсан зэргийг харгалзан Засаг даргын ажилд үнэлэлт өгөх учиртай.

Нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нэг аж ахуйн нэгж гаднах тохижилтоо сайн хийсэн нь, нэг компани үйлдвэрлэлээ сайжруулах зорилгоор техник, тоног төхөөрөмжөө шинэчилсэн нь Засаг даргын хийсэн ажил биш, харин Засаг дарга албан даалгавар гаргасан, хөрөнгийнх нь асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлсэн бол өөр хэрэг. Энэ мэтчилэн Хурлын төлөөлөгчид асуудалд нухацтай хандаж, хийсэн ажлын үр дүнд ялгавартайгаар дүгнэлт хийж, Засаг даргын үйл ажиллагаанд бодит үнэлгээ өгөх нь чухал байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална. Харин нутгийн захиргааны байгууллага Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хуралдаанаар батлуулсны дараа жил бүр хяналт, шинжилгээ хийж, дараа жилийн 02 дугаар сарын 20-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагад хүргүүлж байхаар хуульчлагдсан тул иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид төлөвлөгөө, үндсэн чиглэлийн төлөвлөлтөд саналаа өгөх, хэлэлцүүлэгт ажил хэрэгчээр хандах, гүйцэтгэлийн хяналт, үнэлгээний ажилд оролцох хэрэгтэй юм.

4.4.ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН АЖЛЫГ ЧАНАРЖУУЛЖ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Иргэдийн Нийтийн Хурал нь шууд ардчиллын зарчмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг, хуулиар олгогдсон бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг, иргэдийн өөрийн удирдлагын байгууллага мөн” гэж тодорхойлсон байна.

Орон нутаг дахь ардчиллын бодит баталгаа нь иргэдийн Нийтийн Хурал мөн. Нутгийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх гол үндэс суурь нь иргэдийн Нийтийн Хурлын идэвхтэй үйл ажиллагаа юм. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь иргэдтэйгээ шууд харьцаж, иргэдийнхээ санаа бодлыг хамгийн түрүүн мэдэрч, илүү оновчтой, хүндээ ойр дөт шийдвэр гаргах ёстой байгууллага.

Баг, хороо нь нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх анхан шатны нэгж тул иргэд төрийн байгууллагын хоорондох гүүр гэж хэлж болно.

Иргэн бүр нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, өөрийн орон нутгийн асуудлыг хамтаараа шийдвэрлэх, зохион байгуулах, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх, хэрэгжилтэд нь гар бие оролцох, биелэлтэд нь хяналт тавих зэргээр үе шат болгонд идэвхтэй оролцоход суралцах шаардлагатай байна.

Нутгийн иргэд л өөрийн орон нутгийн өмнө тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлын учир шалтгааныг илүү мэдэж төлөвлөж чадах бөгөөд шаардлагатай мэдээллийг хуримтлуулж чадсан байдгаараа давуу талтай. Хурал шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавихдаа юуны түрүүнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, мэргэжлийн байгууллагыг оролцуулахаас гадна, иргэдийн оролцоог хангахад анхаарах нь чухал.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо” гэсэн 31дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Иргэд сайн дураараа үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх, нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах, энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй” гэж заасан байгаа. Хурлын байгууллагыг иргэдийнхээ санал хүсэлтийг заавал хэлэлцдэг байхаар үүрэгжүүлж өгсөн нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг жинхэнэ иргэдийн төлөөллийн байгууллага гэдэг утгаар нь иргэддээ үйлчилдэг байгууллага болгон, илүү нээлттэй ажиллах нөхцлийг шинээр бүрдүүлсэн гэж үзэж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг иргэдийг оролцоотойгоор хийдэг байх, үүний тулд баг, хорооны иргэдийн нийтийн Хурлаас хяналтын зөвлөл, хэсгийг байгуулан ажиллуулах шаардлагатай байна. Зарим аймаг, суманд иргэдийн оролцоотой “хяналтын баг” байгуулан ажиллаж, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байгаа боловч тэдгээр нь зөвхөн олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр түр

хугацаанд хийгдсэн байна. Иймээс хяналтын ажлыг хийх хөрөнгийн асуудлыг жил бүрийн төсөвт тусгуулан тасалдалгүйгээр хэрэгжүүлж байх нь үр дүнтэй юм.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т зааснаар “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэснийг хэрэгжүүлж, орон нутагт хийгдэж байгаа ажилд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, иргэд, тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа төрийн бус байгууллагын төлөөллийг оруулж хяналт хийх ажил хийх шаардлагатай.

Тухайн нэгжийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар хийгдэж байгаа ажлууд, иргэдээс гаргасан санал, шүүмжлэлийн мөрөөр авч байгаа арга хэмжээний үр дүнг иргэдийн нийтийн Хурлын хуралдаанаараа, эсвэл Зөвлөлийн хуралдаанаараа авч хэлэлцэх, газар дээр нь үзэж танилцах ажлыг зохион байгуулж байх хэрэгтэй юм.

Баг, Хорооны иргэдийн нийтийн Хурал нь дээрх хуулиудыг хэрэгжүүлэх, нутаг, дэвсгэрийнхээ хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, газар тариаланг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, бэлчээр ашиглалтыг зохицуулах, хүний нөөцийн төлөвлөлтийн бодлогыг тодорхойлогч нь байх учиртай.

Мөн тухайн нэгжийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэх, орон нутагтаа жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малчдын нийгмийн асуудалд анхаарч тэдгээрийг хөдөлмөрөөрөө хорших, малчдын бүлэг байгуулах, иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих зэрэг олон асуудлыг орон нутгийн онцлог, боломжийг харгалзан шийдвэрлэх, хэтийн бодлого, зорилгоо зөв тодорхойлон хөтөлбөр, чиглэл боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь чухал юм.

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн нэгжийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нийт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхийг эдлүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

Иргэдийн Нийтийн Хурлын ил тод, үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:

1. Хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулж урьдчилж нээлттэй хэлэлцүүлэг хийх, иргэдийн саналыг авах хурал, цуглааныг зохион байгуулах, саналын хайрцаг ажиллуулах;
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд иргэдийг хэрхэн оролцуулсан, тэдний санал, бодлыг хэрхэн тусгасан талаар жил бүрийн тайландаа заавал тусгадаг байх;

3. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны болон Тэргүүлэгчдийн, Зөвлөлийн хурлын тэмдэглэлтэй сонирхсон иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөгчид танилцах боломжийг хангах талаар Хуралдааны дэг, дотоод журамдаа тусган хэрэгжүүлэх;
4. Нийтэд зориулсан мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээх;
5. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, холбогдох журамд зааснаар иргэний нийгмийн байгууллагаар зарим төрийн ажил, үйлчилгээнд үнэлгээ хийхэд иргэдээ оролцуулах талаар санаачилга гарган ажиллах;
6. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бэлтгэсэн нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн төсөлд санал өгөх хэлэлцүүлгийг хийх, үндэслэл, зорилгыг тайлбарлах, батлагдсны дараа сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн тайланг холбогдох албан тушаалтнаар тавиулах, мэдээллэх хэлбэрээр ажиллана.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д зааснаар тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны тэнцвэрт байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажлыг багийн чиг үүрэгт хамааруулсан болно. Баг нь байгалийн баялгийг ашиглах, хууль тогтоомжийн биелэлтэд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавих, нутаг дэвсгэртээ гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн болон тариалангийн талбай, бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулна.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжоор баг ямар эрх, үүрэгтэйгээр ажиллах, байгаль хамгаалах чиглэлээр байгуулагдсан иргэдийн нөхөрлөлүүдийг хэрхэн дэмжиж, үйл ажиллагааг нь зохицуулах талаар номын 5 дугаар хэсэгт бичсэн болно.

Иргэдийн Нийтийн Хурал нь Хэрэглэгчийн үнэлгээ хийх ажилд оролцоно. “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх ажил 2018 оноос эхэлсэн тул баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, тэргүүлэгч болон Зөвлөлийн гишүүд ч үнэлгээний талаар тодорхой мэдлэгтэй байх хэрэгцээ үүсээд байгаа байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан ерөнхий удирдамжийн дагуу захиргааны байгууллага нь хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэдэг. Хэрэглэгчийн үнэлгээ нь тухайн нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн зүгээс үнэлэлт өгч байгаа хөндлөнгийн үнэлгээний нэг хэлбэр юм.

Иргэдийн оролцоо, хяналтыг бий болгосноор төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа чиглэлийг бодит байдалд үндэслэн төлөвлөх боломж бүрдэхээс гадна, гарсан шийдвэрийн хэрэгжилт сайжрах болно.

Иргэдийн оролцоо, хяналтыг бий болгохын тулд иргэдэд холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэл хүргэх суваг, хэрэгслэлийг нэмэгдүүлэх, тэдгээрээс

баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд оролцох идэвх, оролцоог сайжруулах хөшүүргийг бий болгоход анхаарах хэрэгтэй байна.

2019 онд “Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” /2017-2020/ төслөөс хийсэн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан”-д дурьдснаар баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд оролцсон байдал Улаанбаатар хотод 20.6 хувьтай буюу 5 хүн тутмын нэг нь, хөдөө орон нутагт 49.2 хувьтай буюу 2 хүн тутмын нэг нь оролцсон нь 2015 онд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад Улаанбаатар хотын хорооны иргэдийн Нийтийн Хуралд иргэдийн оролцсон байдал 7.4 хувиар, хөдөө орон нутагт 7.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд оролцоогүйн гол шалтгаан нь Улаанбаатар хотын иргэдийн хувьд “Хэзээ хаана болох талаар мэдээгүй, мэдээлэл ирээгүй” гэж 52.2 хувь нь, хөдөө орон нутгийн иргэдийн хувьд “завгүй байсан” гэж 42.5 хувь хариулсан байна.⁵⁶

Архангай аймгийн Тариат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал иргэдийн оролцоог хангах зорилгоор “Иргэн, айл өрхийн нийгмийн идэвх, оролцоог үнэлэх журам”-ыг баталж үр дүнг нээлттэй мэдээлж ажилласнаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны ирц нэмэгдэж, хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт сайжирч, иргэдийн зүгээс шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг болсон байна. Харин Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Шийдвэр гаргах ажиллагаанд иргэний оролцоог хангах журам”-ыг баталж, сумын төсвийг хэлэлцэн батлах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд иргэдийг оролцуулан саналыг сонссон сайн туршлагауд байна.⁵⁷

Засаг даргын Тамгын газар бол зөвхөн Засаг даргад үйлчилдэг газар биш, иргэдэд үйлчилдэг Засаг даргын үйлчилгээний газар. Цаашдаа Засаг даргаас захирагчийн тогтолцоо руу, засаг захиргааны нэгж, төрийн төв байгууллага тойрсон тогтолцооноос хүн тойрсон, иргэнээ тойрсон, тэдэнд үйлчилдэг тогтолцоо руу шилжих хэрэгтэй байгаа юм.

Иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах, тэдний санал бодлыг төрийн байгууллагаас гарах шийдвэрт тусгах асуудал олон жилийн турш яригдаж байгаа боловч, амьдралд хэрэгжихдээ харилцан адилгүй байна.

Төрийн байгууллага ил тод, нээлттэй ажилласнаар хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, албан тушаалтныг авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөл хангагдана. Харин мэдээлэлгүй, мэдээлэл бага авсан иргэдийн шүүмжлэл, эсэргүүцэл нь төрийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх, бусад хүндрэлүүдийг үүсгэх магадлалтайг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бусад бүх шатны байгууллагууд анхаарч ажиллах нь чухал байна.

....ooOoo....

⁵⁶ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан” 2019 он 89 дүгээр хуудас

⁵⁷ “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сайн туршлага 2017-2019” khural.mn цахим хуудас



5.НУТГИЙН УДИРДЛАГА- БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ИРГЭДИЙН НӨХӨРЛӨЛ

Нутгийн удирдлага нь тухайн нэгжийн байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах үүрэг хүлээдэг.

Иргэдийнхээ оролцоотойгоор байгаль орчныг хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нутгийн удирдлагын зүгээс тодорхой эрх, үүрэгтэйгээр ажиллах талаар олон хууль тогтоомжид заасан боловч үр дүн нь хангалттай бус байгаа юм. 2020 оны сонгуулиар шинээр байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төлөөлөгчид, Засаг дарга нарт байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд өөрчлөлт гаргахыг байгаль өөрөө анхааруулж байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйлсэд иргэдийн оролцоог дээшлүүлж нутгийн иргэд оршин суугаа газрынхаа байгалийн баялгаас зохистойгоор хувь хүртэх боломж нөхцлийг бүрдүүлэх үүднээс Байгаль орчныг хамгаалах тухай хуульд “Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөл” байгуулж ажиллуулах тухай асуудлыг хуульчилсан. Харин Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Газрын тухай, Ойн тухай, Амьтны тухай зэрэг хуульд нутгийн удирдлагаас иргэдийн нөхөрлөлийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хяналт тавих эрх, үүргийг тодорхойлсон болно.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ байгалийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших чиглэлээр нөхөрлөл байгуулах тухай Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэх, Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах, тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн, гэрээг үргэлжлүүлэн сунгах асуудлыг шийдвэрлэх зэрэг олон зохицуулалтууд байдаг.

“Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөл” нь иргэд тухайн нутаг дэвсгэртээ байгаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, гэрээгээр зохистой ашиглах, эзэмших зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу зохион байгуулагдаж, гэрээ

байгуулан үйл ажиллагаа явуулна. Иргэдийн сайн дурын байгууллагад энэ хуулийн 31¹ дүгээрт зааснаар одоогийн нөхөрлөлүүд байгуулагдан ажиллаж байна.

2012 оны 5 дугаар сарын 17-нд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, “Байгалийн нөөцийн хамтын менежмент” гэсэн 8 дугаар бүлэг нэмэгдэж, “Нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулах, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ” хэмээн тодорхойлсон билээ. Ингэснээр байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, гэрээгээр зохистой эзэмших асуудлыг Иргэний хууль, бусад хуультай нийцүүлсний дээр зөвхөн хамтын гэрээнд үндэслэсэн хуулийн этгээд бус нөхөрлөл байгуулах зохицуулалт байсныг өөрчилж хуулийн этгээд байгуулах эрхийг нээлттэй болгосон болно.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор байгаль орчны, газрын тухай зэрэг олон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа тул тэдгээрт байгалийн нөөцийн хамтын менежментийн асуудлыг илүү нарийвчлан тусгах, зохицуулах хэм хэмжээ, хамрах хүрээг Иргэний хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэх шаардлагатай байгаа юм.

5.1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн эрх, үүрэг

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 48 дугаар зүйлд байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд нь нөхөрлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, байгаль орчны мэргэжлийн байгууллага, түүнчлэн байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байж болохоор заасан. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тус бүрээр дэлгэрүүлэн авч үзье.

1.Нөхөрлөл. Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

-байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрх эдлэхээс гадна өөрийн үндсэн үйл ажиллагаандаа газрын тухай, газрын хэвлийн тухай, ой, усны тухай, амьтны аймгийн тухай, байгалийн ургамлын тухай хууль тогтоомжоор зохицуулсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

-Нөхөрлөл тодорхой төрлийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлэхдээ тухайн шатны Засаг даргатай гэрээ байгуулж ажиллана.

-Нөхөрлөл нь өөрийн дотоод дүрэмтэй байх бөгөөд дүрмэндээ бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ахлагч, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, дундын өмч хөрөнгийн харилцааны асуудлыг хуульд заасны дагуу тусгасан байна.

-Нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийн талаар жил бүр тайлан бичиж, тухайн сум, дүүрэг, баг, хорооны Хуралд тайлагнах бөгөөд түүнд байгалийн баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, нөөц баялгийн төлөв байдал, түүний өөрчлөлт зэргийг тусгасан байна.

-Нөхөрлөл нь бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан менежментийн төлөвлөгөөтэй байна.

-байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

-байгаль орчныг хамгаалах талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах;

-байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэр гаргуулах;

-өөрийн эзэмшлийн газар болон байгалийн нөөц бусад эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

-гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд зохистой ашиглах давуу эрхтэй байна.

-Нөхөрлөл нь оролцогч талуудтай Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бичгээр гэрээ байгуулж ажиллана. Өөрсдийн эрх ашгаа хамгаалах, хамтын ажиллагаагаа зохицуулах үүрэг бүхий нөхөрлөлүүдийн холбоотой байж болох бөгөөд холбооны дүрэм, үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

Нөхөрлөл нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банкинд данстай байж болно. Нөхөрлөл нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, гишүүддээ дэмжлэг үзүүлэх зорилгоор дундын сан байгуулж болно.

Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал,

ой мод, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно.

Нөхөрлөл нь гишүүдийнхээ дотроос идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж болно. Идэвхтэн байгаль хамгаалагчид аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа нэн ховор, ховор амьтан, ургамал, түүний амьдрах орчныг хамгаалах, өвөл, хаврын улиралд болон цаг уурын хүндрэлтэй үед амьтдын гол идээшил нутагт өвс тэжээл, хужир мараа тавьж өгөх, ус задгайлах, амьтны халдварт өвчний голомтыг тусгаарлах, амьтны нөөцөд халгаатай махчин амьтдын тоо толгойг зохицуулах, сийрэгжүүлэх, туршилт судалгаа явуулах зэрэг арга хэмжээг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, туслалцаатайгаар авч хэрэгжүүлж болно.

Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа мод бут, ургамал тарих, амьтан шилжүүлэн болон сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагын зөвлөлтөө туслалцаатайгаар хэрэгжүүлнэ.

Сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрснөөр өөрийн хариуцан хамгаалж байгаа газар нутгийн байгалийн бүх төрлийн нөөц баялгийг менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохих төлбөр, хураамжтайгаар ашиглах замаар үр өгөөжийг нь тогтвортой хүртэх, худалдан борлуулах, олсон орлогын 50-иас доошгүй хувийг дундын сандаа төвлөрүүлэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан зарцуулна.

Нутгийн иргэдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх болон нөхөрлөлийн үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах чиглэлийн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулж байна.

Нөхөрлөл нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төслийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль хамгаалах чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтанд оролцох эрхтэй.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Журам, гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай” 2010 оны 250 дугаар тушаалаар байгаль орчныг хамгаалах чиглэлээр явуулж байгаа нөхөрлөлүүдэд дараах үүргийг хүлээлгэсэн болно. Үүнд:

Нөхөрлөл нь хавар намрын хуурайшил ихтэй, түймрийн эрсдэл өндөр цаг үед байнгын эргүүл, жижүүр ажиллуулах, мэдээллийг сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд тогтоосон хугацаанд мэдээлж байх;

Хариуцан хамгаалж буй газар нутгийн төлөв байдал, нөөц, түүний өөрчлөлт, хөдөлгөөнд тогтмол ажиглалт хийж, мэдээллийг байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид өгч байх;

Бэлчээрийг улирлын хуваарь, сэлгээтэй ашиглах, гол горхи, булаг шанд, усны эхийг хамгаалах, цас борооны усыг цуглуулах, худаг гаргах зэргээр усжуулах, хадлангийн талбайг хаших, бордох, аргал хөрзөн түлдэг зуух болон нар, салхины эрчим хүч ашиглаж мод, бутлаг ургамлыг хэрэглээг багасгах замаар орчны доройтол, цөлжилт, хуурайшилтаас сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;

Хариуцан хамгаалж буй газар нутгаа тэмдэгжүүлэх, хадлангийн талбай болон туршилт, судалгаа, нөхөн сэргээлт хийх газрыг хашиж, хамгаалж болох бөгөөд харин бусад иргэдийн нэвтрэх, аялал жуулчлал хийхэд саад учруулах, зэрлэг амьтны нүүдлийг хаах зэргийг хориглох;

Байгаль орчныг хамгаалах чиглэлийн уулзалт ярилцлага, семинар зөвлөлгөөн, мэргэжил шинээр олгох хийгээд давтан сургах сургалтанд гишүүдээ хамруулж байна.

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.

Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны “Журам батлах тухай” 227 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Журам, гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай” 2010 оны 250 дугаар тушаалаар батлагдсан “Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам”-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

Ойн тухай хуульд заасны дагуу **ойн нөхөрлөл** нь бусад нөхөрлөлөөс өөр дараах байдлаар ажиллана. Үүнд:

а.Ойн нөхөрлөл нь гэрээгээр эзэмшсэн газартаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу идэвхтэн байгаль хамгаалагчийг ажиллуулж болно.

б.Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмших давуу эрхтэй.

в.эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах;

г.эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;

д.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ойн аж ахуйн арга хэмжээний төсөл, хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтад оролцох;

е.ойн менежментийн талаар явуулах сургалт, семинар, мэргэжил олгох, давтан сургах үйл ажиллагаанд хамрагдах.

ё.ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, түүнчлэн мод бэлтгэсэн талбайн ойг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээг улсын захиалгаар улсын болон орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, дотоод, гадаадын хандив, тусламжаар гүйцэтгэнэ.

Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага огтолсон **нэг модны оронд арав** буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ургуулж, улсын ойн санд хүлээлгэж өгнө. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын тарьж ургуулсан модыг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу худалдан авч болно. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцсэн тохиолдолд зохих журмын дагуу урамшуулал олгож байхаар журамлагдсан болно. Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах бөгөөд журмыг Засгийн газар батална.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны “Журам батлах тухай” 227 дугаар тогтоолд зааснаар ойн нөхөрлөл нь мод болон ойн дагалт баялгийг борлуулснаас олсон нийт орлогын 50-иас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлж, энэ орлогыг ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бусаар мод бэлтгэхийг таслан зогсоох, хяналт тавих, ойг нөхөн сэргээх, нутгийн хөгжлийг дэмжихэд зарцуулах үүрэгтэй.

Ойн нөхөрлөл нь эзэмшлийн ойг түймрээс сэргийлэх, хавар, намрын хуурайшилт ихтэй үед байнгын эргүүл, жижүүр ажиллуулах, сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд мэдээлэл өгч байх, түймэртэй тэмцэх, түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авах, ойн санд ой зохион байгуулалтыг хийлгэсэн байх, эзэмшлийн ойн сангийн газар, ус, ургамал, амьтны аймаг, бусад байгалийн баялгийг хамгаалах, төрх байдлыг хадгалах, ойн сангийн өөрчлөлтийг жил бүр гаргаж байх, байгалийн бусад баялгийн өөрчлөлтөд тогтмол ажиглалт хийж, үнэн зөв мэдээллийг ойн анги эсхүл байгаль хамгаалагчид өгч байх үүрэгтэй.

Мөн эзэмшлийн ойд хяналт шалгалт зохион байгуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, учруулсан хохирлыг буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад асуудлыг тавих, эзэмшлийн талбайдаа ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах ажлыг өөрийн хөрөнгөөр болон бусад

байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэх, шаардлага хангасан таримал ойг зохих хугацаанд нь улсын ойн мэдээллийн санд бүртгүүлэх, ойд зорчин явагсад, байгалийн тодорхой баялгийг ашиглагчдад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, гаргасан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллана. Ойн нөхөрлөл нь гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ойн дагалт баялгийг төлбөртэйгөөр ашиглана. Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага дараах хураамж төлнө.Үүнд:

- 1.ойн мэргэжлийн байгууллагын эрх олгосны;
- 2.ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгосны;
- 3.бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгосны.

Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагаа явуулснаас ойн сан, түүний нөөцөд хохирол учруулсан бол учирсан шууд хохирлыг нөхөн төлнө:

- хориглосон үйл ажиллагаа явуулсан;
- хууль бусаар мод бэлтгэсэн;
- зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг түүсэн, бэлтгэсэн;
- ойн санд хортой нөлөөлөл үзүүлсэн;
- үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ашигт малтмал олборлох зэрэг үйл ажиллагаа явуулахдаа ойг устгасан;
- хууль бус бусад үйл ажиллагаа явуулсан.

Амьтны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт ан амьтныг хамгаалах чиглэлээр байгуулагдсан нөхөрлөлийн асуудлыг хуульчилсан болно. Ан агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг эзэмшигч нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу эзэмшлийнхээ агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг авна. Иргэн, хуулийн этгээдийн гэрээгээр ашиглаж, эзэмшиж байгаа нутгийн амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг тухайн газар ашиглагч, эзэмшигчийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих, нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох, нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг хянах зэрэг эрхийг хэрэгжүүлж ажиллана.

Харин байгаль орчныг хамгаалах нөхөрлөлийн үйл ажиллагаатай холбоотойгоор төсвийг батлах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулна.

Байгаль орчныг хамгаалах нөхөрлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, үр дүнг тооцож ажиллана.

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг нөхөрлөлд хариуцуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

Нөхөрлөл байгуулах талаар багийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэр гаргаж, гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг нөхөрлөлд хариуцуулах эрхтэй.

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэгт зааснаар “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр байгуулсан хиймэл нуур, цөөрөм, усан сан, өсгөж үржүүлсэн ан амьтан, тарьж ургуулсан ойн төгөл, аж ахуйн ашигт ургамлын доорх газрыг багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн давуу эрхээр эзэмшүүлж болно.” гэсэн зохицуулалтыг хэрэглэн шийдвэрлэж болох юм.

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, гэрээний биелэлтийг жил бүр хэлэлцэн дүгнэх, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах санал, дүгнэлтийг гаргаж, Засаг даргад уламжлан ажиллана.

3.Засаг дарга

Тухайн нэгжийн Засаг дарга нь нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулан, батлагдсан төсвийн хүрээнд тэдгээрийг дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулна.

Нөхөрлөлөөс тухайн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх ажлыг хариуцна.

Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан ажиллана.

Аймаг, Нийслэлийн Засаг дарга нь .ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааны явцад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай бол ойн санд сөргөөр нөлөөлж байгаа үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, зогсоох эрхтэй.

Сум, дүүргийн Засаг дарга нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах талаарх ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, тэдний тарьж ургуулсан таримал ойг хүлээн авах ажлыг хариуцна.

Баг, хорооны Засаг дарга нь нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлэх, нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах, тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны тэнцвэрт байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажлыг хариуцна.

...oOo...

5.2.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн хариуцан хамгаалах байгалийн нөөц

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд “Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ.” гэж заасан. Энэ хуулиар төрийн нийтийн зориулалттай өмчид дараахь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө хамаарч байна. Үүнд:

- 1/ иргэдэд өмчлүүлснээс бусад газар;
- 2/ газрын хэвлий, түүний баялаг;
- 3/ ус, түүний доторх баялаг;
- 4/ ой, түүний дагалдах баялаг;
- 5/ ургамал, ан амьтны нөөц;
- 6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал;
- 7/ археологийн болон палентологийн олдвор;
- 8/ хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн байгалийн нөөцийн хамтын менежментийн хамрах хүрээг тодорхойлсон 47 дугаар зүйлд нөхөрлөлийн хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх объектэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар зэрэг байгалийн нөөцөөс гадна дэлхийн болон үндэсний байгаль, соёлын өвд хамаарагдах газар нутаг орохоор заажээ.

Байгалийн нөөцийн хамтын нөхөрлөлийн хариуцан хамгаалж байгаа нийт нутгийн 3.1 сая буюу 37.8 хувийг гэрээгээр эзэмшиж байгаа ойн сан эзэлж байгаа бол үлдсэн хэсэг нь үндсэндээ бэлчээрийн газарт суурилсан байдаг. Харин тухайн бэлчээрийн газрыг зориулалтаар ашиглах, улирлын чанартай хязгаарлалтай ашиглах эсэхийг тодорхой хууль тогтоомжоор зохицуулж өгсөн байна.

Байгалийн ургамлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ургамлыг нөөцийнх нь хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглосон баянбүрдээс бусад газар нутагт мал бэлчээхгүй юм. Мөн Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болохоор заасныг Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн ой, 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь хэсэгт заасан ойжуулсан, ойн үр бэлтгэх

зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мал бэлчээхийг хориглохоор зохицуулжээ.

Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд улсын газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг газар ашиглалтын зориулалтаар ангилсан байдаг бөгөөд бэлчээр нь хөдөө аж ахуйн газрын ангилалд хамаарагдана. Манай улсын бэлчээр 110391.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 70.6 хувийг эзэлдэг.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Журам, гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай” 2010 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А-250 дугаар тушаалаар батлагдсан “Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам”-ын 1.2-д “Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөлийн энэхүү журмын дагуу хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших байгалийн тодорхой төрлийн баялаг гэдэгт Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйлийн 311.6 дахь заалтад заасанчлан газрын хэвлийн баялаг, бэлчээр, усан сан бүхий газар, улсын тусгай хэрэгцээний газраас бусад байгалийн бүх төрлийн нөөц баялаг хамаарна.” гэж заасан болно.

Журмын “Нөхөрлөлийн эрх, үүрэг” гэсэн 5 дугаар бүлгийн 5.6-д “Бэлчээрийг улирлын хуваарь, сэлгээтэй ашиглах, гол горхи, булаг шанд, усны эхийг хамгаалах, цас борооны усыг цуглуулах, худаг гаргах зэргээр усжуулах, хадлангийн талбайг хаших, бордох, аргал хөрзөн түлдэг зуух болон нар, салхины эрчим хүч ашиглаж мод, бутлаг ургамлыг хэрэглээг багасгах замаар орчны доройтол, цөлжилт, хуурайшилтаас сэргийлэх арга хэмжээг авч ажиллана” гэж заасан нь дээр дурдсан хуульд үндэслэн бэлчээрийн ургамлын нөмрөг нь Байгалийн нөөцийн хамтын нөхөрлөлийн хариуцан хамгаалах байгалийн нөөцийн нэг **бүрэлдэхүүн хэсэг** болохыг тодорхойлж байна.

Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар сум нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, байршлыг тодорхойлсон жилдээ хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй байхаар заасан. Мөн хуулийн 52 дугаар зүйлд бэлчээр зохион байгуулалтын асуудлыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлахаар заасан болно.

Иймээс сумын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл төлөвлөгөөндөө өөрийн хариуцан хамгаалах газар нутагт хэрэгжүүлэх бэлчээрийн менежментийн асуудлыг тусгаж байх нь чухал.

Онц байдлын тухай болон Гамшгийн тухай хуульд зааснаас бусад үед нөхөрлөлийн хариуцан хамгаалж байгаа нутагт мал бэлчээх, худаг ус, өвөлжөө, бууц ашиглах бол сум, багийн Засаг дарга нөхөрлөлийн гишүүдтэй урьдчилан зөвшилцсөн байна.



Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь хуулийн этгээд мөн үү, эсхүл иргэдийн сайн дураар нэгдсэн бүлэг үү? гэсэн асуудлыг өөр өөрөөр тайлбарлаж, бас өөрөөр амьдралд хэрэглэж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг” гэсэн байдаг бол 25.1-д “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.” гэжээ. Мөн улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээдийн жагсаалтад “нөхөрлөл” гэж оруулсан байна. Энэ нөхөрлөл нь Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээд гэдгийг ялгаж ойлгох хэрэгтэй.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээд хэлбэрээр эсхүл Иргэний хуулийн 476, 481 дүгээр зүйлд заасан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хуулийн этгээд байгуулахгүйгээр улсын бүртгэлд бүртгүүлэхгүй эрх зүйн харилцаанд төлөөлөгч буюу гишүүнээрээ дамжин оролцох нөхөрлөл гэсэн хэлбэртэй байж болно.

Иргэний хуульд хуулийн этгээдийн төрлийг тогтоосон 33 дугаар зүйлийн 33.1-д “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.”, 33.2-д “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна” гэж заасан байдаг. Байгаль орчныг хамгаалах хуулийн 50 дугаар зүйлийн 14-т “Нөхөрлөл нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банканд данстай байж болно.” гэж заасан нь тэмдэг, данс авахад улсын бүртгэлд бүртгүүлж татвар, санхүүгийн байгууллагад тайлан гаргаж өгөх үүрэг хүлээх тул хуулийн этгээд болно.

Ийм тохиолдолд нөхөрлөлүүдийн холбоо нь төрийн бус байгууллага, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь хоршоо хэлбэрээр ажиллаж болохоор байна. Иргэний хуулийн 36 дугаар зүйлд зааснаар “эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ” гэж заасан болно.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрх” болох юм.

Нөхөрлөлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-д зааснаар хэд хэдэн этгээд **ашиг олох зорилгоор** эд хөрөнгөө нэгтгэн энэ хуульд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахаар хэлэлцэн тохирч бичгээр байгуулсан хэлцлийн үндсэн дээр нөхөрлөлийг байгуулдаг байна.

Бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдын бүлэг нь хуулийн этгээдээр бүртгүүлээгүй байдаг бол байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.1, 481 дүгээр зүйлийн 481.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулагддаг, эрх зүйн чадамжийн хувьд адил боловч нөхөрлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны зорилго, чиглэл, төлөвлөлт, санхүүжилтийн асуудал нь өөр. Мөн идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, хяналт шалгалт хийх, байгалийн нөөц, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг бусад төрлийн нөхөрлөлд олгогдоогүй олон эрх холбогдох хууль тогтоомжоор баталгаажсан байдгаараа онцлогтой.

Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5, 14 дүгээр зүйлийн 2, Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дэх хэсэгт заасан нэн ховор ургамал, амьтныг хамгаалах зорилгоор нөхөрлөлд хариуцан хамгаалах газарт бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдын бүлэгт бэлчээрийг ашиглуулахаар сумын Засаг дарга гэрээ байгуулсан тохиолдолд байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 13-д заасны дагуу хариуцлага хүлээлгэн учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд байгалийн нөөцийг хариуцан хамгаалах эрх олгох шийдвэрийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргаж, Засаг дарга гэрээ байгуулдаг.

Харин бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдын бүлэгт Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт заасны дагуу сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж байна. Давхардсан гэрээ байгуулсан тохиолдолд нөхөрлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал тавьж, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6-д заасны дагуу Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэхийг шаардах эрхтэй.

“Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай” Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 01 зүгээр сарын 16-ны өдрийн А-12 дугаар тушаалаар батлагдсан гэрээний загварт Засаг дарга нөхөрлөлийн гэрээт газар дээр мал бэлчээх бол нөхөрлөлийн нийт гишүүдтэй тохиролцсон байхыг заажээ.

Цаашид газрын тухай хууль тогтоомжийн агуулга болох газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн өгсөн хүсэлтийг өгсөн өдрөөр нь бүртгэн авч, дарааллын дагуу эрх олгодог байхаар журамлавал маргаантай асуудлыг шийдвэрлэх гарц болох юм. Гэхдээ хамгаалж байгаа ургамал, амьтан зэрэг байгалийн нөөцөд хор хохирол учруулахгүйгээр улирлын чанартай бэлчээр ашиглуулахад анхаарч, эзэмшиж байгаа газраа эрх олгосон этгээдийн зөвшөөрөлтэйгээр бусдад ашиглуулдаг зарчмыг баталгаажуулах нь зүйтэй юм.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн хариуцан хамгаалж буй газар нутагт тухайн байгалийн нөөцөд хамааралгүй газрын тухай, усны тухай гэх мэт хуулийн дагуу эрх авсан объектууд байршиж байх боломжтой. Энгийн жишээ дурдахад тухайн нутаг дэвсгэрт өвөлжөөтэй боловч гадны бүртгэлтэй, эсхүл аливаа олон нийтийн байгууллагад эвсэж, нэгдэхгүй байх Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэж байгаа иргэн байж болно. Байгалийн нөөцийн хамтын менежментээр хариуцаж буй байгалийн нөөцөд хохирол учруулахгүйгээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгалийн нөөц тухайлбал, мод, түлээ бэлтгэх гэх мэт үйл ажиллагаа явуулах иргэний эрхийг нөхөрлөл зөрчих ёсгүйг анхаарах нь чухал.



Тухайлбал: Ойн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.4.2-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн ойд хохирол учруулахгүйгээр иргэн аялал зугаалгаар явах, мал туувар дайран

өнгөрөх, зөгий үржүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр ойн дагалт баялгийг ашиглах, ан хийж болно.” гэж заасан байна.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь томоохон хэмжээний газрыг хариуцан хамгаалдаг учраас бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх, үүний тулд Газрын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах, уг газарт нэвтрэх, дайран өнгөрөх зарчмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд ороогүй ямарч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан бол хариуцан хамгаалж байгаа газар нутагт нь үйл ажиллагаа явуулж болно. Жишээлбэл: Засгийн газраас тогтоосон журмын дагуу тусгай зөвшөөрөлтэйгээр ховор амьтан агнах гадаадын анчин, төрийн байгууллагын зөвшөөрөлтэй эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар нэн ховор ургамал түүх гэх мэт.

Ган, зудын улмаас өөр аймаг, сумын нутагт отроор нүүдэллэн ирэх малчдыг сумын Засаг дарга хүлээн авахаар шийдвэрлэсэн бол байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүдтэй зөвшилцөн отрын малыг хамгаалж буй ургамлын төрөл, амьтны тархацад сөргөөр нөлөөлөхгүй байхаар холбогдох иргэдэд үүрэг болговол аль аль талын эрх зөрчигдөхгүй.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл” гэж /цаашид “нөхөрлөл” гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг” гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд нутгийн иргэд гэдэг ойлголтод тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид бүртгэлтэй иргэд хамаарна гэж ойлгож болох боловч Иргэний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д “Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно” гэж заасан тул өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийг хариуцан хамгаалж байгаа нөхөрлөлд гишүүнээр элсэх эрх зүйн боломж нээлттэй байна гэсэн үг.

Тухайн нутгийн захиргааны байгууллагад бүртгэлгүй боловч тухайн орон нутгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, хөрөнгө, мөнгөний дэмжлэг үзүүлдэг, ажлын байр бий болгодог иргэдэд дээрх эрх зүйн боломжийг Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д “Ойн нөхөрлөлийн гишүүдийн 80-аас доошгүй хувь нь гэрээгээр эзэмшиж байгаа

ойн сангаа байнга харж хамгаалах, хяналт тавих боломжтой тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байнгын оршин суугч иргэн байна” гэж зааснаар олгосон байна.

Нөхөрлөл нь менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд энэ төлөвлөгөөний нэг хэсэг нь санхүүгийн төлөвлөгөө байдаг. Байгалийн нөөцийн хамтын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор дундын санг байгууллага хамт олны хандив, тусламж, нөхөрлөлийн гишүүдийн оруулсан хөрөнгө, дундын сангийн зээлийн хүү, нөхөрлөлийн эд хөрөнгийн ашиглалтын түрээс, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан орлогын мөнгөн дүнгийн тодорхой хувь зэрэг эх үүсвэрээс бүрдүүлж болно.

Нөхөрлөл нь хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулагддаг тул Иргэний хуулийн 477 дугаар зүйлд зааснаар хамтран ажиллах гэрээний талууд гэрээнд заасны дагуу мөнгөн, эсхүл хөрөнгийн, түүнчлэн үйлчилгээ үзүүлэх хэлбэрээ хураамж төлөх бөгөөд гишүүд өөрөөр тохиролцоогүй бол дундын хөрөнгө шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд нөхөрлөлийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бүрэн эрх бүхий этгээдүүд ижил хэмжээгээр нөхөх хариуцлага хүлээнэ.

Харин төрийн бус байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөлүүдийн холбоо нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар гишүүний татвар, хандив, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого болон зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө байж болно.

Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Ойн тухай хууль тогтоомжид харьцангуй тодорхой заасан байна. Тухайлбал: 21 дүгээр зүйлийн 21.12.2 дэх хэсэгт “эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;” гэсэн бол “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолын 4.1.9-д “ойн нөхөрлөл нь мод болон ойн дагалт баялгийг борлуулснаас олсон нийт орлогын 50-иас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлж, энэ орлогыг ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бусаар мод бэлтгэхийг таслан зогсоох, хяналт тавих, ойг нөхөн сэргээх, нутгийн хөгжлийг дэмжихэд зарцуулах” гэсэн байна.

Нутгийн удирдлагаас нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нь хяналт тавих, нөхөрлөлийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган ажиллах хэрэгтэй юм. Иргэдийн оролцоотойгоор нутаг орныхоо байгалийг хамгаалах, унаган төрхийг нь хадгалах, ховор ургамал, ан амьтан тоо, төрлийг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих зэрэг олон

талын ач холбогдолтойг анхаарч ажиллах нь чухал юм.

Дүгнэлт

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн статусыг тодорхой болгох, нөхөрлөлийн санхүүгийн тогтвортой механизмыг бий болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэхэд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

1.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд нь Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу байгуулагдсан иргэдийн сайн дурын байгууллага хэлбэртэй байгаа одоогийн тогтолцоо нь зах зээлийн харилцаанд оролцох, банкны данстай байх, захиалгат ажил, үйлчилгээ үзүүлэх, төсвийн байгууллагаас шилжүүлэг хийх, худалдан авах ажиллагаанд оролцох, байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос хувь хүртэх зэрэг санхүүгийн аливаа үйл ажиллагаа явуулах боломж бүрдэхгүй байна. Иймээс нөхөрлөлийг Иргэний хуулийн 25.1, 36.1, 36.4-д заасны адил холбоо, хоршоо, төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага хэлбэрээр хуулийн этгээд болгон өөрчлөх;

2.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, түүний статусыг тодорхой болгох, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрийнхээ байгалийн нөөцийг давуу эрхтэйгээр ашиглах, байгаль хамгаалахад зарцуулсан зардлыг байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос буцаан олгох зэрэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэгдсэн зохион байгуулалт салбар дундын удирдлагаар хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж байх;

4.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн дүрэм, хамтын ажиллагааны гэрээг Иргэний хуульд нийцүүлэн боловсронгуй болгож гишүүнчлэл, хувь хөрөнгө оруулах, хариуцан хамгаалах байгалийн нөөцтэй холбогдох үйл ажиллагааг төрлөөр нь тодорхой болгох, хариуцан хамгаалах дэглэмийг тогтоож мөрдүүлэх нь чухал байна.

....оОо...

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль

1.Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

2.Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020 он "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн

3.Төрийн албаны тухай хууль 2017 он "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн

4.Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль 2011 он "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2011 оны 26 дугаарт нийтлэгдсэн

5.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмын тухай хууль Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2020 оны 21 дүгээрт нийтлэгдсэн

7.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 1996.08.27

8.Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2007.01.18

9.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 2012.04.27

10.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 2012.09.14

11.Сонгуулийн тухай хууль 2015.12.15 "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2016 оны 04 дугаарт нийтлэгдсэн

12.Ашигт малтмалын тухай хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн

13."Нийтийн сонсголын тухай хууль" 2015 он "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2015 оны 29 дүгээрт нийтлэгдсэн

14. Монгол Улсын Их Хурлын тухай хууль" Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн

15."Байгаль орчныг хамгаалах тухай хууль" Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1995 оны 5.6 дугаарт нийтлэгдсэн.

16."Газрын тухай хууль" 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

17."Ойн тухай хууль" 2012 он Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

18."Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль" Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017 оны 09 дүгээрт нийтлэгдсэн.

19."Малын тоо, толгойн албан татварын тухай хууль" Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2020 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

20.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"

21.Оросын Холбооны Улсын хууль 2003.10.06 «Об общих принципах организации местного самоуправления в Российской Федерации» (принят ГД ФС РФ 16.09.2003) // Собрание законодательства РФ", 06.10.2003, N40, ст. 3822.

22."Журам батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоол

23."Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийн шинэчилсэн найруулга батлах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 03.27-ны өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт

Хоёр. Ном, гарын авлага

1."Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал" товхимол II Улс төрийн боловсролын академи 2000 он

2."Децентрализация государственной власти и местное самоуправление: проблемы реализации" Москва издательство РАГС 2007

3.Б.Чимид "Концепция государственного устройства и местного самоуправления в Конституции Монголии" Москва издательство РАГС 2007

4.О.Тунгалаг "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал-түүнтэй холбоотой зарим асуудлууд" 2012

5."Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" танилцуулга 2000

6."Монгол Улсад нутгийн өөрөө удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь" Сургалтын гарын авлага 2003

7.Монгол Улсад нутгийн өөрөө удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь" Сургалтын гарын авлага 2015

8.Орон нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Харти 1985

9.“Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан” “Эм Эм Си Жи” ХХК-аас хийсэн судалгаа 2019 он

10.“Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намын оролцоо, үүрэг, нөлөө, гишүүдийн орон нутгийн хуралд нэр дэвших эрх, улс төрийн намуудын гишүүнчлэлийн тухай” Улсын Их Хурлын Тамгын газар судалгааны төвөөс 2012 онд хийсэн харьцуулсан судалгааны тайлан

11.“Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгааны тайлан” НҮБХХ-ын “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь.” төслийн ММСГ компаниас хийсэн судалгааны тайлан 2015

12.Хусейов.Р.Р.”Выдвижение и регистрация кандидатов на выборах в органы местного самоуправления: Зарубежный опыт для России” Вестник ПАГС

13.С.Батболд “Орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал” УБ-2010
С.Батболд “Орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал” УБ -2010

14. Д.Дондог, О.Тунгалаг “Нутгийн удирдлага-эрх зүйн шинэчлэл” УБ- 2007

15.Я.Долгоржав “Нутгийн өөрөө удирдах ёсны хөгжил, туршлага, хандлага” УБ-2000

16.”Тунгаамал төв” ТББ “ИТХ-аас бодлогын баримт бичиг боловсруулахад анхаарах зарим асуудлууд” гарын авлага УБ 2016

17.”Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал тэдгээрийн бие даасан, хараат бус байдлын талаар харьцуулсан судалгаа” Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны төвөөс 2015 онд хийсэн судалгааны тайлан

18. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” УБ 2018

20.”Хууль тогтоомжийн тухай хууль –аргачлал, гарын авлага” Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы хамтын ажиллагаа төсөл 2016 он

21.”Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сайн туршлагууд 2017-2019” khural.mn цахим хуудас